



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

Тогтвортой бичил уурхай төсөл

4 дэх үе шат, 2015 - 2018 он



ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

Тогтвортой бичил уурхай төсөл

4 дэх үе шат, 2015 - 2018 он



УУЛ,
УУРХАЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Хэрэгжих хугацаа: 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс 2018 оны 12 дугаар сарын 31
Монгол Улс

Төлөвлөлтийн багийн боловсруулсан эцсийн хувилбар
2014 оны 9 дүгээр сарын 30

Агуулга

	Товчилсон үгсийн жагсаалт	6
1.	Нэгдсэн хураангуй	8
2.	Нөхцөл байдал	11
2.1	Улс төр, макро-эдийн засгийн нөхцөл байдал	11
2.2	Бичил уурхайн асуудал орон нутгийн, үндэсний хэмжээнд болон төрийн бодлогын түвшинд	12
2.3	Дэлхий нийтийн чиг хандлага, сорилтууд ба олон улсын бодлого	13
2.4	Асуудлын дүн шинжилгээ	15
2.5	Оролцогч талууд – өөрчлөлтийн хөдөлгөгч хүч ба саад тотгор	16
3.	Үр дүн ба авсан сургамж	18
3.1	Өмнөх үе шатны гол үр дүн ба бүтээгдэхүүн	18
3.2	Дунд шатны үнэлгээний зөвлөмж	19
3.3	Сургамж ба ТБУТ-ийн 4 дэх үе шатанд тусгасан нь	19
4.	Зорилго	21
4.1	Төслийн хамрах хүрээ ба бүрэлдэхүүн хэсгүүд	21
4.1.1	Мэдлэг хуваалцах бүрэлдэхүүн хэсгийн онцлог	22
4.2	Мэдлэгийн төв нь харилцан солилцох, дэмжих	24
4.3	Хөгжлийн зорилт ба ТБУТ-ийн 4 дэх үе шатны хүлээгдэж буй үр дүн	25
4.4	ТБУТ-ийн 4 дэх үе шатанд бий болох Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа	26
4.4.1	Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа	27
4.4.2	Бүрэлдэхүүн хэсэг 2-ын бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх	29
4.4.3	Бүрэлдэхүүн хэсэг 3-ын бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Мэдлэг, туршлага солилцох, БУ-н олон улсын бодлогын хэлэлцүүлэг	31
4.5	Зорилтот бүлэг ба тэдэнд хүрч ажиллах	33
4.6	Оролцооны түвшин	33
5.	Хэрэгжүүлэх стратеги	35
5.1	Төсөл хэрэгжүүлэх арга	35
5.2	Түнш байгууллагууд, тэдний үүрэг ба хариуцлага	36
5.3	Холбогдох талуудын хамтын ажиллагаа ба зохицуулалт	38
5.4	Өөрчлөлтийн хөдөлгөгч хүч ба саад тотгор	39
5.5	Тогтвортой байдал ба төсөл дуусгах стратеги	39
6.	Бүтэц, удирдлага, зохион байгуулалт	41
6.1	Байгууллагын бүтэц, улс орны тогтолцоо ба түншүүдийн үйл ажиллагаатай уялдуулах нь	41
6.1.1	Байгууллагын бүтэц ба хамтрагч байгууллагууд	41
6.1.2	Улс орны тогтолцоонд нийцүүлэн уялдуулах	42

6.2	Төслийн зохион байгуулалт ба удирдах механизм	43
6.2.1	Төслийн зохион байгуулалт	43
6.2.2	Төслийн Удирдах хороо	45
6.3	Түншүүдтэй хамтран ажиллах захиргааны зохицуулалт	45
6.4	Төслийн менежмент - үүрэг, хариуцах ажил, хариуцлага	45
6.4.1	Төслийн дээд удирдлага	45
6.4.2	Дунд шатны менежмент	46
7.	Хөрөнгө нөөц	49
7.5	Хөрөнгө нөөцийг тодорхойлох нь	49
7.6	Төсөвт оруулах хувь	49
7.6.3	Швейцарийн талаас оруулах хувь	49
7.6.4	Монголын талаас оруулах хувь	50
7.6.5	Гуравдагч талын оруулах хөрөнгө	50
7.7	Зардал-үр ашгийн дүн шинжилгээ	51
8.	Эрсдлийн дүн шинжилгээ	52
8.1	Тооцоолол ба эрсдэл	52
8.2	Эрсдлийг бууруулах стратеги	52
9.	Хяналт-шинжилгээ ба үнэлгээ	53
9.1	Хяналт-шинжилгээ ба төслийн дотоод менежмент	53
9.2	Үнэлгээ ба төслийн орчлын гадаад менежмент	54
	Хавсралт 1. Логик загвар	55
	Хавсралт 2. Төсөл/хөтөлбөрийн гол ажилтнууд, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт	75
	Хавсралт 3. Төсөл хэрэгжих газарзүйн байршил	80
	Хавсралт 4. Олон улсын БУ-н талаарх дэлгэрэнгүй үнэлэлт, дүгнэлт	81
	Хавсралт 5. Оролцогч талуудын дүн шинжилгээ	84
	Хавсралт 6 Шугаман логик загвар / Өөрчлөлтийн онол	85
	Хавсралт 7. ТБУТ-ийн 4 дэх үе шат ба ШХА-ийн Хамтын ажиллагааны зарчмын харьцуулсан дүн шинжилгээ	86

Товчилсон үгсийн жагсаалт

BGI	Better gold initiative буюу Илүү сайн алтны санаачлага	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
GIZ (ГОУ ХАА)	Германы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг	ДШҮ	Дунд шатны үнэлгээ
NTR	NTR Metals (компаний нэр)	ДЭМБ	Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага
PROMINES	БНКУ-ын Уул уурхайн салбарын бүтцийг шинэчлэх төсөл (Дэлхийн банк)	ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
Авст.ОУХА	Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг (одоо ГХХЯ)	ЗГХХК	Засгийн газар хоорондын хэлэлцээрийн комисс
АДРА	Адвентист хөгжил, туслалцааны агентлаг	ЗДТСХ	Засаглалыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах хөтөлбөр (ШХА)
АМГ	Ашигт малтмалын газар	ЭШЭК	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр, төрийг доромжилж, харьцаж шийтгэхийн эсрэг конвенци
АМНС	Ашигт малтмалын нэгдсэн санаачлага	ИНБ	Иргэний нийгмийн байгууллагууд
АМНТМИТ	Ашигт малтмалын нөөцийн тогтвортой менежмент төсөл	ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт
АӨАҮБХУОУК	Арьс өнгөөр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон улсын конвенц	КОУХА	Канадын Олон улсын хөгжлийн агентлаг
АС	Азийн сан	КХОАҮХ	Канадын Хөгжил дэх Олборлох аж үйлдвэрийн хүрээлэн
БНАКУ	Бүгд найрамдах Ардчилсан Конго Улс	МБУНДХ	Монголын Бичил уурхайн Нэгдсэн дээвэр холбоо
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БОХОУХ	Байгаль орчин ба хөгжлийн олон улсын хүрээлэн	МТ	Мэдлэгийн төв
БОХТОТ	"Байгаль орчны хамгаалахад талуудыг оролцуулах нь" төсөл	МХЕГ	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар
БУ	Бичил уурхай	МЭТББҮС	Монголын эмэгтэйчүүдийн ТББ-ын Үндэсний сүлжээ
БУБ	Бичил уурхайн байгууллага	НДЕГ	Нийгмийн даатгалын Ерөнхий газар
БУ-ХБЭТ	Хөтөлбөр: Тусгай хамгаалалттай газар нутаг дахь бичил уурхай ба эмзэг экосистем	НҮБАҮХБ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага
БХОУЗ	Байгаль хамгаалах олон улсын зөвлөл	НҮББОХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр
ГХХЯ	Австралийн Гадаад харилцаа, худалдааны яам (хуучнаар Авст.ОУХА)		
ДЗ	Дэлхийн зөн		

НҮББХЭСЗ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Бизнес ба Хүний эрхийн суурь зарчмууд	УУАА	Уул уурхайн аврах алба
НҮБХС	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан	УУЯ	Уул уурхайн яам
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр	ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ОНБУ	Олон нийт ба бичил уурхай	ХХСАБЭОУК	Хүнийг хүчээр сураггүй алга болгохын эсрэг олон улсын конвенци
ОТХБ	Олон талт хөгжлийн байгууллага	ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци (Дэлхийн банк)	ХБИЭХК	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай конвенци
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага	Холбоо	Монголын Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо
ОУИТБС	Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлага	ХУУХ	Хариуцлагатай уул уурхайн холбоо
ӨАХН	Өмнөд Африкийн Хөгжлийн нийгэмлэг	ХҮЭЗ	Хариуцлагатай Үнэт эдлэлийн зөвлөл
СХХ	Сорьцын хяналтын хэлтэс (Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн газрын дэргэдэх Сорьцын хяналтын хэлтсийн Үнэт металлын сорьцын лаборатори)	ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
СЯ	Сангийн яам	ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенци
Т6	Тэрбум	ХЭСХ	Хүний эрхэд суурилсан хандлага
ТБ	Төрийн байгууллага	ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ТББ	Төрийн бус байгууллага	ХЯ	Хөдөлмөрийн яам
ТБУТ	"Тогтвортой бичил уурхай" төсөл	ЦАЭХК	Цагаач ажилчдын эрхийг хамгаалах тухай конвенци
ТЗН	Төслийн зохицуулах нэгж	ШФ	Швейцарь франк
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт	ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ТОМ	Төслийн орчлын менежмент	ШХАГ	Швейцарийн хамтын ажиллагааны газар
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж	ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пакт
ТХУ	Том хэмжээний уурхай	ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
УБ	Улаанбаатар	ЭМСЯ	Эрүүл мэнд, Спортын яам
УМОУЗ	Уурхай ба металлын Олон улсын зөвлөл	ЭЯГБХУК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци

1. Нэгдсэн хураангуй

Монгол Улс 1990-ээд оноос олон намын тогтолцоо бүхий ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш эдийн засаг их хэмжээгээр өссөн. Энэ нь голчлон урьдчилан хараагүй уул уурхайн салбарын хөгжилтэй холбоотой бөгөөд арван жилийн хугацаанд нэг хүнд ногдох ДНБ бараг 10 хувиар нэмэгдэж, уул уурхайн салбарын экспортын эзлэх хэмжээ 2 дахин нэмэгджээ. Гэвч, эрдэс баялгийн талаарх бодлогын өөрчлөлт, энэ салбарын бараа бүтээгдэхүүний үнэ буурсан нь Монгол Улсын эдийн засаг дахин унах эрсдэлтэй тулгараад байна.

Бичил уурхай (БУ) нь амь зуух чухал стратегийг бий болгодог ч нийтийг хамарсан тэгш бус байдал, нийгмээс тусгаарлагдах, хүний эрхийн зөрчил зэргээс шалтгаалан томоохон хүндрэлтэй тулгарсан. Монгол Улсад бичил уурхай эдийн засгийн шилжилт, байгаль цаг уурын гамшгаас шалтгаалан ядуурал, ажилгүйдэл нүүрлэсэнтэй холбоотойгоор 10 гаруй жилийн өмнөөс эхэлсэн. 2005 онд Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) (Эхний үе шат) хэрэгжиж эхлэх үед өмнө нь ихэвчлэн малчид байсан 100000 гаруй уурхайчид болон нийт хүн амын 15 хувь шууд бус байдлаар энэхүү үйл ажиллагаанаас хамааралтай байв. Гэвч, нийгэм бүхэлдээ БУ-г аюултай арга, байгаль орчинд хор нөлөө учруулдаг, татвараас зугтаадаг, хууль бусаар ашигт малтмалын худалдаа хийдэг, аюултай нөхцөлд ажилладаг, нийгмийн хамгаалалд бараг хамрагддаггүй зэрэг олон сөрөг асуудал дагуулсан түр зуурын үйл ажиллагаа гэж үзэж байв. Үүнээс шалтгаалан бичил уурхайд ажиллаж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд мөн түүнчлэн ахимаг насны хүмүүсийн эрхийг зөрчих, олон нийтийн эсэргүүцэл, дарамт бий болсон.

БУ-г албан ёсны эдийн засагтай уялдуулах, БУ-аас хөгжилд оруулж буй хувь нэмрийг

нэмэгдүүлэх талаар томоохон ахиц, үр дүн гарсан. 2009 онд хийгдсэн ТБУТ-ийн 2 дахь үе шатны Дунд шатны үнэлгээгээр энэ төслийг Монгол Улсын хөгжилд хэрэгтэй, хүн амын тодорхой хэсгийн хувьд маш чухал гэж дүгнэсэн. Үүний дараахан, 2010 оны 7 дугаар сард ТБУТ-ийн дэмжлэг, нөлөөллийн үйл ажиллагааны дүнд бичил уурхайн асуудлаарх анхны эрхзүйн орчин бий болж, энэ салбарыг албажуулах үндсийг тавьсан бөгөөд 2011-2014 онд хэрэгжих ТБУТ-ийг (3 дахь үе шат) БУ-н бодлогын бүрэлдэхүүн хэсэг ба Бичил уурхайчдыг дэмжих бүрэлдэхүүн хэсэг гэсэн хоёр чиглэлээр хэрэгжүүлэх болсон. Өнөөдөр, мянга мянган уурхайчид орон нутгийн БУ-чдын байгууллагын хүрээнд албан ёсоор хөдөлмөр эрхэлж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байна. Байгаль орчны нөхөн сэргээлт, ажлын байрны аюулгүй ажиллагаа, орон нутгийн хөгжилд илүү их хувь нэмэр оруулах зэрэг сайн туршлагууд бий болж байна. БУ-н Дээвэр Холбоо улам бүр хүчтэй болж, уурхайчдын эрхийг үр дүнтэй хамгаалан нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байна. БУ-н тасгийг Ашигт малтмалын газарт байгуулсан бөгөөд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал хариуцсан салбарын яамдын зүгээс БУ-н асуудалд анхаарах явдал сайжирсан. Хамгийн гол нь БУ-н талаарх олон нийтийн болон улс төрчдийн хандлага ихээхэн сайжирч байна.

Сүүлийн үед гарч буй өөрчлөлт шинэчлэл нь тогтвортой БУ-н тогтолцоог бүрдүүлж буй ч энэ салбарын хөгжлийн боломжийг бүрэн илэрхийлэхийн тулд байнга гарч байдаг хүний эрхийн асуудал, нийлүүлэлтийн албан бус сүлжээний асуудлыг шийдэх шаардлагатай. Эрдэс баялагийн талаар төрөөс баримтлах бодлого (2014-2025)-д Ашигт малтмалын тухай хууль (2014)-д нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэх замаар уул уурхайн салбарыг дахин сэргээхээр тусгагдсан

нь тогтвортой БУ-г цаашид хөгжлийн өөр түвшинд гаргаж болох юм. Алтны худалдааг албажуулахтай холбоотой хуулийн заалтууд нь БУ-аар нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд ажлын байрыг бий болгох, валютын арилжаанаас олох орлогыг нэмэгдүүлэх, мөнгөний ханшны уналтыг зогсоох, макро эдийн засгийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх, улс орны хөгжлийг урагшлуулах бас нэг өөр боломжийг бий болгож байна. Хэдийгээр олон ахиц, үр дүн гарсан ч Төслийн 3 дахь үе шат дууссаны дараа үр нөлөөний үр шимээс хүртэгсэд нь харьцангуй хязгаарлагдмал байх ба одоо албан бус, зохион байгуулалтгүй байдал, ажлын байран дахь аюултай нөхцөл байдал, бусад салбарт хор нөлөө үзүүлж буй байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг шийдэхэд Засгийн газар гол үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Түүнчлэн, үр дүнг тогтвортой байлгахад мөлжлөг, муу үйлчилгээ, жендэрийн асуудалд ялгавартай хандах, үүрэг хүлээгчдийн ажил үүргээ гүйцэтгэх чадавх, эрх эдлэгчдийн эрхээ шаардах чадавх сул байгаа зэрэг нь сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна.

ТБУТ (4 дэх үе шат) нь Дунд шатны үнэлгээнд гарсан дээрх дутагдлыг арилгаж, Монгол Улсыг БУ-н сайн туршлагын мэдлэгийн олон улсын төв болгох асуудлыг хэрэгжүүлэхээр зорьж байна. Хөгжлийн зорилтыг "Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын БУ-н салбар нь бичил уурхайтай холбоотой олон улсын туршлагаас үр шимийг хүртэхийн зэрэгцээ өөрөө хувь нэмэр оруулах" гэж тодорхойлов. Энэ зорилтод хүрэх талаар тодорхой ахиц гаргахын тулд Төслийн 4 дэх үе шат нь дараах үр дүнтэй холбоотойгоор хоорондоо уялдаа бүхий 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

- **Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба бичил уурхайчдыг дэмжих үйл ажиллагаа:** БУ-н оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр Хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын бичил уурхайн бүх үйл ажиллагаа, асуудалд тусгасан байна.
- **Нийлүүлэлтийн албан ёсны сүлжээнд оролцогч талуудын эдийн засгийг бэхжүүлэх:** Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор БУ-аар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна.

- **Мэдлэг хуваалцах ба БУ-н талаар дэлхийн хэмжээний бодлогын хэлэлцүүлэг:** Монгол Улсын оролцогч талууд БУ-тай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь БУ-н салбарт олон улсын түвшинд манлайлагч байна.

ХЭСХ-ыг хэрэгжүүлснээр эрх эдлэгчдийг эрх мэдэлжүүлж тэд өөрсдийн эрхээ шаардах эрх мэдлийг сайжруулан, үүрэг хүлээгчдийн үүргээ биелүүлэх чадавх сайжирна. Хэрэгжүүлэх стратеги нь үүрэг хүлээгч ба эрх эдлэгчдийн асуудлыг тусгана. Үүрэг хүлээгчдийн хариуцлагыг сайжруулснаар БУ-чдыг албажуулах, сайн туршлага хэрэгжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх тэдний үүргээ биелүүлэх чадавхи тодорхой нэмэгдэнэ. БУ-н Дээвэр холбоо, иргэний нийгмийн гол байгууллагуудын эрх мэдлийг сайжруулах нь ТБУТ-ийн гүйцэтгэж буй үүргийг эрх эдлэгчдэд шилжүүлэхэд хүргэнэ. Гол асуудлуудын хувьд ахиц гаргаснаар төсөл микро (орон нутгийн) түвшинд шууд оролцдог байдлаас аажмаар нөөц бололцоог месо (засгийн газар, Дээвэр холбоо) түвшинд байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд ашиглах, макро түвшинд бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, мета түвшинд мэдлэг хуваалцдаг болох нөхцөлд шилжих юм.

ТБУТ-ийн 4 дэх үе шат нь түнш болон хамтран ажиллагч талуудтай болон тэдний хоорондын зохицуулалтын хувь одоогийн байр суурь, механизм дээр тулгуурлан хэрэгжинэ. Төсөл БУ-н хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хороо зэрэг өнөөгийн тогтолцоонд гол үүргээ биелүүлэхэд нь үндсэн хамтран ажиллагч байгууллага болох Уул уурхайн яам (УУЯ), Ашигт малтмалын газар (АМГ)-ын БУ-н тасагт дэмжлэг үзүүлж ажиллана. Төсөл нь Хөдөлмөрийн яам (ХЯ), Эрүүл мэнд, спортын яам (ЭМСЯ), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ), Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК) зэрэг БУ-н талаар хамтран ажилладаг гол түнш байгууллагуудаар дамжуулан орон нутгийн удирдлагуудыг оролцуулах замаар орон нутгийн түвшинд үүрэг хүлээгчдийн үүрэг ролийг бэхжүүлэхэд өнөөгийн зохицуулалтын босоо механизмыг ашиглана. ТБУТ хэрэгжиж дууссанаас хойш орон нутгийн хэмжээнд үзүүлэх үр нөлөө, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор өсөн нэмэгдэж буй хамтрагчдын тоог нэмэгдүүлнэ.

Төслийн бүтэц нь эхлээд хэрэгжүүлэх үүргээ, улмаар зохицуулалтын ихэнх чиг үүргээ үүрэг хүлээгчдэд шилжүүлэн өгөх Төслийн

зохицуулах нэгж (ТЗН)-тэй байна. Төслийн зохицуулах нэгжийг Төслийн захирал, Төслийн Үндэсний зохицуулагч удирдах ба нэгжийн гол үүрэг нь УУЯ, АМГ болон холбогдох бусад байгууллагуудтай шууд хамтран ажиллаж үйл ажиллагааны зохицуулалтад дэмжлэг үзүүлж ажиллана. Төслийн Олон улсын захирлын ажил хоёр жилийн дараа дуусах боловч төсөл хэрэгжих 3-4 жилийн хугацаанд Олон улсын зөвлөх төслийн менежментэд дэмжлэг үзүүлэх, техникийн зөвлөгөө өгөх замаар олон улсын ноу-хау, техник туслалцаа үргэлжлэх юм. Дунд шатны менежмент нь БУ-н талаар мэдлэг туршлагатай, төсөл хэрэгжүүлэгч талуудтай тулж ажиллах “үйл ажиллагааны менежер” болох мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Төслийн үйл ажиллагаанд үүрэг хүлээгчид болон эрх эдлэгчдийн гол шийдвэр гаргагчдаас бүрдсэн Удирдах хороо хяналт тавьж ажиллана.

Төсөл өөрөө хэрэгжүүлдэг хэлбэрээ өөрчилж байгаатай холбоотойгоор мониторинг хийх ажил чухал болж байна.

Төслийн түвшинд мониторинг хийх гол этгээд нь ТБУТ-ийн менежментийн удирдлага байна. Үйл ажиллагааны менежерүүд нь түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх болон тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны мониторингийг хариуцна. Дунд шатны дотоод үнэлгээг хэрэгжилтийн 2 дахь жилд хийх бол хөндлөнгийн үнэлгээг 2018 оны дараа 2 жилийн хугацаатай хэрэгжих төгсгөлийн буюу шилжүүлэн өгөх үе шатны төлөвлөлтийн нэг хэсэг болгон хийнэ.

Төсөл нь **Монгол болон Швейцарь** Улсуудын хамтын ажиллагаа байх бөгөөд энэ утгаараа аль аль талаас хөрөнгө оруулна. Швейцарийн тал төслийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхэд 6 сая Швейцарь франк (ШФ)-ийн хөрөнгө оруулалтыг хийнэ. Монгол Улсын талаас оролцогч талууд, орон нутгийн захиргаа, үр шимийг хүртэгчдийн оруулж буй хөрөнгөөс бүрдсэн 1.04 сая ШФ-тай тэнцэх хэмжээний хөрөнгийг оруулж байна. Төслийн хамтран хэрэгжүүлэгчид оруулж буй хөрөнгөө тус тусын захиран зарцуулах дүрэм, журмын дагуу өөрсдөө хариуцан зарцуулна.

2. Нөхцөл байдал

2.1 Улс төр, макро-эдийн засгийн нөхцөл байдал

1990-ээд оноос олон нам бүхий ардчилсан нийгэмд шилжиж эхэлснээс хойш, уул уурхайн салбарыг хөгжүүлж, Монгол Улс дэлхийн эдийн засгийн хамгийн хурдацтай хөгжил бүхий улсын нэг болсон. 2.95 сая хүн ам 1.56 сая хавтгай дөрвөлжин газар нутагт оршин суух Монгол Улс нь дэлхийд хүн амын нягтшил хамгийн бага улсуудын нэг юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай социалист системээр 70 жил замнасны дараа, хагас нүүдэлчин малчид бүхий тус улс 1990-ээд оны эхээр барууны олон намын систем, зах зээлийн эдийн засагт шилжсэн. Төрийн өмчит үйлдвэрүүд ихэнх нь дампуурч, эдийн засаг унасны дараа Монгол Улс ашигт малтмалын баялгаа ашиглан түргэн хугацаанд эргэн сэргэжээ. Эрдэс баялгийн том орд газрууд ашигт малтмалын үйлдвэрлэлийн салбарт гадны хөрөнгө оруулалтыг татаж, бичил уурхай эрчимтэй эхэлж, 100,000 гаруй Монголчууд БУ эрхлэн ядуурлаас гарахыг хүссэн. Урьдчилан тооцоолоогүй байсан уул уурхайн салбарын огцом өсөлтөөс улбаалан нэг хүнд ногдох ДНБ 2002 онд 460 ам.доллар байснаа 2013 онд 3,971 ам.доллар болон өсчээ. Мөн хугацаанд улсын нийт экспортод ашигт малтмалын бүтээгдэхүүний эзлэх хувь 33%-аас 82% болж өсөв.¹

Ашигт малтмалд суурилсан эдийн засгийн өсөлт нь өндөр эрсдэл дагуулж байна. Монгол Улсын ашигт малтмалд суурилсан эдийн засгаас хамаарсан байдал нэмэгдэж болзошгүй. Дэлхийд зэсийн олборлолтоор хоёрт орох Оюу толгойн орд бүрэн ашиглалтад орсноор дангаараа улсын хэмжээнд ДНБ-ий гуравны нэгийг бүрдүүлнэ гэж тооцоолж байна.

Гэвч, гэнэтийн ашгийн татвар¹ гэх мэт татварын таатай бус тогтолцоо, "урт нэртэй" гэх хуулийн дагуу гол мөрний эх газар дахь олборлолтын лицензийг хүчингүй болгосон, 2010 оноос хойш шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зогсоосон, Оюу толгойн асуудлаар Рио Тинто компанитай хийж буй урт хугацааны маргаан зэрэг нь Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг ихээхэн бууруулаад байна.² Ашигт малтмалын үнэ буурсан, Хятад Улсын эрэлт хэрэгцээ багассан, аль хэдийн шинж тэмдэг нь илрээд буй "Голланд өвчин"³ зэргээс шалтгаалан Монгол Улсад дахин эдийн засгийн хямрал нүүрлэх өндөр эрсдэл бий болоод байна. Уул уурхайгаас орж буй төсвийн орлого энэ онд 44 хувиар⁴ буурсан мэдээлэл байна.

Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах шинэ бодлого (2014-2025)-д илүү тогтвортой эрх зүйн орчинг бүрдүүлэхээр зорьж буй. Уул уурхайн салбарыг Монголын эдийн засгийн гол тулгуур болгон дахин идэвхжүүлэх зорилгоор Төрөөс Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг анх удаа 2014 оны 1 дүгээр сард Монгол Улсын Их Хурлаас 86 хувийн дийлэнх олонхийн саналаар баталсан. Энэхүү бодлогод бичил уурхайн талаар "3.1.2 дугаар зүйлд Төрөөс бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны

1 Монгол Улсын Татварын Ерөнхий газар. <http://www.customs.gov.mn/statistics>

2

3 Behre Dolbear жагсаалтаар Монгол Улс 2011/2012 онд 12-т жагсаж байснаа одоогийн байдлаар 24-т жагсах болов.

Мэдээлэл: 2011 онд 12-т (34.0 оноо); 2012 онд 12-т (32.0 оноо); 2013 онд 19-т (26.9 оноо) 2014 онд 24-т (21.5 оноо). <http://www.dolbear.com/news-resources/press-releases>

4 "... байгалийн нөөцийн эдийн засгийн хөгжлийн өсөлт болон аж үйлдвэрийн салбарын(эсхүл хөдөө аж ахуйн) уналтын хоорондын илт хамаарал. "http://en.wikipedia.org/wiki/Dutch_disease

бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг бодлогоор дэмжиж, холбогдох эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох" гэж тусгасан байна. Тус заалт нь БУ-н үйл ажиллагааг уул уурхайн жижиг аж ахуйн нэгж болгон хөгжүүлэх талаарх Монгол Улсын дунд болон урт хугацааны бодлогыг тусгаж байгаа юм.

2.2 Бичил уурхайн асуудал орон нутгийн, үндэсний хэмжээнд болон төрийн бодлогын түвшинд

Бичил уурхай (БУ) нь хөдөөгийн иргэдэд амьжиргаагаа залгуулах, орлого олох боломж олгодог ядуурлаас үүдэлтэй үйл ажиллагаа. Монголын БУ нь алт, нүүрс, жонш болон бусад ашигт малтмалын хайгуул, олборлолт, баяжуулалт, тээвэрлэлтийн энгийн хэлбэрийг гол төлөв хамарсан албан болон албан бус үйл ажиллагаанаас бүрдэнэ. Энд хувиараа, гэр бүлээрээ, бүлгээрээ эсхүл нөхөрлөл байдлаар ажиллах эрэгтэй, эмэгтэй, залуучууд, ахмад настанууд багтаж байна. 1990-ээд оны сүүл, 2000 оны эхээр болсон эдийн засгийн шилжилт, цаг уурын хүндрэлтэй нөхцөлөөс болж ажилгүйдэл газар авч, мал сүргээ ихээр алдсантай холбоотойгоор Монгол Улсад БУ бий болжээ. ТБУТ 2005 онд хэрэгжиж эхлэх үед БУ-н дэд салбар нь ихэвчлэн малаа алдсан малчин өрхүүд амь зуухын эрхээр ажиллаж эхэлсэн 100,000 гаруй бичил уурхайчдад албан бус хөдөлмөр эрхлэх боломжийг олгож, улмаар 400,000 гаруй (нийт хүм амын 15% орчим) Монголчуудыг шууд бус байдлаар тэтгэж байв. БУ дахь эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн харьцааны хувьд 19.4 –

өөс 40-50 хүртэлх хувь нь эмэгтэйчүүд байх ба тэдний ихэнх нь алтны шороон ордод ажилладаг байна. Ядуурал их байгаа, ижил тэгш бус боломж, тусгаарлагдан орхигдсон байдал зэрэгтэй холбоотойгоор, албан бус уурхайг ерөнхийд нь аюултай нөхцөлд ажилладаг, байгаль орчинд хор хөнөөл учруулдаг, газар эзэмшигч болон эрх бүхий байгууллагуудтай маргаантай, хүний эрхийг хөсөрдүүлдэг гэж үздэг байв. Өнөөдөр БУ нь орон нутгийн болон улс орны эдийн засагт хувь нэмэр оруулахын хамт амь зуух, ядуурлыг бууруулах нэг чухал стратеги байсаар байгаа боловч энэ нь төдийлөн мэдэгдэхгүй байна. Орон нутгийн түвшинд БУ-г албажуулах явдалд ахиц гарч, уурхайчдаас орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд оруулж буй хөрөнгө нэмэгдэж, шууд байдлаар ажлын байр бий болгон, хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг сааруулахын зэрэгцээ өрхийн бэлэн мөнгөний орлогыг нэмэгдүүлж байна. Макро түвшинд, БУ-аар олборлосон алт гадаад валютын орлогыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, төв банкны арилжаагаар инфляцийг бууруулах, макро эдийн засгийг тогтворжуулах, улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд дэмжлэг болох нэн бололцоотой юм.

Олон жилийн турш үргэлжилсэн хэлмэгдүүлэлт, хүний эрхийн зөрчлийн дараа Монголд бичил уурхайчид албан ёсны эдийн засагт нэгдэх, өөрсдийн эрхийг хамгаалах талаар томоохон ахиц, үр дүнд хүрсэн. Арав гаруй жилийн өмнө үүсч бий болсон БУ-г олон нийтийн зүгээс эсэргүүцэн түр зуурын зохисгүй ажиллагаа гэж үздэг байсан ба бичил уурхайчдыг хууль бусаар хорьж цагдах, биеийн болон бэлгийн хүчирхийлэлд



өртөх, нийгэм халамжийн үндсэн үйлчилгээ хүртэх боломжгүй байх зэргээр “нинжа” уурхайчдын хөдөлмөрийг мөлжих, эрхийг зөрчих явдал их байв. Эдгээр нөхцөл нь бичил уурхайчдыг нийгмээс тусгаарлах явдлыг улам бүр нэмэгдүүлж байсан ч 2010 оны 7 дугаар сард бичил уурхайн анхны эрхзүйн орчинг баталснаас хойш олон нааштай өөрчлөлт гарч байна. 4,500 гаруй бичил уурхайчид бүртгэлгүй нөхөрлөл, БУ-н ТББ-д нэгдсэн ба тэдний ихэнх нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байна. Байгаль орчны нөхөн сэргээлт, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сайн туршлагууд бий болж, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр ихэсч байна. БУ-н Дээвэр Холбоо уурхайчдын эрхийг хамгаалах талаар хүчтэй, үр дүнтэй ажиллах болов.

БУ-н талаарх олон нийтийн болон улс төрийн үзэл бодол аажмаар эерэг болж өөрчлөгдөхөд ТБҮТ-өөр дамжуулан ШХА-аас явуулж буй нөлөөллийн үйл ажиллагаа ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. АМГ-т БУ-н тасаг байгуулсан, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн захиргааны эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөн (2010) болон ХЯ, ХАХНХЯ, ЭМСЯ-наас хүчтэй дэмжиж ажиллах болсон зэргээр байгууллагын хэмжээнд арга хэмжээ авах замаар илүү чухал үр дүнгийн суурь тавигдаж байна. БУ-н хувьд гэмт хэрэг, хууль зөрчих асуудал гарсаар байгаа, нийгмийн үйлчилгээ хүргэлт хангалтгүй, БУ-г илүү өргөн салбар болгон үйл ажиллагааг нь өргөжүүлэхтэй холбоотой төрийн гол байгууллагуудын чадавхи сул, БУ-н байгууллагуудын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зэрэг томоохон сорилтуудтай тулгарч байна. Эцэст нь, БУ-н баялаг бий болгох, нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан орон нутгийн болон улс орны эдийн засгийг хөгжүүлэх чадамжийг төдийлөн хүлээн зөвшөөрөхгүй байсаар байна.

Сүүлийн үед авч хэрэгжүүлж буй бодлогын өөрчлөлт шинэчлэл нь тогтвортой БУ-г дэмжих суурийг бүрдүүлж байна. Саяхан батлагдсан Төрөөс Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014-2025)-д БУ-н талаар нааштай заалтууд орсон бөгөөд БУ-н эрхзүйн тогтолцоог сайжруулах үндсийг тавьсан. БУ-г албажуулах явц нь орлогын өндөр татвар, БУ-аар ашиглах газар хязгаарлагдмал, улс төр эдийн засгийн өөрчлөлт, ашиг сонирхлын зөрчил, орон нутгийн нөөцийн маргаан, албан бус ашигт малтмалын зах зээлийн тогтолцоо зэрэг олон сорилтуудтай холбоотойгоор тодорхойгүй байсаар байна. Одоогийн байдлаар, үүрэг хүлээгчдийн хүлээж буй үүрэг хариуцлагыг хуульд тодорхой тусгаагүй нь зохицуулалт болон үйлчилгээнд сөргөөр нөлөөлж байна. Эдгээр сорилтууд нь Монгол

Улсын Засгийн газар болон БУ-н хийх томоохон ажил болж байна.

Алтны худалдааны асуудлаарх Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь БУ-г албан ёсны этгээд хэмээн хүлээн зөвшөөрсөн. Алтны хөтөлбөр, алтны худалдааны зохицуулах журмыг боловсруулж байна. Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хууль дахь БУ-тай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг 2014 оны 7 дугаар сард УИХ-аас баталсан ба БУ-н аж ахуйн нэгж байдлаар хөгжих боломжийг хүлээн зөвшөөрөх, газрын хүртээмжтэй холбоотой саадыг арилгах талаар ихээхэн ахиц гарсан. Тухайлбал, БУ-г өргөн хүрээний байгууллын хэлбэрээр (ж.н аж ахуйн нэгж, нэгдэл гэх мэт) хуульчилж болох ба УУЯ нь БУ-д тохирох газрыг тэмдэглэж тогтоох явдалд дэмжлэг үзүүлэхээр тусгагдсан. Үүнтэй холбоотой дагалдан гарах журмуудад оруулах нэмэлт, өөрчлөлт нь хүний эрх, жендэрийн орхигдсон асуудлыг тусгах, гол байгууллагын эрх үүргийг тодорхой болгох, саад бэрхшээлийг арилгах, салбарыг албажуулахад таатай орчныг бүрдүүлэх чухал боломжийг бий болгож байна.

2.3 Дэлхий нийтийн чиг хандлага, сорилтууд ба олон улсын бодлого

Дэлхий нийтийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээг, ашигласан ном, материалын хамт Хавсралт 4-д тусгав.

Уур амьсгалын өөрчлөлт, уламжлалт ахуй амьдралаар амьдрах боломжгүй болсон, эдийн засгийн шилжилт ба уналт, хямрал, ашигт малтмалын үнэ өссөн зэрэг нь дэлхийн хэмжээнд бичил уурхайчдын тоо 2 дахин нэмэгдэж, 30 сая болоход хүргэсэн. Дэлхийн БУ-н тал орчим хувь нь алт олборлож буй бөгөөд алтны салбарын хөдөлмөр эрхлэлтийн 90%-ийг эзэлж, дэлхийн алтны бүтээгдэхүүний 12-15 хувь, Швейцарьт цэвэршүүлж буй алтны гуравны хоёрыг эзэлж байна.

Хүний эрхийг хамгаалах асуудал нийтэд нь бүрэн шийдэхэд хол байгаа ч БУ-н салбарын засаглалын гол асуудал болох болов. Жон Рагги-ийн 2011 онд бичсэн Тогтолцоог хамгаалах, хүндлэх, засч сайжруулах болон НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмуудыг өөрсдийн үйл ажиллагаа нь гуравдагч этгээдийн эрхийг хэрхэн хөнддөг болохыг тусгахын тулд Монголын БУ-н байгууллагууд мөн хүний эрхийг хэрэгжүүлэхэд БУ-н салбарт дэмжлэг үзүүлэх ёстой Монголын төр аль аль нь анхааралтай судлах шаардлагатай.



НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмуудыг арга хэмжээ авах мандат хэмээн хүлээн зөвшөөрөх нь худалдан авагч компаниудыг БУ-аар олборлосон ашигт малтмалын хариуцлагатай эх сурвалжид илүү анхаарахад хүргэсэн. ЭЗХАХБ-ны Зохистой үйл ажиллагааны удирдамж зэрэг Нийлүүлэлтийн сүлжээний зохистой үйл ажиллагаа нь одоо ашигт малтмалыг тэр дундаа БУ-р олборлосон ашигт малтмалыг буруу ашиглахаас сэргийлэх норм, стандарт гэж үзэх болсон. Монгол Улс ТБУТ болон Байгаль орчныг хамгаалахад талуудыг оролцуулах нь (ESEC) төслүүдийн хүрсэн амжилтад тулгуурлан хариуцлагатай БУ болон БУ-г албажуулах талаарх сайн туршлага, сургамжийн сан, эх сурвалж болох боломжтой.

Алт олборлодог БУ-н байгууллагад гэрчилгээ олгох боломжтой Шударга худалдаа болон Шударга олборлолтын стандарт гэх мэт хариуцлагатай эх сурвалжийн бусад санаачлагууд нь Монголын БУ-н салбарт боломж бий болгоно. Шударга олборлолтын стандартын систем Монголд хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой. Хариуцлагатай Үнэт эдлэлийн зөвлөл (RJC)-ийн Үйл ажиллагааны дүрэм, Гарал үүслийг тодруулах стандартад БУ-н ашигт малтмалын хариуцлагатай эх сурвалж, гарвалын хувьд тавигдах шаардлагыг заасан. Швейцарийн Сайн алт санаачлага, Солидаритадын Алтны хөтөлбөр нь мөн БУ-н үйлдвэрлэгчдэд анхаарч ажиллаж байна.

БУ-н зохистой үйл ажиллагаа (Due diligence) нь зөвхөн БУ-аар олборлосон ашигт малтмалыг худалдан авагчын төдийгүй мөн том уурхайд хөрөнгө оруулагчдын ч анхаарах асуудал. Санхүүгийн хөрөнгө оруулагчид, аж үйлдвэрлийн нийгэмлэгүүд БУ-г том уурхайн компаний ашиг, уян хатан ажиллагааны чухал эрсдэл гэж үзэн анхаарах

болсон. Энэ нь том уурхайн компаниудыг өөрсдийн эзэмшлийн газар дээр БУ-тай үр дүнтэй хамтарч ажиллахыг дэмжиж байна. Ийнхүү ажиллахыг Монголд хуулийн дагуу дэмждэг.

Гэвч, сүүлийн арван жилийн хугацаанд эрэл хайгуул эрчимтэй хөгжсөн нь уул уурхайн компаниуд БУ-н ашигт малтмалын эрхийг үгүйсгэхэд хүргэсэн. БУ-чид өөрсдийн үйлдвэрлэлийн бүтээмж, зохион байгуулалт, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх муухан газарлуу шахагдаж ажиллах, дахин ур чадвар эзэмших шаардлагатай болдог. ОУСК-ийн Тогтвортой байдлын тогтолцоо нь уурхайчдын амьжиргааг хамгаалах гарааны цэгийг тодорхойлсон ч тэднийг үр дүнтэй хамруулан оролцуулах явдал хангалтгүй байсаар байна. БУ ба том хэмжээний уурхайн харилцааг зэрэгцэн орших бус харин хамтран ажиллах гэсэн утгаар авч үзэх нь чухал алхам бөгөөд Монгол Улс энэ талаар шинэ эхлэлийг тавьж байгаа.

Олон улсын хэмжээнд, БУ-н салбарыг албажуулах, мөнгөн усны хэрэглээг зохицуулах, устгах нь анхаарлын төвд байсаар байна. Хятад, БНАКУ, Мозамбик, Колумб, Перу зэрэг улсуудад сүүлийн үед авч хэрэгжүүлсэн эрхзүйн болон бодлогын үйл ажиллагаа нь харилцан хуваалцахуйц туршлага болж байна. Монгол Улсын нэгдэн орсон Минаматагийн конвенцийг 2013 онд баталсан нь БУ-г албажуулахад чухал алхам болсон. ШХА-ийн туршлага нь мөнгөн усны хэрэглээг халах явдлыг албажуулах талаар оролцогчдыг ятгахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Хүүхдийн хөдөлмөр, албадан ажиллуулах, жендэрийн тэгш бус байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл анхаарал татсан асуудал байгаа тул хариуцлагатай БУ нь олон улсын түвшинд хурцаар яригдаж буй асуудал байсаар байна. Барууны хууль

тогтоомж, хэвлэл мэдээллийн боолчлол, хүний наймааны асуудалд тавьж буй анхаарал өөрчлөгдөн, ТББ, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд БУ-г хамгаалалтын бүсэд хэрхэн явуулах, БУ-н салбарын жендэрийн асуудал, үр ашгийн талаар анхаарах болсон.

2.4 Асуудлын дүн шинжилгээ

Тогтвортой, албан ёсны БУ-г бий болгох явц үр дүнтэй ч удаан, эмзэг байна. Хүний эрхэд суурилсан хандлагыг (ХЭСХ) эрхзүйн болон бодлогын түвшинд хангалтгүй хэрэглэж буй нь бичил уурхайчдыг хууль биелүүлэхийг шаарддаг ч төрийн зүгээс уурхайчдын хүний эрхийг хангах талаарх үүргээ ойлгодоггүй эсхүл үл ойшоодог, засгийн газар болон уул уурхайн компаний хоорондын маргаанд уурхайчид их хэмжээгээр өртдөг байдал хэвээр байсаар байна. Үүнийг улс орны хэмжээнд дагаж мөрдөх, нийтлэг, олон улсын болон эрхзүйн үүрэг хариуцлагын талаас авч үзээгүйгээс БУ-чдын эрхээ эдлэх асуудал, албажуулалтын талаар бий болгосон амжилт нь гагцхүү тэдний үйл ажиллагаагаар бүрэн тодорхойлогдож байна. Бичил уурхайчдын дийлэнх нь нийгмээс тусгаарлагдсан, мэдлэг ур чадвар муу, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нөөц бололцоо хангалтгүй байсаар байвал нөхцөл байдал удаан, эмзэг байна гэж үзэж байна. БУ-н нөхөрлөлүүд бизнес нэгж (ажилчид авч ажиллуулах зэргээр) болсноор НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн асуудлаар баримтлах зарчмууд нь (албан ёсны уул уурхайд хэрэгжүүлдэг) БУ-д мөн хамааралтай болно.

БУ-аас олж болох үр ашиг нь орон нутгийн болон үндэсний хэмжээнд алдагдаж байна.

Бодит байдал дээр албан ёсоор ажиллаж буй бичил уурхайчид хүртэл гэмт хэрэгт өртөх, хар захад худалдах зэргээр алтаа хуулийн дагуу борлуулж чаддаггүй. Олборлосон бүтээгдэхүүнийг нээлттэй арилжаалах боломжгүй нөхцөлд орон нутгийн болон үндэсний хэмжээнд олж болох эдийн засгийн үр ашиг бага байна. Монгол банкны албан ёсны алтны үнэ нь дэлхийн зах зээлийн үнэтэй ойролцоо байдаг ч борлуулах үйл явц БУ-чдын хувьд хэт төвөгтэй байдаг. Алтаа хар зах дээр борлуулах нь ашигт малтмалын салбарын ил тод байдлыг бууруулж, уурхайчид, орон нутгийн бизнес эрхлэгчид, орон нутгийн захиргаа болон Төр хүртэл гадаад валютын орлогоо нэмэгдүүлэх, инфляцыг бууруулах, макро эдийн засгийг тогтворжуулах, улс орноо хөгжүүлэх тодорхой боломжийг алдаж байна гэсэн үг.

Монголын болон олон улсын сайн туршлагыг[□] холбох, солилцох явдал

хангалтгүй байна. Монгол Улс олон улсын сайн туршлагаас суралцах, хэрэгжүүлэх боломжийг бүрэн авч хэрэгжүүлж чадахгүй байна. Нийтлэг жишээ гэвэл мөнгөн усаар алт бариулах үйл ажиллагааг нууцаар хийхэд хүргэдэг мөнгөн усны хэрэглээг шууд хориглох, баяжуулах цехийн үйл ажиллагааг хязгаарлах зэрэг явдал юм. Үүнтэй адилаар, Монгол Улсын хэрэгжүүлсэн сайн туршлагын жишээ (ж.н ХЭСХ-ийг БУ-д хэрэгжүүлэх алхам) нь зарим талаараа л бусад улс оронд хүрч байна. Хэлний бэрхшээл байгаагийн дээр 2010 онд CASM буюу Олон нийт ба БУ-н санаачлага хэрэгжиж дууссанаас хойш дэлхийн хэмжээнд мэдлэг, туршлага солилцох асуудал илүү учир дутагдалтай болсон. Одоо БУ-н тодорхой



сэдэв, чиглэлээр мэдлэг, туршлага солилцох өргөн хүрээ байгаа ч тэдний хоорондын зохицуулалт хангалтгүй байна. [□] Олон улсын хэд хэдэн бодлогын санаачлагууд, БУ-н асуудлаарх бусад орны үндэсний хөтөлбөрүүд нь Монголын туршлага, мэдлэгээс суралцан үр шимийг хүртэж боломжтой бөгөөд нөгөө талаас НҮББОХ, ЭЗХАХБ, НҮБҮХБ, НҮБХХ-ийн Олборлох салбарын төслүүд, Дэлхийн банкны улс оронд хэрэгжүүлж буй төслүүд (ж.н БНАКУ-д хэрэгжүүлж буй PROMINES, Танзанид хэрэгжүүлж буй SMMRP төсөл) зэрэг олон улсын үйл ажиллагаанаас Монгол Улс суралцах боломжтой. Түүнчлэн, БУ-н асуудлаар бүс нутгийн болон дэлхийн хэмжээний сүлжээ, мэдлэг туршлага солилцох олон улсын сүлжээ, мэдээллийн нэгдэл, форум байхгүй байна. Энэ цоорхой нь Монгол болон бусад оронд сайн

туршлагыг үр дүнтэй удирдаж, түгээх замаар улс орны болон олон улсын хэмжээнд хүрч болох боломжит үр нөлөөг бууруулж байна.


Төслийн хүрээнд шийдэх шаардлагатай чухал асуудал нь "БУ-г хариуцлагагүй үйл ажиллагаа явуулахад хүргэж буй төрийн үүрэг болон бичил уурхайчдын хариуцлагыг тодорхойлж, БУ-н салбарыг цогцоор нь авч үзэхгүй байгаа явдал" юм. Ийм хариуцлагагүй үйл ажиллагаанд түр зуурын, албан бус олборлолтын газар дахь ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа хангалтгүй байх (ж.н ОУХБ, ДЭМБ-ын конвенцид тусгагдсан), албан бусаар үйл ажиллагаа явуулж байгаа уурхайчдад хяналт тавьж, шалгах боломжгүй нөхцөлд байгаль орчинд хор хөнөөл учруулах(ж.н НҮББОХ-ийн конвенцид тусгагдсан), албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний холбогдох талуудын зохицуулалт байхгүй учир алт зэрэг бүтээгдэхүүнийг хар зах дээр худалдаалах (ЭЗХАХБ-ын Зохистой үйл ажиллагааны зааварт тусгагдсан), хөдөлгөөнт сургууль байхгүйн улмаас хүүхдийн нийгмийн асуудал орхигдох эрсдэл зэрэг багтана. Энэ нөхцөл байдал дээр нэмээд орон нутгийн удирдлагууд хөдөлмөрийг нь завших, биед нь хохирол учруулах, цагдаа нар хууль бусаар хорих зэрэг асуудлууд орох ба энэ нь бичил уурхайчид ба төрийн хоорондын үл ойлголцлыг улам ихэсгэдэг байна.

2.5 Оролцогч талууд – өөрчлөлтийн хөдөлгөгч хүч ба саад тотгор

Төслийн 3 дахь үе шаттай харьцуулахад оролцогч талуудын бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон. Оролцогч талуудын нарийвчилсан дүн шинжилгээнээс харахад, БУ-г хуульчилсны үр дүнд холбогдох оролцогч талуудын тоо нэмэгдэж, өмнөх оролцогч талуудын олон нь БУ-н талаар нөлөөтэй, сонирхолтой болсон. Оролцогч талуудын нарийвчилсан дүн шинжилгээг Хавсралт 5-д тусгав.

БУ-н талаарх нийтлэг ойлголт илүү эерэг болж, өмнө нь эсэргүүцдэг байсан талууд байр сууриа өөрчилж байна. Албан ёсоор БУ-н хүчтэй эсэргүүцэгч хэвээр байгаа, саад болж буй этгээд гэж үзэх ёстой нэг оролцогч тал бол Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ).⁵ ТБУТ нь албан бус нийлүүлэлтийн сүлжээний талуудтай мэдрэмжтэй хамтарч ажилласны дүнд "ченж"⁵-үүд нь "хар захын мафи"-ийн өмнө нь үзэж байснаас хамаагүй бага хэсгийг эзэлдэг, харин ч биеийн болон санхүүгийн аюулгүй байдлын хувьд өндөр эрсдэлд байдаг ихээхэн эмзэг бүлэг болохыг илрүүлсэн. Улаанбаатар хотод ажилладаг томоохон ченжүүд хүртэл өмнө нь

5 "Сайн туршлага" гэдэг нь: БУ-н сайн туршлагыг нийтээр хүлээн зөвшөөрсөн ямар нэг баримт бичиг, стандартад тодорхойлоогүй боловч дэлхийн хэмжээнд авсан сургамжийг орон нутагт хэрэгжүүлэх (энэ нь гагцхүү эдгээр сургамжийн талаар мэдлэгтэй байж л хэрэгжүүлэх боломжтой)-ийг хэлнэ. Энэ төслийн баримт бичгийн хувьд сайн туршлага гэдгийг **эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан БУ** гэж ойлгоно.



Зураг 1: ТБҮТ-ийн 4 дэх үе шатны оролцогч талууд

бодож байсан шиг албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд зарах сонирхолгүй биш бөгөөд албан ёсны болгосноор аюулгүй байдал, бизнес боломж нэмэгдэнэ гэж тэдний ихэнх нь үзэж байна. Эдгээр дүгнэлт нь нийлүүлэлтийн сүлжээний талуудыг өмнө нь өөрчлөлтийн саад тогтор бологчоос хөдөлгөгч хүч гэж өөрчлөх хэрэгтэйг харуулж байна.

Гол оролцогч талууд (Зураг 1-д бараан саарал өнгөөр харуулсан)

- БУ-н талаар хамгийн их сонирхох тал мэдээж БУ-н ТББ, БУ-н Дээвэр Холбоогоор төлөөлүүлсэн бичил уурхайчид, ченжүүд,⁶

баяжуулах цехийн эзэн зэрэг нийлүүлэлтийн сүлжээний талууд нь төслийн “үр шим хүртэгч”, эрх эдлэгчид байна.

- Хамтрагч тал болох оролцогч тал нь (өндөр хариуцлага, ашиг сонирхол, нөлөөлөлтэй) үүрэг хүлээгч болох Төр, тухайлбал, Засгийн газрын уул уурхайн салбарыг төлөөлсөн УУЯ, түүний хэрэгжүүлэгч агентлаг болох АМГ, мөн Уул уурхайн аврах алба (УУАА) байна. Мөн орон нутгийн захиргаа, орон нутгийн БУ-н асуудал хариуцсан албад, саяхан байгуулагдсан ХЯ, ХАХНХЯ зэрэг нь хамтрагч тал байна.

Үндсэн оролцогч талууд (Зураг 1-д бүдэг саарал өнгөөр харуулсан)

- Маш өргөн хүрээний Үндсэн оролцогч талууд байна. Үүнд төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн салбар багтаж байна.

⁶ Үүнд: ASM-PACE, Хамгаалалтын бүс, онцгой эко бүсэд БУ эрхлэх явдлыг удирдах сайн туршлага, одоогоор санхүүжилт хангалтгүй болсон; БУ-н Алтны зөвлөл ба НҮББОХ-ийн ‘Mercurywatch.org’ вэб хуудас; IIED’s ASM Knowledge Programme буюу БУ-н мэдлэгийн хөтөлбөр, хараахан үйл ажиллагаа нь эхлээгүй; Вашингтон орчмын БУ-н мэргэжилтнүүдийн DC_ASGM гүүглийн дугуй ширээний бүлэг; Мөнгөн усны асуудлаар ажилладаг мэргэжилтнүүдийн ASGM partnership БУОА-н гүүглийн бүлэг; ЭЗХАХБ-ын Зохиостой үйл ажиллагааны Зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаарх ЭЗХАХБ-ын БУ-н төв; UN-ICGLR-UN-ын 2 жил тутам зохиогддог БУ-г албажуулах асуудлыг зарим талаар хөнддөг ашигт малтмалын салбарын маргааны асуудлаарх бага хурал; Ecominerals буюу эко ашигт малтмалын асуудлаарх уаhoo бүлэг; хариуцлагатай БУ-тай холбоотой сургалтын материал,

бусад мэдээлэл бүхий Alliance for Responsible Mining’s website буюу Хариуцлагатай уул уурхайн нэгдэл вэб хуудас.Эдгээр санаачлагууд чухал хэрэгцээтэй боловч зохицуулалтгүй байна.

3. Үр дүн ба авсан сургамж

3.1 Өмнөх үе шатны гол үр дүн ба бүтээгдэхүүн

ТБУТ нь 2005 онд буюу Монгол Улс шилжилтийн үеийн үр дагавараас шалтгаалсан уналтад орсон хэвээр байсан, 100,000 гаруй бичил уурхайчдын алтны халуурлын эгзэгтэй үед хэрэгжиж эхэлсэн байна. Төслийн 2 дахь үе шат (2007-2010)-ны явцад мөнгөн усны хэрэглээг хориглосон (улс төрийн шалтгаантай), үүнийг дагаад БУ-г гэмт хэрэг гэж үзсэн кампанит ажил өрнөж байсан нөхцөлд төсөл үйл ажиллагааны стратегия бүрэн нийцүүлж ажиллах шаардлагатай байсан. 2 дахь үе шатны эцэст, төслийн нөлөөллийн болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг төсөөлж болох ч хэмжих боломжгүй байв. Улмаар ШХА-ийн БУ-д өмнө нь хэрэгжүүлсэн төслөөр баталгаажсан өөрчлөлтийн онолыг дараахь томъёоллоор боловсруулсан: *"БУ-г албан ёсны эдийн засагт уялдуулан хамруулах таатай нөхцөл нь албажуулах, хариуцлагатай үйл ажиллагаа байх ба хариуцлагатайгаа харуулсан БУ нь БУ-н хөгжлийн боломжийн талаар итгэх оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлнэ"*.

Төслийн 3 дахь үе шатыг боловсруулахдаа БУ-н эрхзүйн таатай тогтолцоог бүрдүүлэхэд болон БУ-н сайн туршлагыг хариуцлагатай бичил уурхайчдад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьсон. Хүлээгдэж байсан үр дүнг (1) *"Эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх замаар хариуцлагатай бичил уурхайчдын баталгаатай ажлын байрыг бий болгох"*, (2) *"зохион байгуулалтад оруулах, нийгмийн болон байгаль орчны хариуцлагыг сайжруулах, арга технологийг сайжруулах, орон нутгийн баялаг бүтээх зэргээр бичил уурхайчдын амьжиргааг сайжруулах"* гэж тодорхойлсон. Төслийн дунд шатны үнэлгээгээр цаашид сайжруулах зарим асуудал байгааг дурдахын зэрэгцээ хүрсэн үр дүнгийн энэ

хандлагыг 4 дэх үе шатны бүрэлдэхүүн хэсэг болгохыг зөвлөсөн. Үүнд дараахь асуудлуудыг хамарна: (i) Эрхзүйн тогтолцоо ба албажуулах үйл ажиллагаа, (ii) БУ-н байгууллага ба бүтцийг бэхжүүлэх, (iii) нийгмийн хариуцлага, нийгмийн хамгаалал, ажлын байрны аюулгүй ажиллагаа, (iv) Байгаль орчны хариуцлага, экологид ээлтэй технологи (ESEC II төсөлтэй хамтран, зохицуулах)⁷; (v) чадавхийг бэхжүүлэх, мэдээллийн хүртээмж, (vi) орон нутгийн хөгжил ба орлогын эх үүсвэр бий болгох асуудал юм.

ТБУТ-өөс хариуцлагатай БУ-чид болон эрхзүйн таатай орчин нь харилцан бие биенээ хүчирхэгжүүлэх харилцан ашигтай циклийг санаачилсан. Үүний дүнд БУ-г албан ёсны болгох талаар ахиц гарсан төдийгүй, бичил уурхайчдыг эрх мэдэлжүүлэх болон БУ-н олборлолтын газрыг хариуцлагатай БУ-н олон улсын нийгмийн болон байгаль орчны сайн туршлагын стандартад⁷ ойртуулах талаар ихээхэн ахиц гарсан. БУ-н Дээвэр Холбоо 2013 онд байгуулагдсан нь бодлогын түвшинд чухал боломж байгааг харуулав. Төслийн 3 дахь үе шатны явцад ХЭСХ-ыг хэрэгжүүлснээр үүрэг хүлээгчид тус салбарыг албажуулахад идэвхтэй болсон ба эрх эдлэгчид өөрсдийн эрхээ шаардах, улс төрийн хүсэл эрмэлзлийг бий болгох талаар эрх мэдэлтэй болсон. Гэвч, ХЭСХ-ыг хэрэгжүүлэх, улс төрийн болон байгууллагын түвшин дэх БУ-н талаарх ойлголтыг шийдэх, хүний эрхийн талаарх үүргийг хэрэгжүүлэх, жендэрийн тэгш байдлыг үр дүнтэй хангах чиглэлээр олон ажил хийх, боломж байсаар байна.

⁷ БОНХАЖА ТБУТ-ийн 4 дэх үе шатны төлөвлөлтийн ажилд албан ёсоор оролцохоос татгалзсан.



3.2 Дунд шатны үнэлгээний зөвлөмж

Төслийн 3 дахь үе шатны ДШҮ-ээр ТБУТ-ийн хэрэгжилтийн стратегийн ахиц, амжилтыг нотолсон. Үнэлгээг 2013 онд хийсэн. Үнэлгээгээр ХЭСХ-ыг хэрэгжүүлэх явдлыг эрчимжүүлэх, жендэрийн асуудалд анхаарах, алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулахад анхаарч ажиллах, тус салбар ШХА-ийн дэмжлэгээс бүрэн хамааралтай байх эрсдлийг бууруулах, АМГ-ын БУ-н тасаг, БУ-н Дээвэр холбоо зэрэг гол түнш байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх зэрэг асуудлаар олон зөвлөмж өгчээ. Эдгээр зөвлөмжөөс гадна төслийн үр дүн, үр нөлөөг цаашид сайжруулах боломж, ХШҮ-тэй холбоотой хэмжих, үнэлэх аргыг сайжруулах шаардлагатай байгааг тусган, ДШҮ нь ТБУТ-ийн хэрэгжилтийн стратегийг амжилттай гэж дүгнэсэн: Зөвлөмжийн ихэнх нь хэрэгжиж буй үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэхийг санал болгосон байна.

3.3 Сургамж ба ТБУТ-ийн 4 дэх үе шатанд тусгасан нь

Үр нөлөө, тогтвортой байдлыг хангахын тулд Засгийн газраас БУ-н салбарт тавьж буй анхаарлаа БУ-н салбарын хариуцлагатай үйл ажиллагааг "шагнах" байдлаас "үүрэг хүлээгч"-ийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд анхаардаг болж өөрчлөх хэрэгтэй. Бичил уурхайчдыг, ялангуяа эмзэг бүлэг болох эмэгтэй бичил уурхайчдыг эрх мэдэлжүүлэх нь үүрэг хүлээгчдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлнэ. Ингэснээр Төр хүний эрхийн талаар хүлээх үүргээ биелүүлэхэд анхаарч, Монголын БУ-н нөхцөл байдлыг сайжруулах улс төрийн болон байгууллын хүсэл эрмэлзлийг бэхжүүлэх юм. ТБУТ-ийн үр

дүнгийн тогтвортой байдлыг хангахын тулд Төр БУ-г албажуулах нөхцөлийг бүрдүүлэн, төрийн байгууллагууд тус салбарт үзүүлэх үйлчилгээг хүргэдэг байх шаардлагатай.

"Сайжруулсан" алтны "бүтээгдэхүүн"-ийг хар зах дээр гаргах болон алтыг хууль бусаар улсын хил давуулан гаргах явдлаас зайлсхийхийн тулд төслийн хамрах хүрээг өргөжүүлэн албан бус алтны худалдааны сүлжээг хамруулах шаардлагатай. Энэ нь Монгол Улс ЭЗХАХБ-ын гаргасан ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал, хууль ёсны талаарх зааврыг дагаж мөрдөхөд дэмжлэг болохын хамт уурхайчдын эмзэг байдлыг багасгаж, үр дүн буруу тийш эргэх эрсдлээс сэргийлэх юм. Энэ нь мөн ашигт малтмалын салбарын макро эдийн засагт үзүүлж буй эерэг үр нөлөөг сайжруулах зорилготой Монгол Улсын 2025 он хүртэлх Алт хөтөлбөрт дэмжлэг үзүүлнэ. БУ-н алт нь Монгол Улсын мөнгөний бодлогод⁸ чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Эдийн засаг, улс төрийн хувьд танил тал, холбоо сайтай, хар зах дээр ажиллах сонирхолтой зуучлагчидтай "тэмцэх" нь үр дүнтэй, амжилттай хэрэгжих арга биш юм. Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан "эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх"-д төслийн хамрах хүрээг өргөжүүлэх нь БУ-чид болон албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний талуудын хооронд тогтвортой холбоог бий болгох, өрх гэр, орон нутаг, бүс нутаг болон улс орны эдийн засагт илүү өргөн хүрээний үр нөлөө бий болгох, эдгээр үр нөлөө бодитой харагдаж, ойлгогдсоноор улс төрийн дэмжлэг авах аль алинд нь ашигтай арга юм.

⁸ Орон нутаг, бүс, улсын хэмжээнд Монгол банкнаас өөр алт худалдан авагчийг нэрлэж буй Монгол нэр.

БУ-г албажуулах талаарх улс төрийн эсрэг үзэл бодол нь БУ-н хэврэг байдлыг бий болгож байна. 2000 оны эхээр “Нинжа нар” гэгдэж байсан БУ-г түр зуурын таагүй үзэгдэл гэж үздэг байв. Үл ойшоосноор БУ арилж үгүй болсонгүй харин албан бус байдлаар засгийн газрын хараа хяналтаас гадуур хөгжиж, улс төрийн асуудал болсон. Байгаль орчны асуудал, БУ-н албан бус статусыг үргэлжлүүлэх гэсэн сонирхол нь олон нийтийн дунд таагүй үзэл бодлыг бий болгож, эрхзүйн орчныг бүрдүүлэхэд арав гаруй жилийн туршид саад болсоор байна. Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах шинэ бодлого нь БУ-г албажуулахын эсрэг байр суурьтай байгаа БОНХАЖЯ-ны Байгаль орчны бодлогод хэр нөлөөлж чадахыг харах хэрэгтэй.

ТБУТ-ийн үр дүн нь БУ-г цаашид дэлхийн түвшинд хөгжүүлэхтэй ихээхэн холбоотой. Швейцарь Улсыг зөвхөн худалдааны чиг үүргээр төдийгүй 20 жилийн туршид ШХА-аар дамжуулах энэ салбарыг хөгжүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлж ирсэн учир БУ-н салбар дахь гол оролцогч тал⁹ гэж үздэг. Энэ хорин жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага, ялангуяа БУ-г албажуулах, хуульчлах, мөнгөн усны хор нөлөөг бууруулах, хариуцлагатай БУ-н ажиллагаа, орон нутгийн эдийн засгийн хөгжил, бичил уурхайчдын жендэрийн тэгш байдал зэрэг туршлага нь НҮББОХ-ийн Мөнгөн

усны асуудлаарх Минаматагийн конвенцийг хэрэгжүүлэх болон бичил уурхайчдаас зах зээл хүртэлх нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Монгол Улс нь эдгээр туршлагыг “эзэмшиж буй” орон юм.¹⁰ Энэ нь Монгол Улс БУ-н мэдлэг, мэдээллийн төв болох өргөн боломжтойг харуулж байна.

Дэлхийн бусад орны БУ-н санаачлага, сүлжээтэй нягт холбоотой байх нь Монгол Улсын хувьд төсөл хэрэгжиж дууссаны дараа бичил уурхайн салбарт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх боломжоо хэвээр хадгалахад чухал юм. Олон улс оронд БУ-н төсөл хэрэгжиж дууссаны дараа БУ-н салбар зогсонги байдалд орсон бөгөөд ШХА-аас “хамааралтай” байгаагаас мөн ийм эрсдэл Монголд байгааг ДШҮ-ээр дүгнэсэн. Мэдлэгийн төв нь Монголын болон бусад орны оролцогч талууд уурхайчид болон оролцогч талууд хүний эрхээ эдэлдэг, харилцан солилцож, эрх мэдэлжүүлдэг хариуцлагатай БУ-н салбарыг бий болгох талаар харилцан тогтвортой хамтарч ажиллах боломжийг хангана.

⁹ Оролцогч талуудын дүн шинжилгээнд БУ-чдын байгууллагаар төлөөлүүлсэн ч хувь хүний түвшинд бичил уурхайчид, тэдний гэр бүлийнхэн де факто эрхтэй байна.

¹⁰ Байгаль орчны асуудлаарх төслийн үйл ажиллагаа нь Мөнгөн усны асуудлаарх Минаматагийн конвенциэр хүлээсэн Монгол Улсын үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах, дагаж мөрдөхтэй нягт нийцсэн байна. Монгол Улсад мөнгөн усны хэрэглээг хориглосон. Гэвч мөнгөн усгүй баяжуулах цехээр (ТБУТ-өөс хэрэгжүүлсэн) үйлчлүүлэх боломжгүй албан бус уурхайчид мөнгөн усыг хэрэглэсээр байгаа юм.



4. Зорилго

4.1 Төслийн хамрах хүрээ ба бүрэлдэхүүн хэсгүүд

ТБУТ-ийн 4 дэх үе шатны хамрах хүрээ нь агуулгын болон газарзүйн байршлын хувьд илүү өргөн байна. Төсөл нь эрхзүйн таатай орчин дахь хариуцлагатай уул уурхайн талаар гарсан томоохон амжилтыг бэхжүүлэхийг зорьж байна. Өмнөх сургамж, туршлага дээрээ үндэслэн дараахь 3 үндсэн асуудлыг уялдуулснаар 4 дэх үе шат илүү үр дүнд хүрнэ. Үүнд:


- **ХЭСХ-ыг дорвитой хэрэгжүүлснээр төслийн тогтвортой байдал бэхжинэ.**¹¹ Эрх эдлэгчдийг эрхээ ойлгож шаардах талаар илүү эрх мэдэлжүүлэх, холбогдох хуульд заасны дагуу үүрэг хүлээгчдийн хүний эрхийн талаарх өөрсдийн үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавхийг бэхжүүлэх нь төслийн үр нөлөө, тогтвортой байдлыг бэхжүүлнэ.
- **БУ-г албажуулахад анхаарах асуудлыг нийт оролцогч талуудын эдийн засгийн бололцоог бэхжүүлэхийн зэрэгцээ алт нийлүүлэлтийн албан ёсны сүлжээг бүрдүүлэх чиглэлээр өргөжүүлнэ.** Алт нийлүүлэлтийг сүлжээг албажуулахад дэмжлэг үзүүлэх нь БУ-аар олборлосон алтны бүтээгдэхүүн нь зөвхөн уурхай эрхэлж буй иргэдийн гэр бүлд нэмэр болоод зогсохгүй, мөн орон нутгийн тогтвортой хөгжил, улсын орлого, мөнгөний тогтвортой байдалд, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны хөгжилд хувь нэмэр оруулах явдлыг баталгаажуулна.

- **БУ-чдын дунд сайн туршлагаа солилцох талаар хамтран ажиллах нь Монгол Улсад санаачлан хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тогтворжуулах, үр дүнг бусад улсад түгээхэд чухал.** БУ-н салбарт 20 жилийн туршид Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА)-ийн үзүүлсэн дэмжлэгийн хуримтлуулсан туршлагыг танилцуулах замаар Монгол Улс өөрийн туршлагыг баталгаажуулж, Азийн бүсийн хэмжээнд (түүнээс цааш ч мөн хэрэгжүүлж боломжтой) энэ талаарх мэдлэгийн төв болох боломжтой юм. Мэдлэгээ идэвхтэй хуваалцах замаар БУ-н бодлого боловсруулагчид болон БУ-чид олон улсын сайн туршлагын талаарх мэдээллээс өөрсдөө хүртэх, дэлхийн хэмжээнд БУ-н талаарх хэлэлцүүлэгт эзлэх байр сууриа бэхжүүлэх юм.

ТБУТ нь өөр хоорондоо уялдаа бүхий 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бүтцээ шинэчлэх шаардлагатай. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг нь дараахь асуудлыг хамарна. Үүнд:

- Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба бичил уурхайчдыг дэмжих үйл ажиллагаа: Төслийн 3 дахь үе шат болон ТБУТ-ийн өмнө хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг үргэлжлүүлэн энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ХЭСХ, үүрэг хариуцлагыг бэхжүүлэх, эрх эдлэгчдэд илүү эрх мэдэл олгох чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд анхаарна.
- Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудын эдийн засгийн үр ашгийг бэхжүүлэх: Тус бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд алтны ил тод нийлүүлэлтийн сүлжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх болон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах талаарх Монгол Улсын болон олон улсын бодлогын хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл өгч ажиллана. ХЭСХ-ыг эхнээс нь тусгаж хэрэгжүүлнэ.

¹¹ ШХА: ШХА-ийн хүний эрхийн талаарх бодлого: Чанартай амьдралыг цогцлоох—Ядуу иргэд эрхээ эдлэх нь. Берн, 2006. www.deza.admin.ch/ressources/resource_en_25225.pdf



Зураг 2: 4 дэх үе шатанд Төслийн хамрах хүрээг өргөжүүлнэ

- *Мэдлэг, мэдээлэл солилцох болон БУ-н бодлогын талаарх олон улсын хэлэлцүүлэг:* Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь төслийн үр нөлөөг үндэсний түвшнээр үл хязгаарлан олон улсын хэмжээнд түгээх, мөн бусад улсын туршлагыг Монгол Улсад авчрах зорилготой. БУ-н талаарх дэлхийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын гол цөм нь ХЭСХ-ыг эдийн засгийн үр ашигтай, байгаль орчны хувьд хариуцлагатай, нийгэм хүлээн зөвшөөрсөн, тогтвортой бичил уурхайн гол үндэс гэж үзэж буй явдал юм.

4.1.1 Мэдлэг хуваалцах бүрэлдэхүүн хэсгийн онцлог

БУ-н салбар нь Монгол Улсад болон дэлхийн бусад улс оронд ч ангал ба өсөн дээшлэх боломжийн дундах зам болж байдаг: Монгол Улсын хувьд өнөөг хүртэл гайхалтай ахиц үр дүн гарсан ч төсөл хэрэгжиж дууссаны дараа энэ үр дүн сул, эргээд буруу тал руугаа эргэх ч эрсдэлтэй. Хэрэв оновчтой мэргэжлийн зөвлөмж, дэмжлэг авахгүй, БУ-н чиглэлээрх олон улсын оролцогч талуудыг оролцуулах талаар чадавхийг бэхжүүлэхгүй бол улс орон гагцхүү дотоодын санаачлага, богино хугацаанд хуримтлуулсан туршлага, улс төрийн хүсэл зоригийн урьдчилан таах аргагүй өөрчлөлтөөс хамааралтай болно. ТБУТ хэрэгжиж дуусах үедээ Монгол Улс БУ-н салбар төлөвшихтэй холбоотой боломж, сорилтуудыг өөрөө шийдэх чадвартай болгохын зэрэгцээ Минаматагийн конвенци, НҮБ-ын Үндсэн зарчмууд, ЭЗХАХБ-ын гаргасан Зохистой үйл ажиллагааны заавар зэрэг БУ-н талаарх олон улсын санал санаачлага зэрэг олон улсын баримт бичгийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, дагаж

мөрдөхөд шаардлагатай чадавхийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай. Олон улсын мэдлэг, мэдээлэл солилцох явдал нь бусад олон улс оронд болдог буруу шийдвэр гаргаснаас үүдэн БУ-чид, худалдаа эрхлэгчдийн эрхийг үгүйсгэх, хүний эрхийг зөрчих явдал нэмэгдэх эрсдлийг арилгахад зайлшгүй чухал¹².

Тус салбарт олон нийтийн зүгээс илүү анхаарах болж, сайн туршлагын талаарх мэдлэг, мэдээлэл олж авах явдал сайжирах нь БУ-н талаарх оновчтой бодлого, үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэхэд ихээхэн чухал болж байна. Энэ нь Монгол Улсад шууд хамааралтай боловч бодлого боловсруулагчид, бусад оролцогч талууд шинэ гэрээг хэрэгжүүлэх ихээхэн сонирхолтой, БУ-г хөгжүүлэх боломж, эрсдлийн талаарх ойлголтоо сайжруулах сонирхолтой байдаг олон улсын түвшинд мөн чухал юм. Монгол Улс нь мэдлэг мэдээлэл солилцох замаар олон улсын сайн туршлагаас үр шимийг хүртэх, өөрөө хувь нэмэр оруулах сайхан боломжтой бөгөөд ШХА болон ТБУТ нь энэ асуудалд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.¹³

¹² Сүүлийн үед их яригдаж буй ашигт малтмалын нөөцийн "хариуцлагатай эх сурвалж, гарал үүсэл", "зохистой үйл ажиллагаа" –ны асуудлууд нь олон оронд эрх нь хязгаарлагдмал байдаг БУ-чид, худалдаа эрхлэгчдийг "хариуцлагатай" нийлүүлэлтийн сүлжээнд оролцох эрхээ алдах томоохон эрсдэлд хүргэж байна.

¹³ ХЭСХ-ын дагуу Швейцарийн Засгийн газар нь үүрэг хүлээгч байна. Швейцарь Улс нь НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн үндсэн зарчим, ЭЗХАХБ-ын гаргасан Үндэстэн дамнасан корпорацийн талаарх Гарын авлагад заасны дагуу Швейцарийн аж үйлдвэрүүд өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээн дэх хамгийн эмзэг хүмүүст худалдааны сувгаа нээлттэй байлгах үүрэг хүлээсэн байдаг. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд БУ-н чиглэлээр анхдагч, үр нөлөө ихтэй хэд хэдэн төслүүдэд дэмжлэг үзүүлж байгаа нь Швейцарь Улс мэдлэг, туршлага, хэлхээ холбооны арвин нөөцтэй болсон нь бусад улсын БУ-н салбар дахь хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх замаар БУ-чдыг эрхээ шаардах, үйл ажиллагаагаа албажуулан хуульчлахад дэмжлэг

ТБУТ, ШХА-ийн мэдлэг, туршлага солилцох явдал нь Монгол Улсад болон дэлхийн хэмжээнд БУ-н салбарт томоохон үр нөлөө үзүүлсэн.¹⁴Монгол Улсад хэрэгжүүлж буй ТБУТ болон ШХА-аас БУ-н чиглэлээр бусад улсад хэрэгжүүлж буй төслөөр дамжуулан олон улсад нэвтрүүлсэн нь БУ-н салбарт эерэг өөрчлөлтийг эхлүүлэгчид болж, анхан шат, төрийн байгууллага улмаар Парламентын түвшинд амжилттай анхдагч болж байна. Монгол Улсын туршлагын талаар олон улсын уулзалт хурлын үеэр ихээхэн ярих болсон.

Мэдлэг туршлага солилцох талаар илүү системтэй хандсан бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх нь төслийн үр нөлөөг ихээхэн сайжруулах юм. Мэдлэг туршлагаа үр дүн солилцох нь “өгөх, “авах” хоёр чиглэлийн үйл ажиллагаа бөгөөд үйл ажиллагааны өргөн хүрээний стратеги, чиглэл болон агуулгын асуудлыг хамрахыг шаарддаг. ТБУТ-ийн 4 дэх үе шатны төлөвлөлтийн (Хавсралт 8) үед БУ-н мэдлэг, туршлага солилцох талаар хийгддэг санал санаачлагын талаар хийсэн асуулгаас харахад мэдлэг туршлага солилцох аргуудыг өргөнөөр хослуулах нь амжилтын түлхүүр болдог байна. Үүнд вэб хуудас, олон нийтийн харилцааны бүлэг ажиллуулах, хамгийн үр дүнтэй арга болох мэргэжилтэн болон ажилтан солилцох, зорилтот танилцах аялал, нүүр тулан суралцах арга хэмжээ, БУ-н тодорхой асуудлаар зорилтот бага хурал зохион байгуулах, оролцох зэрэг мэдээлэл түгээх стратегитай хандлагууд багтана. Эдгээр арга нь бататгах сүлжээ, чадавхийг бэхжүүлэх, сэтгэлгээний өөрчлөлт бий болгох явдал юм. Мэдлэгийн төв (МТ)-ийг бүрдүүлэх нь эдгээр аргуудыг идэвхтэй хослуулах, үр дүнгийн харилцан адилгүй элементүүдийг холбох үйл явц юм. Асуулгаас харахад, бодлогын түвшинд ихээхэн нөлөөлөхүйц том байгууллагууд (ж.н НҮБХХ, НҮББОХ, АХБ, Дэлхийн банк, ЭЗХАХБ зэрэг)-ын дэмжлэг бүхий БУ-н мэдлэг туршлага солилцох зарим нэг (цөөн тооны) санаачлагууд байгаа боловч дийлэнх нь тодорхой асуудалд анхааран, гол төлөв дангаараа үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээрээс аль нь ч БУ-н талаарх мэдлэг туршлага солилцох харилцан холбоотой, дэмжлэгтэй, уялдаатай санаачлагыг

хэрэгжүүлэх чадвартай БУ-н мэдлэгийн төв болж хараахан амжаагүй байна.¹⁵

ТБУТ нь БУ-н Мэдлэгийн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх хамгийн тохиромжтой нэгж юм. БУ-н салбарын байнгын давшингуй, хөдөлгөөнтэй байдаг онцлогтой холбоотойгоор, ийм төрлийн төв нь зогсонги бус шилжин, хөдөлж байх шаардлагатай ба ингэснээр (i) Монгол Улсын хүрсэн ахиц амжилтыг бататгаж, цаашид тогтмол суралцах сонирхлыг өдөөх, (ii) эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан БУ-н салбарыг үр дүнтэй бий болгохын тулд мэдлэг, туршлагыг бий болгож, удирдаж, ашиглах чадавхийг бүх талуудад бэхжүүлэх зорилгоор Монголын болон бусад улсын холбогдох талуудын хоорондын холбоог бэхжүүлэх юм. Ингэснээр Мэдлэгийн төв нь а) түншүүдийн туршлагаас Монгол илүү үр шим хүртэх; б) түншүүд Монголын мэдлэгийн нөөцөөс суралцан, бусад орны БУ-чид болон БУ-н түншүүдийн хүртэх үр шимийг нэмэгдүүлэх; мөн түүнчлэн с) шууд оролцоо, дэмжлэг үзүүлэх, ТБУТ-ийн мэдлэгийн төвийн чиг үүрэг, мэдлэгийн бүтээгдэхүүнийг цаг тухайд нь дамжуулах замаар өөрсдийн зорилгод хүрэхийн төлөө ажиллаж байгаа нь бусад мэдлэгийн төвүүдийн чадавхийг бэхжүүлэн мэдлэг, туршлага солилцох бусад санаачлагуудыг бэхжүүлэх юм.

БУ-н Мэдлэгийн төвийн талаар агуулгын түвшинд санал болгож буй загварыг Хавсралт 8-ын 2 дахь хэсэгт тусгав.¹⁶



үзүүлэх боломжтой болгож байна.


14 Төлөвлөлтийн явцад ярилцсан Монголын оролцогч талууд өөрсдийнхөө болон хамт ажиллагсдынхаа явсан танилцах аяллын талаар байгууллагынх нь хувьд нөлөөлөхүйц өөрчлөлт хийх чухал арга хэмжээ болсон гэж дурдаж байсан. Монголд ТБУТ-өөс зохион байгуулсан “CASM 2007”, “Ази-Номхон далайн БУ-н Бага хурал-2013” зэрэг БУ-н асуудлаарх Бага хурлууд Монголын болон олон улсын БУ-н хувьд чухал арга хэмжээ болсон. Монгол Улс, Латин Америкт мөнгөн усны хэрэглээг бууруулж буй ШХА-ийн стратегийг системчлэн, хэвлүүлэх нь Минаматагийн конвенцид тусгасан таслан зогсоох, арилгах хандлагаас албажуулах хандлагад чиглүүлсэн.

Мэдлэг, туршлага солилцох нь нөөцийн өөр нэг шинэ боломжийг бий болгож байна. Мэдлэгийн төв нь харилцан солилцох, дэмжих, чиглүүлэх, зохицуулах явдал юм. БУ-н мэдлэг, туршлага солилцох бусад санаачлагуудтай түншлэн хамтран ажиллах нь бие биетэйгээ мэдээлэл солилцох замаар холбогдох оролцогч талуудын үйл ажиллагааг сайжруулна. Судалгаанд хамрагдсан мэдлэг туршлага солилцох санаачлагууд бүгд энэ чиглэлээр ТБУТ-ийн Мэдлэгийн төвтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Одоо хэрэгжиж буй сүлжээ, туршлага, мэдлэгийн бусад төвийн нөөц бололцоог дэмжин ажилласнаар Монголын БУ-н хувьд нэмэлт боломж бололцоог бий болгох юм.

4.2 Мэдлэгийн төв нь харилцан солилцох, дэмжих

Төслийн хүрээнд бий болсон үр нөлөө нь тодорхой, бодитой боловч энэ нь төслийн хамарч буй тодорхой асуудал, газарзүйн хэсгүүдээр хязгаарлагддаг. 2005 онд Төсөл хэрэгжиж эхлэх үед БУ-н салбар бүхэлдээ

албан бус, зохион байгуулалтгүй, ядуу байв. Ажлын байр аюултай, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, орон нутгийн хөгжилд тогтвортой оруулах хувь нэмэр байхгүй байсан. Уурхайчид, тэдний гэр бүлийнхнийг гадуурхаж, эрх бүхий байгууллага болон хамгаалалтынхан хөөх явцад бие махбодыг гэмтээх зэрэг хүний эрхийг ноцтой зөрчих явдал их гарч байв. Арав орчим жилийн дараа буюу 2014 онд БУ-н салбар нь уул уурхайн тухай хуульд хүлээн зөвшөөрөгдсөн, БУ-чдыг төлөөлсөн БУ-н Холбоотой, уурхайчид аюул осолгүй, байгаль орчинд хал багатай уурхайн арга ажиллагааг ашиглах талаар ахиц гаргаж байгаа, улс орны хэмжээнд олон газруудад орон нутгийн эдийн засгийн хөгжилд БУ-аас олж буй орлого чухал байр суурь эзэлсэн салбар болоод байна. Гэвч, эдгээр үр нөлөө нь гагцхүү ТБУТ хэрэгжиж буй сумдад л гарч байгаа бөгөөд нийт БУ-чдын томоохон хэсэг энэ ахиц, үр дүнгээс хүртэж чадахгүй байсаар байна. Мөн алтны худалдаа нь албан бусаар хийгдэж, улс орны хэмжээнд эдийн засгийн хөгжилд оруулж байгаа бодит нөлөөлөл нь хөдөлмөр эрхлэлтээр хязгаарлагдаж байна.



Зураг 3: Өөрчлөлтийн онолын мэдээлэл бүхий график:
БУ "хөгжлийн хөдөлгөгч хүч болох нь"

Хүлээгдэж буй өөрчлөлт – буюу ядуурлыг ил тод, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан хөгжил дэвшил болгох явдал юм. “Хөгжил дэвшил” гэдгийг хүний сайн сайхан амьдрал, хүний эрх чөлөөний бүх асуудлыг багтаан ойлгож байна. БУ-н нийлүүлэлтийн сүлжээнд алтыг хамруулж буй бөгөөд БУ-аар олборлосон алт нь боловсруулахаас эхлээд худалдаа болон бусад чиглэлээр орон нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд шууд хувь нэмэр оруулна.

Төслийн хүрээнд санал болгож буй 3 бүрэлдэхүүн хэсэг нь хүлээгдэж буй үр нөлөөг бий болгох “хөдөлгөгч хүч” болох юм. Зураг 3-д харуулсан мэдээлэл бүхий график нь Бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын хамаарлыг харуулах ба хөдөлгүүр тус бүрийг түлшээр хангахад шаардлагатай “орц”-ыг харуулж байна. “Хөдөлгөгч хүч” нь (урт хугацаанд) жилд дунджаар 5 орчим тонн албан ёсоор арилжаалагдсан алт гаргах үр дүнд хүргэх бөгөөд 100,000 гаруй бичил уурхайчдын гэр бүлийн гишүүдэд өсөлт хөгжил авчрах юм. Бий болгож буй мэдлэг, туршлага, ур чадварын талаар эерэг мэдээлэл нь энэ үйл явцыг хурдасгана.

Төслийн 4 дэх үе шатанд ХЭСХ-ийг хэрэгжүүлэх нь төслийн хэрэгжилтээс хамаарсан байдлыг бууруулахын зэрэгцээ ахиц, үр дүн бий болгоно гэж үзэж байна. Эрх эдлэгчдийг эрх мэдэлжүүлэн, үүрэг хүлээгчдийн чадавхийг бэхжүүлснээр (чадавхийн болон үүргээ биелүүлэхийн аль алины хувьд) төслийн шууд хэрэгжилтээс үл хамааран бие даан үр дүн, ахиц бий болно гэж үзэж байна. Өмнө нь БУ дахь төслийн шууд оролцоо нь тогтвортой БУ-г таниулан, ойлгуулахад зайлшгүй чухал шаардлагатай байсан. Үүрэг хүлээгчид үүргээ биелүүлэх явдлыг сайжруулах нь Төсөл өөрөө шууд оролцон хэрэгжүүлдэг байдлаа болих боломжийг бүрдүүлнэ. Эрх эдлэгчид эрхээ эдлэх хангалттай эрх мэдэлтэй, үүрэг хүлээгчид өөрсдийн үүрэг сайн биелүүлдэг болж, Төслийн оролцоо зогсох үед “Тогтвортой байдал” бий болно. Ийм төгс нөхцөл байдал ТБУТ-ийн 4 дэх үе шатны явцад хараахан бий болохгүй нь тодорхой боловч тодорхой бодит ахиц үр дүн гарах боломжтой гэж үзэж байна. Эрх эдлэгчдийн дийлэнх хэсэгт эрх мэдэл олгосон даруйд хүний эрхийг хэрэгжүүлэх үйл явцыг эргэлт буцалтгүй эхлүүлнэ гэж үзэж байна. Өнөөг хүртэл төслийн хүрээнд бий болсон үр нөлөөнөөс харахад, ийм үр дүн гарах боломжтой юм.

4.3 Хөгжлийн зорилт ба ТБУТ-ийн 4 дэх үе шатны хүлээгдэж буй үр дүн

Хөгжлийн зорилт

Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай хүний эрхэд суурилсан Монгол Улсын БУ-н салбар нь бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцан үр шимийг хүртэхийн хамт өөрөө хувь нэмэр оруулах

ТБУТ-ийн 4 дэх үе шат нь БУ-н салбарт 20 жилийн хугацаанд хуримтлуулсан ШХА-ийн туршлагад үндэслэн, дэлхийн болон улс орны хэмжээнд үр нөлөө бий болгох зорилготой. Дээр дурдсан Өөрчлөлтийн онолд дурдсанаар үндэсний хэмжээнд бий болгох үр нөлөө нь (хөгжил дэвшил ба нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал) эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай хүний эрхэд суурилсан Монгол Улсын БУ-н салбарт хувь нэмэр оруулах явдал. Ядуурал, БУ-н бүтээгдэхүүний хууль бус худалдаа нь БУ бүхий улс орны хувьд нийтлэг тулгамддаг асуудал учир ТБУТ нь мэдлэг туршлага солилцох аргуудыг ашиглах замаар “дэлхийн сайн туршлага”-д хувь нэмэр оруулах замаар олон улсын түвшинд үр нөлөө бий болгох зорилготой ба энэ нь эргээд Монголд хэрэгтэй, БУ-н талаар улс орны хэмжээнд бий болох ахиц өөрчлөлтийг нэмэгдүүлнэ.

Төслийн 3 бүрэлдэхүүн хэсэг хөгжлийн зорилтод шууд хувь нэмэр оруулна. (i) Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих, (ii) Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээн дэх оролцогч бүх талуудын эдийн засгийн боломжийг бэхжүүлэх, (iii) Мэдлэг, туршлага солилцох болон БУ-н олон улсын бодлогын хэлэлцүүлгийн замаар Хөгжлийн зорилтод хүрнэ. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрийг төслийн хүлээгдэж буй үр дүнд тусгасан болно.

Үр дүн 1

Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа

БУ-н оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр Хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын бичил уурхайн бүх үйл ажиллагаа, асуудалд тусгасан байна.

Тогтвортой БУ нь тус салбарыг хөгжүүлэх Засгийн газрын үүрэг, хариуцлагыг албажуулахаас ихээхэн хэмжээгээр хамаарна. Сүүлийн жилүүдэд гарч буй

ахиц, үр дүнгээс харахад, БУ нь хөгжлийн гол хөдөлгөгч, боломжийн, аюулгүй, эрх тэгш хөдөлмөр эрхлэлтэд чухал хувь нэмэр оруулагч, байгаль орчны хувьд хариуцлагатай хувийн салбарын гишүүн болж чадна. Гэвч ийм болоход, Төрийн үүрэг, эрх эдлэгчдийн эрхээ мэдэж, хариуцлагаа хүлээдэг болоход ихээхэн анхаарах шаардлагатай. Энэхүү үр дүнтэй холбоотой ТБУТ-ийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Төр нь БУ-г жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх замаар хариуцлагатай БУ-г хөгжүүлэхэд шаардлагатай хууль ёсны эрх мэдэлтэй, хүний, техникийн болон санхүүгийн чадавхтай байх эрхзүй, санхүү, байгууллагын тогтолцоог бий болгохыг зорино. Бүрэлдэхүүн хэсэг мөн БУ-н байгууллага, эрэгтэй болон эмэгтэй уурхайчид, тэдний гэр бүл нь өөрсдийн эрхээ шаарддаг эрх мэдэлтэй болж, БУ-н үйл ажиллагааг сайжруулахыг зорино.

Үр дүн 2

Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх

Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор БУ-аар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна.

Алтны нийлүүлэлтийн сүлжээний доод хэсэгт тавих анхаарлыг нэмэгдүүлж, үүнээс гарах үр ашгийг бүрэн ойлгон нэмэгдүүлэхэд эдийн засгийг бэхжүүлэх арга хамгийн боломжийн хандлага юм. Монголын албан бус алтны худалдаа нь гэмт хэргийн үйл ажиллагаанаас (маргаантай ашигт малтмалын нөхцөл зэрэг) үүдэлтэй бус харин албан ёсны зах зээл буруу байгаагаас болж байгааг илрүүлсэн дүгнэлтэд үндэслэсэн. Нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талууд зах зээлийн хязгаарлагдмал байдал, алтны албан ёсны худалдааны саадыг шийдсэнээр үр дүнг нь хүртэх болно. Төслийн энэ үр дүнтэй холбоотой бүрэлдэхүүн хэсэг нь орон нутаг, бүс нутаг, улс орны хэмжээнд амьжиргааны түвшинг сайжруулахын зэрэгцээ Монгол банк (нийлүүлэлтийн сүлжээний үндсэн оролцогч тал гэж үзэж байгаа) БУ-аар олборлосон алтыг худалдан авснаар Монгол Улсын мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал макро эдийн засагт мөн хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Үр дүн 3

Мэдлэг, туршлага солилцох, БУ-н талаарх олон улсын бодлогын хэлэлцүүлэг

Монгол Улсын оролцогч талууд БУ-тай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь БУ-н салбарт олон улсын түвшинд манлайлагч байна.

"Бид Азийн мэдлэгийн төв болохыг хүсч байна".¹⁷

Төслийн энэ үр дүнтэй холбоотой бүрэлдэхүүн хэсэг нь Засгийн газар, уурхайчид, бусад оролцогч талуудаас бүрдсэн Монголын БУ-н салбар нь алслагдсан байдлаас салж, олон улсын туршлага, сайн туршлагатай уялдуулах зорилготой. Зарим улс орнууд Монгол Улсын туршлагаас суралцах сонирхолтой байгаагаа илэрхийлж байна. БУ-н салбар дахь нөхөн сэргээлтээс эхлээд бичил уурхайн олборлолтын газарт ирж байгаа зочдод аюулгүй ажиллагааны зааварчлага өгөх хүртэл туршлагууд болон улам нэмэгдэж байгаа БУ болон том хэмжээний уурхай зөвхөн зэрэгцэн орших бус харин хамтын ажиллаж буй туршлагууд гэх мэт Монгол Улсын хүрсэн олон амжилт нь улс орон дотроосоо илүү олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж байна. ТБУТ-ийн өмнөх болон одоогийн үе шатанд мэдлэг, туршлагаа солилцох нь Монголын БУ-н талаарх хандлага, бодлогыг өөрчлөх маш хүчтэй арга гэдгийг харуулсан бөгөөд Монгол Улс нь мэдлэгийн төвийг дэмжих замаар тогтвортой БУ-н "сайн туршлага"-ын томоохон жишээний нэг болох боломжтой юм.

Энэ үе шатны нэг зорилго нь Монгол Улсын БУ-н салбарын эрх эдлэгчид, үүрэг хүлээгчид нь мэдлэг, туршлага солилцох сайн туршлагаас үр шим хүртэж байх явдлыг хангах, ингэснээр БУ-н салбарт бий гаргасан амжилтаараа бахархах, үндэсний эзэмшил, Монголын БУ-н тогтвортой хөгжлийн боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай улс төрийн хүсэл зоригийг бий болгох **явдал юм.** Мэдлэг, туршлага солилцох энэ аргын гол анхаарах асуудал нь зөвхөн ТБУТ-ийн хүрээнд хийгдсэн амжилт, хэрэгцээ шаардлага бус түүнчлэн БОХТОХ (ESEC) төслийн хүрээг хамрахын хамт амжилттай, жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан үйл ажиллагааг бусад оронд мөн хэрэгжүүлэх суурийг бий болгох юм.

¹⁷ Уул уурхайн яамны албан хаагч, ТБУТ-ийн талаар ярилцах үеэр, 2014.

4.4 ТБУТ-ийн 4 дэх үе шатанд бий болох Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа

Төслийн Бүтээгдэхүүн нь шууд болон "дам үр дүн"-ээр дамжуулан төслийн үр дүнд хувь нэмэр оруулна. Төслийн үр дүнд хүрэхэд "ердөө л" тодорхойлсон бүтээгдэхүүн бий болгосноор хүрэх боломжгүй илүү өргөн хүрээний, нарийн төвөгтэй хандлага шаардлагатай тохиолдолд, дам үр дүнг ашиглана. Дам үр дүн нь өөрчлөлтийг илүү бүхэл, цогц байдлаар илэрхийлэх логик хүрээг сул байдлаар харуулна.

4.4.1 Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа

Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн Бүтээгдэхүүн (Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа), нь шууд болон дам үр дүнгээр дамжуулан "БУ-н оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр Хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын бичил уурхайн бүх үйл ажиллагаа, асуудалд тусгасан байна" (Үр дүн 1) гэсэн үр дүнд хувь нэмэр оруулна.

Бүтээгдэхүүн 1.1

Хуульчлах & албажуулах:

Төслийн түнш болон хамтрагч эрх бүхий байгууллагууд БУ-н холбоотой дүрэм, журмуудыг хүний эрхийн асуудлыг тодорхой тусган шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

Дараахь дам үр дүнгээр дамжуулан Үр дүн 1-д хувь нэмэр оруулах:

БУ-н таатай эрхзүйн болон санхүүгийн орчин нь ХЭСХ-ын гол зарчмуудыг тусгасан, уурхайчдын эрхийг хэрэгжүүлэх талаар ахиц гарч, БУ-н байгууллагуудын үүргийг үр дүнтэй институтчилсэн байна.

Эрхзүйн болон санхүүгийн орчин нь бичил уурхайчдын эрхийг хүлээн зөвшөөрч, тэдэнд тулгарч буй саад бэрхшээлд анхааран, бичил уурхайн асуудлыг хариуцдаг гол байгууллагууд тус салбарыг албажуулах талаарх үүргээ хариуцлагатай хэрэгжүүлэхгүй тохиолдолд БУ-чид өөрсдөө үйл ажиллагаагаа албажуулж, байгаль орчны болон нийгмийн хувьд гүйцэтгэх үүргээ сайжруулж, орон нутгийн болон улс орны хөгжилд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлэхийг зорьдоггүй. Засгийн газар, аймаг сумдын зөвхөн тодорхой хэсгийн

чиг үүргийн талаар л хуульд тусгасан. Үр дүнг сайжруулахад хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаарх үүрэг хариуцлага, чиг үүрэг, зохицуулалтыг тодорхой болгох, энэ талаарх ойлголтыг сайжруулах, үүрэг хүлээгчдийн санхүүгийн болон техникийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Салбарын гол оролцогч талуудыг тогтмол оролцуулах, тэдэнтэй зөвшилцөх замаар зохицуулалтын өөрчлөлтийн хэлэлцүүлэгт дэмжлэг үзүүлэх.
- УУЯ, АМГ, тэдний хамтрагч төрийн байгууллагуудын оролцоог бэхжүүлэхийн зэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах.
- Засгийн газрын төв болон орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэхийн хамт тэдний хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах.
- Аймаг, сумдын засаг захиргааны байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээг өргөжүүлэх, сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.
- Засгийн газрын гол чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог сайжруулах явдлыг санхүүжүүлэх механизмаар дамжуулан үйлчилгээг тогтвортой өргөжүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх.

Бүтээгдэхүүн 1.2

Эрх мэдэлжүүлэх:

Бичил уурхайчид, тэдний төлөөллийн байгууллагуудын эрхээ хамгаалах, шаардах, нөлөөлөхтэй холбоотой чадавхийг бэхжүүлэх

Дараахь дам үр дүнгээр дамжуулан Үр дүн 1-д хувь нэмэр оруулах:

Бичил уурхайчид, тэдний төлөөллийн байгууллагуудыг уурхайчдын эрх, байгаль орчин болон нийгмийн хувьд халтай уурхайн үйл ажиллагаа, технологи ашигласнаас болж эрх нь хөндөгдөж болзошгүй уурхайчид зэрэг хүмүүсийн хүний эрхийг хүндлэх, хамгаалах, хэрэгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахтай холбоотой эрх мэдэлжүүлэх

БУ-н Холбоо нь 4-5 жилийн хугацаанд хэрэгжих Хүний эрхийн нөлөөллийн стратеги батлах зэргээр байгууллын чадавхи, лобби, нөлөөллийн чиглэлээр томоохон ажил хийсэн. Холбоо, БУ-н ТББ болон бусад оролцогч талуудын хүлээн зөвшөөрсөн чухалчлах асуудал нь бүх шатан дахь БУ-н байгууллагуудын эрэлтэд тулгуурласан, жендэрийн мэдрэмжтэй ардчилсан үйл ажиллагаагаар гишүүддээ үйлчилгээ хүргэх, төлөвлөх, санхүүжүүлэх механизмаар дамжуулан урт хугацааны

тогтвортой байдлыг сайжруулахтай холбоотой байна. Холбоог эрх мэдэлжүүлэх, хувийн салбарын томоохон төлөөллүүдтэй харьцах холбоог бэхжүүлэх талаар олон боломж байгаа.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БУ-н Холбооны Хүний эрхийн нөлөөллийн стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн болон бүс нутгийн БУ-н байгууллага байгуулах, тэднийг бэхжүүлэхтэй холбоотой чадавхийг бэхжүүлэх.
- БУ-н Холбоо, бүс нутгийн болон орон нутгийн БУ-н байгууллагуудад үүрэг хариуцлагыг үр дүнтэй шилжүүлэх замаар тогтвортой байдлыг дэмжих.
- Манлайлал, нөлөөллийн болон практик менежментийн ур чадварыг хөгжүүлэх ажлыг чиглүүлэх, төлөвлөлтийн залгамж байдал ба жендэрийн тэгш эрхийн асуудалд онцгойлон анхаарах
- Орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд уурхайчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах

Бүтээгдэхүүн 1.3	Мэргэшүүлэх ба хариуцлагыг сайжруулах: Зохицуулалт, харилцаа холбоо, чадавхийг бэхжүүлэх тодорхой бүтэц, үйл явцыг гол байгууллагуудад тогтоож, БУ-н мэргэшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх
-------------------------	--

Сүүлийн үед холбогдох хууль тогтоомжид оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь бичил уурхайчдад аж ахуйн нэгж байдлаар үйл ажиллагаагаа явуулах, үйл ажиллагаагаа сайжруулах, амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, хөгжилд оруулж буй хувь нэмрээ сайжруулах, ажилчдын эрхийг хамгаалах боломжийг олгож байна. Гэвч, эрх нэмэгдэхийн хэрээр хариуцлага ялангуяа байгаль орчин, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн болон нийгмийн үр дүнг сайжруулах хариуцлага нэмэгдсэн. Санал болгож буй үйл ажиллагаанууд нь үүрэг хүлээгчдийн үүргийг бэхжүүлэх замаар Бүтээгдэхүүн 2.3 болон 2.4-д тусгагдсан эдийн засгийн хувьд бэхжүүлэх үйл ажиллагаанд шууд хувь нэмэр оруулна.

Үйл ажиллагаа:

- Мэргэжлийн сургалтын боломжид үнэлэлт өгч, хөгжүүлэх.
- Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн салбартай хамтран

ажиллах боломжийг судалж, хэрэгжүүлэх.

- Одоо хэрэгжүүлж буй бичил болон жижиг үйлдвэрийг хөгжүүлэх санаачлагад тулгуурлан хөгжүүлэх.
- Мэргэшүүлэх үүргийг албан ёсны болгох ажлыг дэмжих.

Бүтээгдэхүүн 1.4	Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал ба эрх тэгш байдал: Ажлын байрны аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн болон хүүхэд асрах үйлчилгээг сайжруулах талаар төслийн хамтрагч түншүүдийн хөтөлбөр
Дараахь дам үр дүнгээр дамжуулан Үр дүн 1-д хувь нэмэр оруулах: Бичил уурхайчид аюулгүй ажлын байр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн болон хүүхэд асрах үйлчилгээг хүртэх эрхээ эдлэхийн зэрэгцээ жендэрийн асуудлыг БУ-н үйл ажиллагаа, шийдвэрт уялдуулан тусгасан байна.	

Хэдийгээр одоогийн байдлаар ТБУТ-өөс үр шим хүртэгсэд нь ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын хувьд ихээхэн сайжирч байгаа ч, ТБУТ нь маш аюултай, хүнд нөхцөлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй, нас бие гүйцсэн болон залуучууд, хүүхдүүдийн хувьд асар их эрсдэлтэй байгаа БУ-н нийт салбарын хувьд тулгамдаж буй эрсдлийг шийдэх талаарх оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд анхаарал хандуулах шаардлагатай. Эдгээр тулгамдсан асуудлын жендэрийн чиг хандлага болон байгууллага, албажуулалт, үйл ажиллагааг мэргэшүүлэх талаар анхаарах шаардлагатай нь тодорхой.

Дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын чиглэлээрх кампанит ажлыг сайжруулах.
- Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах талаар хэрэгжүүлж буй хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх
- Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр үүрэг хүлээгчдийн техник чадавхийг бэхжүүлж, шаардлагатай бол мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлэх.
- БУ-н олборлолтын газрын орчимд хүүхэд асрах үйлчилгээний загварыг үнэлж, хэрэгжүүлэх.
- Нийт үйл ажиллагааг жендэрийн асуудлыг үр дүнтэй тусгаж, үүрэг хүлээгчдийн жендэрийн асуудлаарх чадавхийг сайжруулах.

Бүтээгдэхүүн 1.5	Өргөдөл гомдол ба маргааныг шийдвэрлэх: Хүний эрх, ашигт малтмалын эрхийн маргааныг шийдвэрлэх механизмыг олон улсын гэрээ, сайн туршлагад нийцүүлэн бүрдүүлэх
-------------------------	---

БУ-г албажуулахад тулгарч буй гол саад бэрхшээлд уурхайн компаниуд болон бусад газар эзэмшигчидтэй гардаг газрын маргаан, уурхайчид болон Засгийн газар хоорондын үл ойлголцлыг улам бүр нэмэгдүүлдэг хүний эрхийн зөрчил зэрэг багтана. Үүнийг шийдвэрлэх албан ёсны арга нь одоо байгаа эерэг туршлага (ж.н гурван талт гэрээ) болон хүний эрх, өмчийн эрхийн талаарх хэлэлцээрт суурилах бөгөөд энэ чиглэлээрх байгууллагуудын (Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК) зэрэг) чадавхи, үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Өргөдөл гомдол, маргааныг шийдвэрлэх механизмыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Үүрэг хүлээгчдийн шаардлагатай чадавхийг бэхжүүлэх.
- БУ-н Холбоо, бүс нутгийн БУ-н байгууллагууд, БУ-н ТББ-уудыг гишүүдийнхээ маргааныг шийдвэрлэх чиглэлээр бэхжүүлэх.
- Хамтын ажиллагаа болон маргааныг шийдвэрлэхтэй холбоотой сайн туршлагыг онцлох

4.4.2 Бүрэлдэхүүн хэсэг 2-ын бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх

Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2-ын бүтээгдэхүүнүүд (Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх), нь “Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор БУ-аар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна.” (Үр дүн 2) гэсэн зорилтод хүрэхэд шууд болон явцын дунд бий болох дам үр дүнгийн аль нэгээр хувь нэмэр оруулна гэж үзэв.

Бүтээгдэхүүн 2.1	Нийлүүлэлтийн сүлжээг албажуулах: БУ-н албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний хэрэгцээ шаардлага, хэлбэр, эрхзүйн болон санхүүгийн тогтолцооны талаар гол оролцогч талууд санал нэгтэй байх ба энэ талаар албан ёсоор арга хэмжээ авах.
-------------------------	--

Дам үр дүнгээр дамжуулан Үр дүн 2-д хувь нэмэр оруулах:
Уурхайчид болон ченжүүдийн албан ёсны, хариуцлагатай, үр ашигтай нийлүүлэлтийн сүлжээнд оролцох эрх болон гол байгууллагуудын гүйцэтгэх үүргийг эрхзүйн болон санхүүгийн таатай орчинд тодорхойлсон байна.

Албан ёсны санхүүжилт, нийгмийн хамгаалал, бусад халамж дэмжлэг авах боломжгүй, санхүүгийн хувьд боломжгүй байдаг тул албан бус байдал нь уурхайчид, ченжүүдийн нийлүүлэлтийн сүлжээн дэх эрхийг бүх шатанд хэрэгжүүлэх явдлыг хязгаарлагдмал болгодог. Ил тод байдал хангалтгүй байх нь БУ-аас орон нутаг болон улс орны хөгжилд оруулж буй чухал хувь нэмрийг тодорхойгүй болгож, бодлого боловсруулагчид хангалттай, бүрэн мэдээлэл байхгүйгээс болж БУ-г албажуулах явдлыг хязгаарлан эдийн засагт оруулах хохирлын эрсдлийг бий болгодог.

Үйл ажиллагаа:

- Албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээний талаар олон улсын сайн туршлагад суурилсан баримтад тулгуурласан хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлэх.
- Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээ нь Монголын макро эдийн засгийн хөгжилд оруулж чадах хувь нэмрийн талаар мэдээллээр ханган, олон нийтийн харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээний талаар бодлогын хэлэлцүүлэг хийхэд дэмжлэг үзүүлэх.
- Нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг эдийн засгийн үр ашигтай, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээг бий болгох эрхзүйн болон санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх талаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх.
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг эдийн засгийн үр ашигтай, хариуцлагатай, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд БУ-р олборлосон ашигт малтмалыг ихээхэн хэмжээгээр худалдаалах боломжийг бүрдүүлэх эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

Бүтээгдэхүүн 2.2	Нийлүүлэлтийн сүлжээний уян хатан байдал: Бичил уурхайчид албан ёсны, хариуцлагатай, эдийн засгийн хувьд ашигтай нийлүүлэлтийн сүлжээнд орсон байна.
-------------------------	---

Одоогийн байдлаар, уурхайчид албан ёсны зах зээлд орох нэг л боломж байгаа нь Монгол банкинд алтаа шууд худалдах явдал боловч энэ нь ашгийн болон аюулгүй байдлын үүднээс авч үзвэл ихээхэн боломжгүй юм. Энэхүү албан ёсны зах зээлийн сувгийг өөрчлөх боломжууд байгаа бөгөөд ингэж зах зээлд албан ёсны нэмэлт гарцыг бий болгосноор уурхайчдын хувьд эдийн засгийн сонголт, эрх чөлөөг сайжруулах юм. Илүү их өрсөлдөөн, илүү сайн эрхзүйн боломж нь нийлүүлэлтийн сүлжээний эдийн засгийн амьдрах чадварыг сайжруулан, орон нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд илүү их хувь нэмэр оруулах боломжтой болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудад зах зээлд хүрэх олон замуудын талаарх нөлөөллийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- Монголын хувьд нэмүү өртөг бий болгох уламжлалт болон уламжлалт бус экспортын боломжийг нээх.
- Нийлүүлэлтийн сүлжээг албажуулах боломжийн найдвартай загварыг туршихад дэмжлэг үзүүлэх

Бүтээгдэхүүн 2.3	Эдийн засгийн сонголт ба эрх чөлөө: Уул уурхайтай холбоо бүхий бизнесийн янз бүрийн загваруудыг БУ-н ТББ-уудад хүргэнэ.
-------------------------	--

Дам үр дүнгээр дамжуулах Үр дүн 2-т хувь нэмэр оруулна:

БУ-н байгууллагууд болон БУ-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талууд өөрсдийн бизнесээ хөгжүүлж, худалдааны чадамж бэхжин, чөлөөт зах зээлд нэвтрэх чадавхитай байна.

БУ-н байгууллагууд болон БУ-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудыг дэмжсэнээр уурхайчид болон худалдаа эрхлэгчид албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний талаар нөлөөлөх үйл ажиллагааг хамт хийх, том уурхай болон БУ-н хамтын ажиллагаанд БУ-н байгууллагуудын болон орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх асуудлыг багтаана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БУ-н байгууллагууд болон худалдаачдыг

тэдний аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадамжийг сайжруулахын зэрэгцээ экологид үзүүлэх нөлөөг хамгийн бага байлгах, нийгэм болон эдийн засагт үзүүлж байгаа эерэг үр нөлөөг бэхжүүлэх, гарч болзошгүй гуравдагч талд үзүүлэх сөрөг үр нөлөөг бууруулахад чиглэсэн оновчтой, чанартай сургалтад хамруулах явдлыг хангах.

- Бүх оролцогч талууд хэрхэн БУ-н хөгжлийн боломжийг нэмэгдүүлэх хариуцлагатай уурхайн нөөцийг бүрдүүлж болохыг тодорхойлох, үнэлэх, хэрэгжүүлэх
- БУ болон том уурхайн аль алинд нь ашигтайгаар “хамтран ажиллаж буй” амжилттай жишээг өргөжүүлэх, түгээх.
- Ашигт малтмалын бүтээгдэхүүн баяжуулагчид болон худалдан авагчдын (баяжуулах цех, ченжүүд, НТР зэрэг алт цэвэршүүлэх салбар компани, арилжааны банк болон бусад) албан ёсоор, хуулийн хүрээнд, ашигтай ажиллах чадавхийг бэхжүүлэх.

Бүтээгдэхүүн 2.4	Орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх: БУ-н байгууллагууд болон худалдаа эрхлэгчид орон нутгийн амьжиргааг сайжруулах, эдийн засгийг өргөжүүлэх, амьдрах чадвартай болгоход оруулах хувь нэмрээ нэмэгдүүлэх чадавхитай болж, оролцогч талууд энэ хувь нэмэр, үр дүнгийн талаар мэддэг болсон байна.
-------------------------	---

Ашигт малтмалын олборлох, баяжуулах, худалдах үйл ажиллагаа нь орон нутгийн эдийн засгийн өсөлтийн чухал өдөөгч байдаг. Хэрэв оролцогч талууд орон нутгийн эдийн засагт БУ-н байгууллагууд болон худалдаа эрхлэгчдийн оруулж буй хувь нэмрийн талаар мэдэхгүй байвал үйл ажиллагааны сөрөг үр нөлөөний талаар илүү анхаарч, үр дүнгийн талаарх тэнцвэргүй ойлголтыг бий болгоно. БУ нь хувь хүн, гэр бүл, сум, аймаг болон улс орны хэмжээнд ямар боломж ба сорилтуудыг бий болгодог, тэдгээрийн эерэг болон сөрөг үр дагаврын талаарх тэнцвэрт байдлыг хангасан харилцаа нь үүрэг хүлээгчид болон эрх эдлэгчдэд шийдвэр гаргахдаа одоогийнхтой адилгүй, илүү бодитой, бүрэн бүтэн мэдээлэлд үндэслэн гаргах боломжийг хангаж байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БУ эрхэлдэг айл өрх, хамт олны хувьд БУ-тай холбоотой бизнесийн боломжийн өөр нэмэлт хувилбаруудыг тодорхойлж, хэрэгжүүлэх.
- Уурхайчид, нийлүүлэлтийн сүлжээг ажиллуулагчдын бизнесийн амжилтаа

бататгах чадавхийг бэхжүүлэх.

- БУ-г орон нутгийн хөгжлийн бодлогын замаар эдийн засгийг бэхжүүлэх ойлголт, боломжийг үнэлж, хэрэгжүүлэх.
- Гуравдагч талууд БУ нь орон нутгийн эдийн засгийг хөгжүүлээд хэрхэн хувь нэмэр оруулж байгаа, БУ-н үр нөлөөг бодитой үнэлэх явдлыг хангах сөрөг ба эерэг үр нөлөөний тэнцвэрийг зөв тогтоох байдлаар олон түвшинд (сум, аймаг, улс орны хэмжээнд) оновчтой, хамгийн нөлөө бүхий харилцаа холбооны сувгаар дамжуулах мэдээлэл боловсруулж, нийтлүүлэх.

4.4.3 Бүрэлдэхүүн хэсэг 3-ын бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа: Мэдлэг, туршлага солилцох, БУ-н олон улсын бодлогын хэлэлцүүлэг

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын Бүтээгдэхүүн (Мэдлэг, туршлага солилцох ба БУ-н талаарх олон улсын хэлэлцүүлэг) нь “Монгол Улсын оролцогч талууд БУ-тай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь БУ-н салбарт олон улсын түвшинд манлайлагч байна.” гэсэн үр дүн (Үр дүн 3)-д хувь нэмэр оруулна.

Бүтээгдэхүүн 3.1

Мэдлэгийн менежмент ба түгээх: Сайн туршлагын мэдлэгийн төвийн үйл ажиллагаа эхэлсэн байна.

Мэдээлэл бол эрх мэдэл. Нийгэм болон хүний нөөцийн Мэдлэгийн төвийг хамгийн гол ач холбогдол бол хүмүүс төслийн зорилтод хүрэхэд чухал тогтвортой үр дүнг бий болгох ул суурьтай шийдвэр гаргахад илүү мэдээлэлтэй болох явдал юм. Мэдлэгийн төв нь дараахь зүйлсийг багтаасан байна. Үүнд: а) ижил ашиг сонирхолтой, харилцан адилгүй туршлага бүхий хувь хүмүүс, байгууллагуудын хөдөлгөөнт сүлжээ, б) хүртээмжтэй, уялдаатай, хэрэгцээтэй, авах боломжтой чухал бөгөөд үнэн зөв мэдээллийн урсгал бөгөөд, хүмүүс энэ талаар болон хэрхэн хэрэглэх талаар мэддэг, с) Мэдлэгт суурилсан үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх мэдлэгийн төвийн менежер, d) мэдээллээс суралцах, солилцох явдлыг дэмжих, харилцааны хэлбэрүүд байна. Мэдлэгийн төвийн санал болгож буй хэлбэр, шинж чанарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 8-аас харна уу.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Мэдлэгийн төвийг байгуулах талаар зөвлөгөө өгөх гадны зөвлөх үйлчилгээг худалдан авах.
- Төслийн эхнээс нь хэрэгжилтийн явцад болон төгсгөлийн үед мэдлэгийн төвийн эрх мэдэл, хэлбэрийг батлах.¹⁸
- Үр дүн 1 ба 2-ын үйл ажиллагаа болон Бүтээгдэхүүн 3.4-тэй холбоотой зардал багатай байх, санхүүгийн хувьд тогтвортой байх, эзэн байх, ашиглалтын эрх, харилцааны стратеги зэрэг Мэдлэгийн төвийн бизнес төлөвлөгөөг боловсруулах.
- Мэдлэгийн төвийн зохицуулагчийг өөрчлөх, сонгох авах журам.
- Мэдээллээс суралцах, солилцох болон харилцааны талаар чиглүүлэх сүлжээ, харилцаа холбоог бүрдүүлэх.
- Мэдлэгийн төвийн гол чиг үүрэг, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх боломжтой түншүүдийг тодорхойлох, оролцуулах.
- Олон улсын болон Монголын БУ-н оролцогч талуудын өргөн хүрээ нь мэдлэгийн төв хэрхэн ажилладаг, хэрхэн хувь нэмэр оруулж, ашигладаг, өргөжүүлдэг, хэрхэн эзэн болж байх, ийм сүлжээ байгаа талаар бахархах асуудлыг ойлгож, мэддэг байх явдлыг хангах.

Бүтээгдэхүүн 3.2

Сайн туршлага хуваалцах: Монголын оролцогч талууд улс орны болон олон улсын БУ-н салбарт утга төгөлдөр байдлаар оролцон, харилцаж мэдлэг, туршлага болон ур чадвараа солилцоно.

Нүүр тулан буюу биечлэн оролцож суралцах (ж.н шинэ технологийн нүдээр үзэж танилцах эсхүл туршлагаас нь суралцахаар оролцогч талтай уулзах)-аас гадна төслийн зүгээс аль болох их хэмжээгээр алсын зайнаас суралцах (бичил уурхайчдад “дигитал аргаас хоцрогдсон” байх явдлыг давахад нь дэмжлэг үзүүлэх) боломжийг нэмэгдүүлэх нь чухал байна. Хөдөлгөөнт техникийг ашиглах замаар вэб-хурал, интернэтээр харилцах зэрэг нь чадавхийг бэхжүүлэх үр дүнтэй арга болж чадна.

¹⁸ Хавсралт 8, 1 дэх хэсгээс “ТБҮТ-ийн хүрээнд авсан сургаамж” зэрэг одоо хэрэгжиж буй мэдлэг туршлага солилцох санаачлагын талаар хийс эн дүн шинжилгээг харна уу.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БУ-н мэдлэг, туршлага солилцох гол боломжууд болон Монголын болон олон улсын холбогдох талуудын оролцоог дэмжихэд тэргүүлэх ач холбогдол өгөх.
- Монгол Улс сайн туршлага болж чадах асуудлаар болон Монгол Улс олон улсын туршлагаас хүртэх боломжтой чиглэлээр олон улсын хурал зохион байгуулах, мэдээлэл нийтлэх.
- БУ-н асуудлаар ижил ашиг сонирхол нь хөндөгдөж буй дотоодын бүлгүүдийн хоорондын албан ёсны болон албан бус оролцоо, мэдээлэл солилцох явдлыг бэхжүүлэх.
- Монголын БУ-н талаар илүү судалгаа хийх, БУ-н чиглэлээр ажиллах сонирхол бүхий мэргэжилтнийг хөгжүүлэх явдлыг дэмжихийн тулд гадны оюутан, эрдэмтдийг Монгол улсад, Монголын эрдэмтэд, оюутнуудыг гадаадад танилцах аялалд явуулах, энэ талаар нийтлэх.

Бүтээгдэхүүн 3.3	Ижил төрлийн байгууллагууд бие биеэсээ суралцах: Хөгжиж буй орнуудын Бичил уурхайчид, зохицуулагчид болон БУ-тай холбоотой иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-ын харилцан суралцах сүлжээ бий болно.
------------------	---

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Мэдлэгийн төв нь хөгжиж буй орнуудын бичил уурхайчид, зохицуулагчид хоорондоо харилцан суралцах сүлжээг хэрхэн бий болгож болохыг тодорхойлох.
- Улс орнуудын уурхайчид үйл ажиллагаагаа сайжруулахад эрх мэдэл, санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг туршлага, сорилт, шийдлийг хэлэлцэх зорилгоор зөвхөн уурхайчид оролцсон бага хурал зохион байгуулах.
- Монголын бичил уурхайчид, зохицуулагчид, ИНБ-ууд БУ бүхий бусад оронд очих солилцооны ажлыг зохион байгуулах.
- Бусад орнуудын уурхайчид, зохицуулагчид, ИНБ-ын төлөөлөл Монголд ирж танилцах аяллыг зохицуулж, зохион байгуулах.

Бүтээгдэхүүн 3.4	Үйл ажиллагааны тогтвортой байдал: Өмнө хүрсэн амжилт, цаашдын сорилтын талаар мэдээлэл, санал солилцох механизм бүрдэнэ.
------------------	--

Энэ бүтээгдэхүүн нь эерэг мэдээлэл, санал солилцох механизмыг Өөрчлөлтийн онолд тусгах зорилготой (4.2 дугаар хэсэг). Түүнчлэн Мэдлэгийн төвийн “мэдээлэл солилцох, харилцах асуудлыг чиглүүлж, суралцах, харилцан хуваалцах үйл ажиллагаа” гэсэн 4 дэх бүрэлдэхүүн хэсэгт хамааралтай.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- БУ-д хамааралтай нийгмийн хэсэг, БУ-н салбарын үүрэг хүлээгчдэд (орон нутгийн захиргаа, парламент, яамд) хүрч ажиллах талаар Монгол Улсын хүрсэн амжилт (болон томоохон сорилтууд)-ыг улс орны хэмжээнд таниулан ойлгуулах стратеги боловсруулах.
- Монголын тогтвортой БУ-н манлайлагчид болон бусад оролцогч талуудтай сургамж, туршлага солилцсон шилдэг шинийг санаачлагчдыг шагнах жилийн шагнал гардуулах арга хэмжээ зохион байгуулах.
- Монголын хүрсэн амжилт, жендэр, хүний эрх зэрэг чиглэлээр олон улсын хэмжээнд үр дүн бий болгох талаар санал болгох, боломжууд юу байгааг тодорхойлох, эдгээрийг бусад улсад түгээх боломжийг тодорхойлох.
- БУ-н олборлолтын газарт очиж танилцах, БУ-н бусад арга хэмжээ зохион байгуулах замаар Монгол Улсын өвөрмөц онцлог бүхий БУ-н салбар, түүний хүрсэн амжилтыг бусад улсад таниулах.

Бүтээгдэхүүн 3.5	Давтамж: Авсан сургамжийг олон улсын хэмжээнд дэлгэрүүлэн өргөжүүлэх механизмыг бүрдүүлнэ.
------------------	---

Энэ нь бусад оронд хүний эрхэд суурилсан БУ-н салбарыг хөгжүүлэх улмаар хөгжлийн хөдөлгөгч хүч болгох талаарх ойлголтыг бэхжүүлж, энэ талаар ахиц өөрчлөлт гаргах зорилготой. Түүнчлэн, бусад улс орны эерэг (болон сөрөг) туршлагын талаар мэдээлэл бий болгох ба энэ нь цаашид Монголын хувьд БУ-н салбарт шинэ сорилтууд тулгарахад хэрэгцээтэй болж болно. Латин Америкийн улсуудтай хамтран ажиллах, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх Азийн улс орнуудын сонирхол зэрэг Монгол Улс өөрөө хувь нэмэр оруулаад эхэлсэн хөгжиж буй орнуудын хооронд БУ-н салбар дахь өнөөгийн харилцааг бэхжүүлэх нь сургамж, туршлага солилцох чухал боломж бөгөөд үүнийг Мэдлэгийн төвийн боломжийн хувьд тэргүүлэх чиглэл болгох нь зүйтэй. Мэдлэгийн төвийн чиг үүргийг дотоодын болон олон улсын түншүүдэд цагаа олж шилжүүлэх нь дахин давтан хэрэгжүүлэх явдлын чухал асуудал юм.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хариуцлагатай БУ, БУ-аас нөөц олох, БУ-н оролцогч талуудын хүний эрхийг хэрэгжүүлэх чиглэлээрх олон улсын санаачлагыг дэмжих.
- Эдийн засгийн тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан БУ-н салбарыг бий болгох чиглэлээр ажиллаж буй олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа, суралцах үйл явдлыг зохицуулах.
- Төслийн ажилтнууд солилцох, зөвлөгөө үзүүлэх зэргээр БУ-н шинэ төсөл, санаачлагыг дэмжих.
- БУ-д ХЭСХ-ыг хэрэгжүүлэхэд авсан сургамжийг системчлэх.
- БУ-н Мэдлэгийн төвийн тогтвортой байдлыг хангах санхүү, улс төр, нийгмийн хөрөнгө нөөцийг бий болгохын тулд стратегийн болон бодлогын түвшин ажиллах байгууллагуудын болон Монголын ба бусад орнуудын БУ-н санаачлагын үйл ажиллагааг зохицуулах механизмыг бүрдүүлэх.

4.5 Зорилтот бүлэг ба тэдэнд хүрч ажиллах

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн гол үр шимийг хүртэгсэд нь бичил уурхайчид ба БУ-н байгууллагууд байна (БУ-н Холбоо, бүс нутгийн БУ-н холбоод, БУ-н ТББ, ирээдүйд БУ-н аж ахуйн нэгжүүд бий болно гэж үзэж байна). Гол зорилтот бүлэг нь БУ-н байгууллага, БУ-н олборлолтын газар дахь хүмүүс байх ба эдгээр нь "өөрчлөлтийн хөдөлгөгч" болох үүргээ биелүүлэх тал дээр эерэг өөрчлөлтийг гаргасан ба БУ-н манлайлагчид (3,000-5,000 уурхайчдад хамааралтай) байна. Төслийг үргэлжлүүлснээр улс орны бусад хэсэгт ажиллаж буй уурхайчдад (15,000-20,000 уурхайчид) хүрч ажиллах боломжтой.

Гол зорилтот бүлэгт үүрэг хүлээгчид мөн багтах (ж.н УУЯ, АМГ-ын БУ-н тасаг, ХЯ, ЭМСЯ, ХАХНХЯ-ны холбогдох нэгж, орон нутгийн захиргааны холбогдох байгууллагууд) ба чиг үүргийг тодорхой тогтоож, шаардлагатай чадавхийг бэхжүүлсний дараа эдгээр нь улс орны хэмжээнд эрхзүй, байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрхийн чиглэлээр бий болох үр дүнг тогтворжуулах, өргөжүүлэх үүрэгтэй байна.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын гол үр шимийг хүртэгсэд нь нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчид байна (бичил уурхайчид, БУ-н байгууллага, үйлдвэрлэгчид, ченжүүд болон улсын нөөцийн сан).

Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2-ын үр шимийг хүртэгч дараагийн шатны этгээд нь нийт БУ-н салбар байна, өөрөөр хэлбэл БУ-чдын гэр бүл, бизнесийн түнш (хөрөнгө оруулагчид), БУ-тай холбоотой бусад бизнесүүд, орон нутгийн иргэд байна¹⁹. БУ-н албан ёсны эдийн засгийн үйл ажиллагааны үр ашиг, улсын сан хөмрөгт алтны оруулах хувь нэмэр нэмэгдэх зэргээр гуравдагч үр шим хүртэгсэд нь төр, Монголын нийт хүн ам байна. БУ илүү хариуцлагатай болж, мэргэшснээр Том хэмжээний уурхайн хүлээх хариуцлага багасч, гэрээгээр хамтран ажиллах илүү сайн түнштэй болон, илүү их алт авах, худалдах боломжтой болж үр шим хүртнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын үр шимийг хүртэгсэд нь маш өргөн, олон тооны байна! Үүнд Монголын БУ-н оролцогч талууд (нийлүүлэлтийн сүлжээний оролцогч, БУ-н бизнес түншүүд, БУ-н зохицуулагчид, орон нутгийн иргэд, сайн туршлагыг түгээгч мэргэжилтнүүд) багтах ба БУ-н олон улсын оролцогч талуудын өргөн хүрээний ангиллыг хамарна. Тодруулбал, нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талууд, Монгол ба бусад орны үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагууд нь зохицуулалтын таатай орчин, илүү амжилттай, хариуцлагатай БУ-н бизнест шаардлагатай мэдээллийн хүртээмж сайжирснаас үр шим хүртэнэ. Эдийн засгийн чадамжтай БУ-н байгууллагууд илүү хариуцлагатай уурхайн технологи хэрэглэх, үр нөлөөг илүү тогтвортой удирдан, жендэрийн тэгш бус байдал, хүний эрхийн зөрчлийг шийдэх талаар илүү чадавхтай болно. Хоёрдогч үр шим хүртэгсдэд байгаль орчин зэрэг БУ-н хор хөнөөлтэй арга ажиллагааны нөлөөнд өртсөн гуравдагч тал багтана. Бүрэлдэхүүн хэсэг 3-ын бусад үр шим хүртэгсэд нь олон улсын бодлого боловсруулагчид, хандивлагчид, бусад орны оюутнууд, их сургууль, БУ-н нийлүүлэлтийн сүлжээний талууд байна.

Нийт бүрэлдэхүүн хэсгийн гол зорилтот бүлэг нь УИХ-ын гишүүд байх ба тэд үр дүн бий болоход үндсэн гол үүрэгтэй, БУ-н эрхзүйн болон санхүүгийн тогтолцооны цаашдын үр дүнд маш чухал байна. УИХ-ын гишүүдэд стратегийн түвшинд хүрч ажиллахыг БУ-н Холбоо зохицуулж ажиллах ба урт хугацаанд, тогтвортой үр дүн бий болгохыг зорино. Мэдлэг, туршлага солилцох үйл ажиллагаа нь салбарын талаарх сэтгэлгээний өөрчлөлт бий болгоход чухал болох нь харагдсан.

¹⁹ Байгууллын хувьд Иргэдийн хурлаар төлөөлүүлэв.

4.6 Оролцооны түвшин

ТБУТ нь 4 дэх үе шат хэрэгжих хугацаанд тэргүүлэх чиглэлээ аажмаар өөрчлөн, микро, месо, макро, мета түвшинд оролцоно. Төслийн ХЭСХ-тай холбоотой үр нөлөөг тодорхойлсноос харахад, үүрэг хүлээгчид нь эмэгтэй, эрэгтэй уурхайчдад үйл ажиллагаагаа албажуулах, сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр өөрсдийн хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх хариуцлагаа нэмэгдүүлнэ. Ингэснээр, төсөл аажмаар микро түвшинд оролцохоо больж, нөөц бололцоогоо месо түвшинд байгууллын чадавхийг бэхжүүлэхэд болон макро түвшинд бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд зарцуулах болно.

Микро түвшинд, ТБУТ нь эрх эдлэгчдийг илүү эрх мэдэлжүүлж, бичил уурхайчид болон нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудтай шууд хамтарч ажиллана. Уурхайчид болон орон нутгийн удирдлагуудтай хамтран ажилласнаар орон нутгийн болон уурхайчдын чадавхийг бэхжүүлнэ. Төслийн 4 дэх үе шатны явцад ийнхүү шууд хамтран ажиллах нь аажмаар багасч, үүний оронд үүрэг хүлээгчид өөрсдөө шууд оролцох явдал нэмэгдэнэ.

Месо түвшинд, ТБУТ нь бүс нутгийн болон орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийн байгууллагууд (БУ-н нөхөрлөл ба ТББ, БУ-н Холбоо, худалдаа эрхлэгчдийн байгууллага), иргэний нийгмийн байгууллагууд, БУ-н үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажиллана. Байгууллын хувьд бэхжүүлэхдээ БУ-н салбарын асуудлуудыг шийдэхэд идэвхтэй, чөлөөтэй, утгатай оролцоог бий болгож, төсөл дууссаны дараа ч ахиц, үр дүнг тогтвортой байлгахад үүрэг хүлээгчдийн үүргийг албажуулахыг зорино. Энэ нь ХЭСХ-ын үйл явц бөгөөд өөрөө нэг бүтээгдэхүүн болно.

Макро түвшинд, ТБУТ нь үүрэг хүлээгчидтэй хамтран ажиллаж, тэдний чадавхийг бэхжүүлэн, бодлого боловсруулагчид ба хэрэгжүүлэгчдэд зөвлөгөө өгч ажиллана. ТБУТ, зарим үед ШХА нь ижил бодлого, үйл ажиллагаатай хандивлагчид, төслүүдтэй шууд хамтарч ажиллах ба түнш болох УУЯ, АМГ, бодлогын гол оролцогч талуудтай БУ-н бодлогын хэлэлцүүлэгт оролцуулах замаар бэхжүүлнэ.

Мета түвшинд (улс орны хүрээгээр үл хязгаарлагдан), ТБУТ нь сайн туршлага, байгаль орчны менежмент, аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалал, бусад асуудлын талаарх холбогдох мэдээллийг бий болгож, мэргэжилтнүүд болон туршлагаас суралцах боломжийг бүрдүүлэх, БУ-н нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрхийг хэрэгжүүлэх явдлыг эрчимжүүлэх олон улсын бодлогын болон суралцах орчинг хангахын тулд БУ-н ажлын хэсэг, олон улсын хуралд оролцох зэргээр түгээх болон эрх эдлэгчид, үүрэг гүйцэтгэгчид, тэднийг боломжоор хангаж байдаг этгээд зэрэг БУ-н оролцогч талуудын суралцах явдлыг дэмжинэ. Эдгээр үйл ажиллагаа нь олон улсын зах зээл дэх хариуцлагатай олборлосон ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх бөгөөд ингэснээр хариуцлагатай нөөцийн зах зээлийн санаачлагуудын үйл ажиллагааг дэмжин хэрэглэгчдэд илүү тогтвортой ашигт малтмалын сонголтыг бий болгоно.

5. Хэрэгжүүлэх стратеги

5.1 Төсөл хэрэгжүүлэх арга

ТБУТ нь Засгийн газарт зөвлөгөө өгөх болон эрх эдлэгчдийн зүгээс үүрэг хүлээгчдэд өөрсдийн шаардлагаа тавихад зуучлагч болж ажиллах хос үүрэгтэй байна. ТБУТ нь эрх эдлэгчдийн эрхээ шаардах чадавхийг бэхжүүлэх, хүний эрхийг хангаснаар хөгжилд хүргэх үүрэг хүлээгчдэд дэмжлэг үзүүлнэ. ТБУТ нь алдаа гажуудал гарч буй эсэхэд тогтмол хяналт тавьж, үүрэг гүйцэтгэхэд гарч буй асуудлыг шийдэх юм. Алдаа гажуудлыг арилгах арга хэмжээ нь холбогдох зарчмын дагуу хийгдэнэ.

ТБУТ-ийн 4 дэх үе шат нь ШХА-ийн хамтын ажиллагааны шинэ стратегид²⁰ нийцүүлэн уялдуулахад дараахь стратегийн өөрчлөлтийг хэрэгжүүлнэ:

- Урт хугацааны үр нөлөөг бий болгох зорилгоор байгууллын чадамж, төслийн түншүүдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор улс орны тогтолцоонд илүү уялдуулан нийцүүлэх.
- Өөрөө хэрэгжүүлэхээ болихын тулд төслийн түншүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэднийг төсөл хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцуулах шаардлагатай. Үүний тулд төсөл улс төрийн шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх түвшний хоорондын зохицуулалт шаардлагыг сайжруулах шаардлагатай.
- Бодлогын хэлэлцүүлэг явуулахдаа соёлын хэм хэмжээ, үндэсний тусгаар тогтнолыг хүндлэхийн хамт хамтрагч талуудыг ятгах хэлбэрээс олон улсын эрхийн үүрэг

хариуцлагын дагуу хүлээсэн үүргээ сайн биелүүлэхийг чухалчлахыг ойлгуулах хэлбэрт шилжих хэрэгтэй.

- Төслийн хэрэгжилт нь микро түвшинд үйл ажиллагаа явуулдаг байдлаа (ж.н ТБУТ-ийн баг БУ-чидтай ажиллах) өөрчлөн месо, макро түвшинд үйл ажиллагаагаа зохицуулан, хяналт тавихад шилжинэ. Төслийн түншүүд энэ чиглэлээр бэлтгэгдсэн байх хэрэгтэй бөгөөд ийм өөрчлөлт бага багаар гарна.
- Төслийн зохицуулах нэгж (ТЗН)-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь төслийн ажилтнуудын зүгээс удирдах болон хэлэлцээр хийх ур чадвараа сайжруулахыг шаардана. ХЭСХ, жендэрийн сургалт зайлшгүй чухал.

Төсөл болон оролцогч талуудын бүлгийн хоорондын итгэлцлийн харилцааг төслийн оролцогч талуудын бүлгүүдийн хоорондын итгэлцлийн харилцаа болгон шилжүүлнэ. Сүүлийн 10 жилийн хугацаанд төсөл оролцогч бүх талуудын итгэлийг олж авсан. БУ-н асуудлаарх байгууллага хоорондын зохицуулалт нь ТБУТ-ийн хүрээнд хийгдэх болсон. Хэдийгээр энэ нь ТЗН-ийн бүтэц руу шилжих явдлын дэмжиж буй ч энэ нь төсөл төвд байх явдлаас үр дүнтэй больж, энэ чиг үүргийг бусад оролцогч талууд гүйцэтгэх тогтвортой байдлыг бий болгох нь чухал. ТЗН-ийн сайн үйл ажиллагаа гэдэг нь төсөл зохицуулах үүрэгтэй байна гэсэн үг биш харин төсөл оролцогч талуудын хоорондын харилцааг зохицуулахад дэмжлэг үзүүлнэ гэсэн үг. Үүний тулд, оролцогч талуудтай харилцах нөлөөлөлд автоагүй, нэг талыг баримтлаагүй байх, оролцогч талуудын зохицуулалтын чадавхийг ийм байдлаар бэхжүүлэх нь төслийг улс төрийн арга хэрэгсэл болохоос сэргийлэхэд зайлшгүй чухал.

Мэдлэг, туршлага солилцох бүрэлдэхүүн хэсгийн зарим үйл ажиллагаа нь төслийн

²⁰ ШХА: Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратеги (2013–2016). Улаанбаатар, 2013 оны 2 дугаар сар.

зүгээс шууд хэрэгжүүлэхийг шаардана. Энэ бүрэлдэхүүн хэсгийг улсын тогтолцоонд нийцүүлэх олон улсын мэдлэг туршлага солилцох идэвхтэй үүргийг Монголын холбогдох байгууллага гүйцэтгэж буй нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой байна. Хэрэв нөхцөл байдал ийм бус байвал, хэрэгжүүлэх үүргийг ШХА, үндэсний болон олон улсын түншүүд шууд хариуцах хэрэгтэй болно.

5.2 Түнш байгууллагууд, тэдний үүрэг ба хариуцлага

Уул уурхайн яам (УУЯ) нь ашигт малтмалын салбарыг хөгжлийг хариуцдаг гол байгууллага. Тус яам нь төрийн болон төрийн бус байгууллагуудыг зохицуулах замаар БУ-н бодлого, эрхзүй болон тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавихад гол үүрэгтэй байна. УУЯ нь лиценз олгох, зохицуулах, хэрэгжүүлэхээс гадна геологийн судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий АМГ, уурхайн аюулгүй ажиллагааг хангах асуудлыг хариуцсан УУАА зэрэг гол хэрэгжүүлэгч нэгжүүдийг хариуцан ажилладаг. АМГ-ын БУ-н тасаг нь бичил уурхайчид, тэдний байгууллага, орон нутгийн захиргаанд БУ-тай холбоотой эрхзүй, техник, байгаль орчин, эрүүл ахуй, орон нутгийн хөгжлийн асуудлаар техник зөвлөмж өгч, орон нутгийн захиргаа болон АМГ-ын лицензийн албатай хамтран ажиллаж, БУ-чдад газар олгох талаар дэмжиж ажилладаг.

ТБУТ нь эхлээд хэрэгжүүлэх улмаар зохицуулалтын үүргээ аажмаар шилжүүлэх хэрэгтэй. Энэ үүднээс, гол түнш байгууллага, тэдний гүйцэтгэх үүрэг нь дараахь асуудлыг хамарна:

- **ТБУТ-ын албан ёсны хамтрагч нь** Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж УУЯ, Швейцарийн Засгийн газрыг төлөөлж ШХА байна. УУЯ нь Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газар, БУ-н нэгжээр, дамжуулан БУ-н бодлого, хууль тогтоомж боловсруулах; АМГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж зохицуулах; дор дурдсанчлан УУЯ болон АМГ, болон бусад гол хамтрагч талуудын үйл ажиллагааг зохицуулах гол үүрэгтэй. Үүрэг хариуцлага, ялангуяа байгууллага хоорондын зохицуулалтын үүрэг нэмэгдсэнээр УУЯ-ны БУ-н Зохицуулалтын нэгж байгуулах хэрэгтэй болно.
- **Хэрэгжүүлэлтийн шатанд, ТБУТ нь АМГ болон түүний БУ-н тасагтай нягт хамтарч ажиллана.** Төсөл хэрэгжүүлэх дийлэнх чиг үүргийг БУ-н тасагт шилжүүлж улмаар гол үүрэг хүлээгчдийн эрх мэдлийг нь нэмэгдүүлэн, чадавхи болон нөөцийг

бэхжүүлэх хэрэгтэй болохыг төсөлд онцлон тусгасан.

БУ-н Холбоо нь нөлөөллийн болон лобби хийх үүргийн хувьд чухал амжилтад хүрсэн бөгөөд уурхайчид, тэдэнд үзүүлэх үйлчилгээ, зохион байгуулалт, зохицуулалтыг сайжруулахад чухал ач холбогдол өгч ажилладаг. Холбоо нь төслийн хэрэгжилтийн явцад бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд төслийн гол түнш байгууллага байна.

Тогтвортой БУ-н нийтлэг олон салбарыг хамарсан, эрх мэдлийн хувьд тулгамдсан сорилтууд нь эрүүл ахуй, ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн хамгаалал, жендэр, байгаль орчин, бизнесийн хөгжил зэрэг хүний эрхийн асуудлаас эхэлнэ. ХЯ, ХАХНХЯ, ЭМСЯ, ХЭҮК нь эрхзүйн өөрчлөлт болон байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулах зэргээр дэмжиж ажиллаж байгаа бөгөөд сум, аймгийн холбогдох агентлагуудын ажил хариуцсан ажилтнуудыг сургалтад хамруулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр бодлогын болон хэрэгжилтийн шатанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Түүнчлэн төсөл хэрэгжүүлэхэд чухал түнш байгууллага нь аймаг, сумдын захиргаа байх ба эдгээр нь албажуулах болон орон нутгийн хөгжлийн асуудал хариуцсан гол оролцогч тал бөгөөд БУ-чдад газар олгох, уурхайчдад үзүүлэх үйлчилгээ зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх боломжийг илрүүлэхэд илүү анхаарах замаар Монгол банк, Сорьцын хяналтын алба (СХА)² худалдааны сүлжээг албажуулах, шударга зах зээлд орох боломжийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Азийн сан ТБУТ-ийн чухал хамтрагч байх ба тус сан нь ШХА-аас хамтран дэмжлэг үзүүлдэг БОХОТХ төслийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлдэг. Хариуцлагатай уул уурхайн байгаль орчны ихэнх асуудал (ялангуяа бичил уурхайн олборлолтын газрын нөхөн сэргээлт болон мөнгөн ус ашиглалтын хэмжээг бууруулах)-ыг БОХОТХ төслийн 2 дахь үе шат тусгасан бөгөөд үр дүн, уялдаа холбоо, сургамжаа харилцан солилцох явдлыг сайжруулахад нягт хамтын ажиллагаа маш чухал.

Дотоодын болон олон улсын хэд хэдэн ТББ, ИНБ нь бичил уурхайчид, тэдний байгууллагыг эрх мэдэлжүүлэхэд чухал хамтрагч, түнш болохоо харуулсан Жишээ нь Монголын Эмэгтэйчүүдийн ТББ-ын сүлжээ, Хүний эрх хөгжил төв, Хүний эрхийн ТББ-уудын форум гэх мэт. Олон улсын хэд хэдэн байгууллагууд (ж.н Дэлхийн зөн, Мерси Кор, АДРА) БУ-н асуудал нь тэдний хүний эрх, хөгжлийн талаарх үйл ажиллагааны чиг үүрэгтэй уялдаатай холбоотой байгааг

харсан бөгөөд төслийн хүрээнд ХЭСХ-ыг тусган ажиллахад илүү анхаарал тавьж үр дүн гаргахаар ажиллаж байна. Хөгжлийн шийдэл ТББ-ын түншүүд болон зарим талаар судалгааны байгууллагууд байгууллага, аж ахуйн нэгж, техник болон байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай агуулгад нийцсэн шийдлийг боловсруулахад ихээхэн үр дүн гаргаж ажилласан.

Хэдийгээр ийм байгууллагууд үүрэг хүлээгчид болон БУ-н оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байх боловч тэдний энэхүү хүчин чармайлтын ихэнх нь эрэлтэд суурилсан байдаг. Иймээс тэд БУ-н салбарт урт хугацаанд оролцох эсэх нь БУ-г тэргүүлэх чиглэл болгон албан ёсоор уялдуулах болон үйл ажиллагаандаа дэмжлэг олж авах санаачлагаар тодорхойлогдохгоор байна. Тухайлбал, Дэлхийн зөн байгууллага нь микро түвшин дэх олон нийтийн оролцоог эрх мэдэлжүүлж, нөлөөлдөг бөгөөд Бүгд найрамдах Ардчилсан Конго Улсад хэрэгжүүлж буй хөтөлбөртэйгээ холбох замаар БУ-г тэргүүлэх чиглэл болгох сонирхолтойгоо илэрхийлсэн.

Хамтрагчид болон боломжит түншүүдэд хариуцлагатай гарал үүслийн санаачлага ба олон улсын худалдан авагчид багтах бөгөөд үүнд Хариуцлагатай уул уурхайн санаачлага, Олон улсын шударга худалдаа, Швейцарийн Сайн алтны санаачлага, Солидариад зэрэг байгууллага байна. Аль аль нь БУ-н байгууллагыг өөрсдийн санаачлага, үйл ажиллагаандаа зохицуулан хамруулах, гол эрсдлийг шийдэх, БУ-н бий болгож буй хөгжлийн боломжийг нэмэгдүүлэхэд үйлдвэрлэгчдэд зах зээлд суурилсан дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой. Монголоос гарал үүсэлтэй бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхолтой NTR Металз болон олон улсын бусад байгууллагууд, брэнд нь БУ-н нийлүүлэлтийг сүлжээг албажуулах, шинэ зах зээлд нэвтрэх боломжид дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

Тогтвортой БУ-н санхүүгийн механизмд түншүүдийг оролцуулах шаардлагатай бөгөөд үүнд БУ-чдад үзүүлэх үйлчилгээ, татвар, төлбөрийн үндэслэлтэй хэмжээг хууль тогтоомжид тусгах зэрэг асуудал багтана. Мөн Сангийн яам болон Татварын албыг оролцуулах хэрэгтэй. Арилжааны банкууд мөн уурхайчид болон ченжүүдийн бизнесийн эрсдлийг бууруулахад туслах механизмыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

Том уурхайн компаниуд болон зарим талаар тэдний олон улсын хамтрагчид БУ хамтран ажиллах, зэрэгцэн орших сайн туршлагыг

корпорацийн нийгмийн хариуцлагын бусад үүргүүдтэйгээ уялдуулан хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Холбогдох хамтрагчид, түншүүд нь уурхайн болон эрэл хайгуулын компани, Уул уурхайн Үндэсний ассоциациас эхлээд Монголын уул уурхайн компанийн хөрөнгө оруулагчид/удирдах зөвлөл, цаашлаад Дэлхийн Алтны зөвлөл, Уул уурхай ба металын Олон улсын зөвлөл хүртэл өргөн хүрээг хамарна. Олон улсын түвшинд RJC буюу Хариуцлагатай Үнэт эдлэлийн зөвлөл ба Солидариад байгууллага нь БУ-том уурхайн хамтын ажиллагааны сайн туршлага, шинэ хэлбэрийг дэмжих зорилгоор том хэмжээний алтны компанитай хамтарч ажилладаг бөгөөд том уурхайн компаниуд RJC-д нэгдэхээр бол дэмжлэг үзүүлэх боломжтой.

Олон тооны хандивлагчид тогтвортой БУ-н зорилгыг хэрэгжүүлэхэд шууд хамаарах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. GIZ буюу Германы Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санаачлага (АМННС) нь Ашигт малтмалын салбарын Мэргэжлийн сургалтыг тусгасан бөгөөд энэ хүрээнд алтны нийлүүлэлтийн сүлжээг үнэт эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар нэмүү өртөг шингээх зэрэг хамтын ажиллагааны боломжийг бий болгож байна. АМННС-ын хүрээнд Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад олон талыг оролцуулсан ашигт малтмалын нөөцийн менежментийн хороог байгуулсан нь БУ-чдыг олон нийтийн төлөөлөл, аж ахуйн нэгж, жижиг компани байдлаар оролцох нэмэлт боломжоор хангаж байна. GIZ байгууллага Монгол дахь ОУИТБС буюу EITI -ын нарийн бичгийн дарга нарын газарт дэмжлэг үзүүлж, ОУИТБС болон БУ-г бусад улсынхтай уялдуулах, БУ-н талаарх мэдээлэл солилцох харилцан суралцах сүлжээг бий болгох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Бусад байгууллагатай хамтран ажиллах нэмэлт боломж нь анхан шатнаас эхлээд бодлогын түвшний санаачлагуудыг багтаана. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) БУ-н эрүүл ахуйн асуудлаар нарийвчилсан үнэлгээ хийсэн бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад БУ-н асуудлыг тусгах талаар ТБУТ-тай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Австралийн Гадаад харилцаа, худалдааны яам ГХХЯ (хуучнаар Авст.ОУХА) зохицуулалтыг сайжруулах зорилгоор БУ-н зөвлөлийн байгууллага хоорондын ажиллагааг дэмжих санаачлагыг эхлүүлээд байгаа бөгөөд гарах үр дүнгээс хамааран, БУ-н талаарх оролцоогоо нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Дэлхийн банк Монгол Улсын хувьд БУ-н асуудлаар тодорхой анхаарч ажиллаагүй байгаа ч үйл ажиллагаа нь өргөн хүрээнд уул

уурхайн салбарын удирдлагатай холбоотой учир чухал хамтрагч болно. Хуучин СИДА (одоо Канадын Гадаад харилцааны яамны бүтцэд орсон) байгууллага нь Хөгжил дэх Олборлох Аж үйлдвэрийн санаачлагын Хүрээлэнг байгуулсан ба тус институтын БУ-н талаарх тэргүүлэх чиглэлд Монгол Улсыг багтаах боломжтой бөгөөд БУ-н засаглалыг бэхжүүлэх болон шаардлагатай технологийн асуудлаарх цоорхойг шийдэх боломжтой юм. Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хувьд бусад боломжит хамтрагчдын талаар Мэдлэгийн төвийн асуулагад багтаасан болно.

5.3 Холбогдох талуудын хамтын ажиллагаа ба зохицуулалт

ТБУТ-ийн 4 дэх үе шат нь зохицуулалт, хамтын ажиллагааны одоогийн сүлжээ, механизмд үндэслэнэ. Өөр өөр түншүүдийн нэмэлт эрх мэдэл, үүрэг, чиг үүргийг харгалзан, ТБУТ-ийн Удирдах хороо нь макро түвшинд байгууллага хоорондын зохицуулалтыг хийх ба ТЗН нь бодлогын болон хэрэгжилтийн шатанд ХЯ, ХАХНХЯ, ЭМСЯ, ХЭҮК-ийн идэвхтэй ажиллагааг хангах үүднээс зохицуулалтын хувьд УУЯ-ны БУ-н албатай нягт хамтарч ажиллана. Австралийн ГХХЯ нь БУ-н асуудлаар байгууллага хоорондын зөвлөлийг дэмжихийн хамт цаашид бодлогын түвшинд тодорхой үүрэг гүйцэтгэх боломжтой. Засгийн газрын хэрэгжилтийн түвшин дэх албан ёсны байгууллага хоорондын зөвлөлд Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны Үндэсний зөвлөл, түүний бичил уурхайтай холбоотой гол байгууллагуудыг багтаасан БУ-н асуудал эрхэлсэн дэд зөвлөл багтдаг. ТБУТ нь гол чиглэлийн яамд (ХЯ, ЭМСЯ, ХАХНХЯ, ХЭҮК)-аар дамжуулан орон нутгийн захиргааны техник ажилтнуудыг хамруулан орон нутгийн түвшин дэх үүрэг хүлээгчдийн үүргийг бэхжүүлэх одоогийн байгаа босоо чиглэлийн зохицуулалтын механизмыг ашиглан, бэхжүүлэх юм. Сумын түвшинд GIZ байгууллагын дэмжлэг үзүүлсэн олон талт оролцогч тал бүхий ашигт малтмалын нөөцийн менежментийн зөвлөлийг сонгосон аймгуудад байгуулж байгаа бөгөөд бичил уурхайчид, тэдний байгууллага, орон нутгийн захиргаа, том хэмжээний уурхайн хоорондын хамтын ажиллагааны өөр нэг боломжийг бий болгож байна.

БУ-н Холбоо нь уурхайчид, тэдний байгууллага холбоодын хоорондын үйл ажиллагааг зохицуулах, гол агентлаг, байгууллагуудын зохицуулагч байдлаар ажиллах илүү их боломжтой болно.

ТБУТ-ийн 4 дэх үе шат нь бусад төсөл,

түншүүдийн чадалд тулгуурлан, давхардлаас сэргийлж, зардлыг хамгийн бага байлгана. Хариуцлагатай уул уурхайн байгаль орчны асуудлууд (ялангуяа уурхайн олборлолтын газрын нөхөн сэргээлт, мөнгөн усны ашиглалтыг бууруулах)-ыг ШХА-ийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй БОХТОХ төслийн 2 дахь үе шатанд тусгасан. БУ-чдад зориулсан техник, мэргэжлийн сургалт нь ШХА-ийн Мэргэжлийн боловсрол сургалтын төслийн хүрээнд олж авсан сургамж, туршлагад үндэслэн хэрэгжих боломжтой бөгөөд “бүртгэлгүй БУ-н нөхөрлөл”-ийг аж ахуйн нэгж болгон хөгжүүлэх ажилд ЖДҮ-ийн хөгжлийн төслийн туршлага чухал болж болно. БУ-н орон нутгийн түвшин дэх удирдлагын хувьд ШХА-ийн Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр (ЗДТСХ)-тэй цаашид холбоотой ажиллаж болох ба БУ-н Холбоо, БУ-н ТББ зэрэг байгууллагууд ШХА-ийн ТББ-ын чадавхийг бэхжүүлэх төслөөс мөн үр шимийг нь хүртэх боломжтой. Түүнчлэн, ТБУТ-ийн 4 дэх үе шат нь бусад хандивлагчдын хэрэгжүүлж буй төслүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулах боломжийг идэвхтэй судалж, ашиглах болно.²¹ Мэдлэг, туршлага солилцох талаарх бусад байгууллагын үйл ажиллагааг дэмжих нь Бүрэлдэхүүн хэсэг 3-ийн чухал асуудал байна.

ТБУТ нь чадавхийг бэхжүүлснээр зохицуулалтын үүргээ бэхжүүлж, энэ үүргээ аажмаар шилжүүлнэ. ТБУТ-ийн Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2 нь эхнээсээ зохицуулалтын үүргээ хэрэгжүүлэхийн хамт явцын дунд хэрэгжүүлэлт, зохицуулалтын үүрэг хариуцлагаа дотоодын холбогдох байгууллагад шилжүүлнэ. Төсөл нь эдгээр бүрэлдэхүүн хэсгийн хувьд нэмэлт үүрэг гүйцэтгэх чиглэлээр олон улсын түншүүдийн ашиг сонирхлыг судлах бөгөөд энэ асуудлыг БУ-н асуудлаарх олон улсын хандивлагчдын форум зохион байгуулах замаар шийдэхээр төлөвлөж байна.

Бүрэлдэхүүн хэсэг 3 нь холимог бүтэцтэй байна. Одоогийн байдлаар төсөл энэ чиглэлийн үйл ажиллагаагаа шууд шилжүүлэн өгөх боломжтой ямар нэг байгууллага Монголд хараахан байхгүй учир Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хувьд гүйцэтгэх үүрэг нь ТБУТ-ийн ТЗН-д хэвээр байна. Цаг хугацааны явцад ТБУТ аажмаар дуусах үед зарим үйл ажиллагааг дотоодын холбогдох байгууллагууд гүйцэтгэж, бусад

21 Ж.н.: ТБУТ нь GIZ-тэй Монгол Улсад БУ-аар олборлосон алтаар үнэт эдлэл хийх талаар хамтарч ажиллаад эхэлсэн. Богино хугацааны зорилтот зах зээл нь дотоодын зах зээл. Хэрэв амжилттай байвал, энэ хамтын ажиллагааг ТБУТ-ийн 4 дэх үе шатанд өргөжүүлж болох ба ТБУТ нь гэрчилгээ бүхий нийлүүлэлтийн сүлжээг байгуулах (Шударга олборлолт ба шударга худалдааны гэрчилгээ) бол GIZ нь үнэт эдлэлийн үйлдвэрлэл, дотоодын (магадгүй олон улсын) зах зээлд худалдах асуудлыг хариуцна.

үйл ажиллагааг олон улсын өөр байгууллага гүйцэтгэнэ. Энэ үе шатны төгсгөлд Бүрэлдэхүүн хэсэг 3-ийн менежментийг дотоодын юм уу гадны гуравдагч талд шилжүүлнэ.

5.4 Өөрчлөлтийн хөдөлгөгч хүч ба саад тотгор

ТХН-ээс ТЗН болон өөрчлөх нь хэрэгжилтийн загварыг төслийн түншүүд болон тэдний чадавхи, үйл ажиллагаа сайжирч буй харилцаанд тусгалаа олно.

Эрх эдлэгчид болон үүрэг хүлээгчдийг төслийг хэрэгжүүлэх хөдөлгөгч гол хүч гэж үзэх бөгөөд ТБУТ-өөс тэднийг эрх мэдэлжүүлэх, бэхжүүлэх талаар дэмжлэг үзүүлнэ. Төслийн 4 дэх үе шатны өөрчлөлтийг нийлүүлэлтийн сүлжээний талаарх оролцогч талуудын үзэж буй Бүрэлдэхүүн хэсэг 2-ийн “эдийн засгийг бэхжүүлэх” хандлагын хүрээнд авч үзэх бөгөөд өөр өөр оролцогч бүлгүүдийн эрх тэгш оролцоо, эрх мэдлийг хангах замаар үр дүнг улс төржүүлэхээс зайлсхийж ,нягт хамтарч ажиллахад анхаарна.

Гагцхүү бодит баримт л саад тотгорын талаарх мэдээллийг баталгаажуулна.

Өмнөх үе шатнуудад, судалгаа, өргөн хүрээний харилцааны стратеги нь албажуулах явцад бий болсон эерэг үр дүн, уурхайчдад тулгарч байсан сорилтуудтай холбоотой бодит баримтыг бий болгосон. Эдгээр нь орон нутгийн албан тушаалтнууд, УИХ-ын гишүүд, олон нийт зэрэг оролцогч талуудын хандлагыг өөрчлөхөд ихээхэн ахиц өөрчлөлтийг гаргасан. Үүнтэй адилаар, бусад саад бэрхшээлийг гагцхүү баримтаар л баталгаажуулна. БОНХАЖЯ-ны БУ-н асуудлаар тавьж буй гол анхаарал нь хөрсний эвдрэл, БУ-н олборлолтын газрын нөхөн сэргээлт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалан БУ-н эсрэг байр суурьтай байна. Хүний эрхтэй холбоотой энэ бодит “өрсөлдөөн”-ийг шийдэхэд²², ТБУТ нь нөхөн сэргээлт болон байгаль орчны хувьд хариуцлагатай аргыг ашиглах өмнөх сайн туршлагад тулгуурлах бөгөөд ШХА-ийн дэмжлэг бүхий өртөг багатай нөхөн сэргээлтийн үр дүнтэй технологийг нэвтрүүлэхэд анхаардаг БОХТОХ төслийн 2 дахь үе шаттай холбоотойгоор зохицуулна.

5.5 Тогтвортой байдал ба төсөл дуусгах стратеги

ТБУТ эхнээс нь БУ-н чиглэлээрх төрийн болон төрийн бус байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг бүрдүүлэхэд

анхаарч ажиллана. Төслийн бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь байгууллын, техникийн, санхүүгийн болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төсөл хэрэгжиж дууссаны дараа ч гэсэн БУ-н салбарт тогтвортой үр дүн гарч байх явдлыг дэмжих хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой. Хэрэгжүүлэх үүргийг, улмаар зохицуулалтын үүргийг үүрэг хүлээгч болон гол холбогдох талуудад үр дүнтэй шилжүүлэх замаар (ж.н БУ-н Холбоо) шаардлагатай чадавхи бүрдэж, чиг үүргийг албажуулж, төслийн энэ үе шат дуусах үед хангалттай санхүүжилттэй байх нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна.

ХЭСХ нь төслийн санаачилсан үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана гэж үзэж байна. Төслийн 4 дэх үе шат нь төсөл дуусах хугацааг 4 жилээр сунгасан ба ХЭСХ-ыг сайтар хэрэгжүүлэх замаар *БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа* бүрэлдэхүүн хэсгийн хүрсэн амжилтыг дахин цэгцэлж, нэгтгэх боломжийг олгож байна. Үүргээ биелүүлэх чадавх нь сайжирсан үүрэг хүлээгчид болон өөрсдийн эрхээ амжилттай шаардах чадавхитай эрх эдлэгчид нь төсөл дууссанаас үл хамааран тогтвортой БУ-г дэвшилтэй, ахицтай байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Албан ёсны БУ-н үйлдвэрлэгчид болон албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний талуудын нийтлэг ашиг сонирхол нь тогтвортой байдлыг хангана. Алтны нийлүүлэлтийн сүлжээний хамгийн эцсийн албан ёсны хүрэх үр дүн нь Монгол банк юм. Мөнгөний бодлогын үүднээс БУ-аар олборлосон алтыг худалдан авах Монгол банкны сонирхол нь БУ-гаар алт олборлогчид болон орон нутгийн худалдаа эрхлэгчдийн тогтмол нийлүүлэлтийг хангах сонирхолтой нийцэж байна. Энэхүү нийтлэг сонирхол нь бичил уурхайн салбарыг бэхжүүлнэ. Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг эдийн засгийн хувьд бэхжүүлэх нь төслийн шинэ бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд, ХЭСХ-ыг эхнээс нь хэрэгжүүлэх болно.

Мэдлэг, туршлага солилцох явдал нь өөрийгөө бэхжүүлэх мэдээллийн эх үүсвэрийг бий болгоно. Төслийн шинэ бүрэлдэхүүн хэсэг болох *Мэдлэг, туршлага солилцох, БУ-н бодлогын талаарх олон улсын хэлэлцүүлэг*-т бусадтай харилцах, сүлжээ байгуулах, холбогдох асуудал багтана. Мэдлэг, туршлага солилцох явдал нь хувь хүний болон байгууллагын түвшинд нийгмийн капиталыг бий болгож, үйл ажиллагааны тууштай байдал, эзэн байх явдалд дэмжлэг үзүүлнэ. Нийгмийн капиталыг нэмэгдүүлэх хамгийн амжилттай арга бол үүнийг хэрэглэх явдал: “хэрэглэх тусам та түүнээсээ илүү ихийг авах болно”. Орон нутаг ба БУ буюу CASM төслийн

²² Хэдийгээр хүний эрхийн асуудал түгээмэл, салгалгүй байдаг ч.

туршлагаас харахад оролцогч талуудын хооронд сүлжээ байгуулах, мэдлэг туршлага солилцсон нь төсөл дууссанаас олон жилийн дараа ч гэсэн байж байдаг нь харагдаж буй бөгөөд туршлагаасаа хамгийн их хуваалцаж байсан талууд хамгийн их үр шим хүртсэн байна. Иймээс мэдлэг, туршлага солилцох нь өөрөө тогтвортой гэж үзэж болно.

Хоёр жилийн хугацаатай төгсгөлийн үе шатанд хийх гол ажил нь эцсийн хүлээлгэн өгөх ажил юм. Улс орны тогтолцоонд илүү ойртуулан уялдуулах зорилгоор төсөл өөрөө шууд хэрэгжүүлдэг байдлаа өөрчлөх нь 3 дахь үе шатны явцад гадны зөвлөхөөр багц үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгүүлдэг ажлын дараагийн алхам байна. Энэ нь төслийн шинэ үе шат эхэлмэгц хэрэгжүүлж эхлэх төслийг дуусгах стратегийн нэг хэсэг байна.

Энэ үйл явцад олж авсан сургамж, төслийн түншүүдийн хэрэгжүүлэх байдал, 4 дэх үе шатанд хүрсэн өөрөө эзэн байх түвшин зэргээс шалтгаалан, төслийн түншүүдэд ТБУТ-ийн ахлах мэргэжилтнүүдийн заавар удирдамжийн дагуу төслийг бүхэлд нь шилжүүлэх боломж байж болох юм. Төслийн төгсгөлийн шатны төлөвлөлтийг дунд шатанд дотооддоо өөртөө хийх үнэлгээнээс эхлэх ба 4 дэх үе шатны төгсгөлд хийх хөндлөнгийн үнэлгээний гол цөм болно.

6. Бүтэц, удирдлага, зохион байгуулалт

6.1 Байгууллагын бүтцийг, улс орны тогтолцоо ба түншүүдийн үйл ажиллагаатай уялдуулах нь

6.1.1 Байгууллагын бүтэц ба түнш байгууллагууд

ТБУТ нь Швейцарь болон Монголын Засгийн газрын хоорондын хоёр талт хамтын ажиллагаа бөгөөд төслийн хэлэлцээрт эрх бүхий байгууллагууд гарын үсэг зурна. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам нь УУЯ-ны нэрийн өмнөөс, Швейцарийн Засгийн газрыг төлөөлж ШХА гарын үсэг зурна.

УУЯ нь Монгол Улсын Засгийн газар дахь хамтран хэрэгжүүлэх гол байгууллага байна. УУЯ нь бодлого боловсруулах, дотоодын болон гадны зохицуулалт, АМГ-т хяналт тавих гол үүргийг хэрэгжүүлнэ. УУЯ-ны Бодлогын төлөвлөлт, зохицуулалтын газрын бүтцэд БУ-н хэлтсийг урт хугацаанд ажиллах БУ-н Зохицуулалтын нэгж байгуулж болох юм. Хэрэгжүүлэх гол түнш байгууллага нь АМГ-ын БУ-н тасаг байна.

ШХА нь ТБУТ-ийн зохицуулах нэгж (ТЗН)-ийг томилно. Байгууллын бүтэц, зохион байгуулалтыг төлөвлөлтийн үе шатанд хэд хэдэн хувилбараар авч үзсэн. ТЗН-ийг ШХА-т хэвээр байлгах нь (i) ТЗН-ийг УУЯ/АМГ-т байгуулснаар төсөл хэрэгжиж дууссаны дараа чиг үүрэг үргэлжлэхгүй болох эрсдлийг бууруулах²³; (ii) УУЯ/АМГ-аас өөр БУ-н чухал

оролцогч талуудад тодорхой чиг үүргийг шилжүүлэх явдлыг (ж.н ЭМСЯ нь эрүүл мэндийн кампанит ажил хийх, БУ-н Холбоо нөлөөллийн үйл ажиллагааг, ХЭҮК нь хүний эрхийн зөрчлийг) дэмжих, улмаар улс орны өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх; (iii) Засгийн газарт очихоос эмээдэг олон тооны албан бус уурхайчдын айдсыг шийдэх болон (iv) Бүрэлдэхүүн хэсэг 3-ийн хүрээн дэх Монгол Улсын “Мэдлэгийн төв” болгох шаардлагатай үйл ажиллагааны “тохирох” байгууллага байхгүй байгаатай холбоотой цоорхойг нөхөх юм.

Хариуцах байгууллагууд нь ТЗН – ТХН-ийн харилцааг дуурайх хэрэгтэй. ТБУТ-ийн 4 дэх үе шатны ТЗН-ийн чиг үүргээс эхлээд хэрэгжилтийн, улмаар зохицуулалтын үүргийг шилжүүлэх ба төслийн гол түнш байгууллага нь УУЯ-ны БУ-н хэлтэс (бодлого боловсруулах, зохицуулах, хянах чиг үүрэг) болон АМГ-ын БУ-н тасаг (хэрэгжүүлэх) байна. Одоогийн зохицуулалтын тогтолцоог ашиглан, тодорхой нэгжийг өөрсдийн эрх мэдэлтэй холбоотойгоор өөр байгууллагын бүтцэд байгуулах хэрэгтэй (ж.н аюулгүй ажлын байр (ХЯ), жендэрийн тэгш байдал, нийгмийн хамгаалал (ХАХНХЯ) гэх мэт) болно (Зураг 4). Нийт нэгж, алба нь ТХН-ийн чиг үүрэгтэй ижил чиг үүрэгтэй байх ба ТЗН-ийн асуудал хариуцсан ТБУТ-ийн ажилтан (хариуцсан менежер)-тай шууд холбоотой байна. Энэ нь Бүрэлдэхүүн хэсэг 1 ба 2-ын бүх асуудалтай шууд хамааралтай байх ба 6.2.1 дэх хэсэгт тусгасан Бүрэлдэхүүн хэсэг 3-ын тохирох загварыг гаргах хэрэгтэй болно.

²³ Төлөвлөлтийн шатанд (Монголд хэрэгжиж буй бусад төслийг мөн авч үзсэн) зохицуулалтын болон хэрэгжүүлэх нэгж, ажилтнуудыг засгийн газрын байгууллагад бий болгох замаар чиг үүргийг засгийн газрын түншүүдэд шилжүүлэх боломжийг судалсан. Дээр дурдсан хүчин зүйлсээс гадна энэ хандлага нь төсөл дуусмагц ажилтнууд болон төсөв

хуваарилалтыг төсөлд тусад нь шийддэг байснаас шалтгаалан дотоод дахь хариуцлагыг нэмэгдүүлэхээс илүү бууруулдаг болох нь харагдсан. ТБУТ-ийн 4 дэх үе шат нь байгууллагын үүрэг хариуцлага (ТБУТ-ийн ажилтнуудыг аажмаар багасгах замаар) шилжүүлэхийг зорьж буй. Учир нь хүний болон санхүүгийн нөөцийг байгууллагын бүтцэд албан ёсоор, тогтвортой тусгасан байдаг.

Зохицуулалтын чиг үүргийг шилжүүлэх нь төсөл дууссаны дараа үр дүн тогтвортой байх явдлыг хангахад зайлшгүй чухал.

Тогтвортой БУ-г хөгжүүлэхэд байгууллага хоорондын зохицуулалт ач холбогдолтой учир УУЯ-ны одоогийн БУ-н хэлтсийг өргөжүүлэн БУ-н зохицуулалтын хэлтэс болгох явдлыг хүчтэй дэмжих хэрэгтэй. БУ-н бодлого, төлөвлөлтийн хандлага, ХЭСХ зэрэгтэй холбоотой хэрэгжүүлэх чиг үүргийн ихэнх нь АМГ-ын БУ-н тасагт шилжүүлнэ. ТЗН-ийн гол чиг үүргийг УУЯ-нд шилжүүлэх хэрэгтэй бөгөөд ингэснээр төслийн үр дүнг эрчимжүүлнэ. Санал болгож буй чиг үүргийг 6.2.1 дэх хэсэгт тусгасан.


Төслийн дээд удирдлага нь Засгийн газрын холбогдох байгууллагатай харьцах зохицуулалт, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. **Менежмент ба зохицуулалт:** Хамтрагч байгууллагууд одоогийн бүтцээр ажиллана (ж.н УУЯ-ны БУ-н хэлтэс/ Зохицуулалтын хэлтэс, БУ-н яамд хоорондын зөвлөл). **Хэрэгжүүлэлт:** АМГ болон бусад яамдын холбогдох хэлтэс дэх хамтрагч нэгж буюу “асуудал хариуцсан ажилтан” нь дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хамтран, бэхжих ба эдгээр нь өөрсдийн яам, агентлаг, орон нутгийг холбох гол суваг нь байна. Дотоод ба гадны зохицуулалтын механизмыг 5.3 дахь хэсэгт дурдсан ба Зураг 4-т харуулав.

Нөлөөллийн гол чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлнэ. ТБУТ-ийн нөлөөллийн чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, БУ-н салбарын хувийн хэвшилд шилжүүлэх шаардлагатай. ХЭСХ-д суурилсан эрх мэдэлжүүлэх загварыг ашигласнаар энэхүү шилжүүлэх үйл явц нь дурдсан үйл ажиллагааны багцад нийцүүлэн уялдуулсан.

Зохион байгуулалтын бүтэц нь байгууллын зохицуулалтын 3 үе шаттай байх шаардлагатай. Хамгийн өндөр шийдвэр гаргах түвшинд ТБУТ-ийн Удирдах хороо,

6.1.2 Улс орны тогтолцоонд нийцүүлэн уялдуулах

Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратеги (2013–2016) нь үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулан, улс орны тогтолцоог аль болох их ашиглахыг үндэс болгодог. ТБУТ-ийн 4 дэх үе шат нь стратегийн ерөнхий зорилт болох “эрх тэгш нийгмийн болон эдийн засгийн хөгжил”-д хувь нэмэр оруулна. Шинэ стратегийн менежментийн зарчим нь: (i)




Зураг 4: Албан ёсны Засгийн газрын хамтрагч байгууллагын (хар хөх), засгийн газрын бусад агентлагууд (цайвар цэнхэр) болон төрийн бус байгууллагын (ногоон) зохион байгуулалтын бүтцийг харуулсан бүүдүвч

төсөл нь засгийн газраас цааш үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүжүүлэх өндөр магадлалтай асуудалд анхаарах шаардлагатай; (ii) Швейцарь Улсын зүгээс аливаа хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамтран төлөвлөж, үнэлж, хэрэгжүүлж, санхүүжүүлэхийг шаарддаг; (iii) Ядуу иргэд үр шимээс хүртэж байх тэргүүлэх чиглэл, үйлчилгээнд төсвийн хөрөнгийг зарцуулах ардчилсан механизмыг бэхжүүлэх; (iv) олон талт түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх хамтарсан төслийг хэрэгжүүлэх болон (v) ШХА өөрөө төслүүдээ хэрэгжүүлэхээ болих явдал юм. Түүнчлэн, хөгжлийн төслүүд нь харилцан биенээ нөхөх зарчимд нийцсэн, улс орны холбогдох оролцогч талууд өөрсдийн асуудлыг шийдэх явдлыг дэмжсэн, өмнө нь хэрэгжиж буй гэрээгээр хүлээсэн үүргийг орлох, өөрчлөх зорилгогүй байна.

6.2 Төслийн зохион байгуулалт ба удирдах механизм

6.2.1 Төслийн зохион байгуулалт

Төслийг ТЗН нь албан ёсны хамтрагч байгууллага болох УУЯ, АМГ болон бусад байгууллагатай хамтран, Удирдах хорооны хяналтын дор хэрэгжүүлнэ. ТЗН дэх дээд удирдлага нь УУЯ, АМГ болон бусад байгууллагатай шууд харьцах ба хамтран төлөвлөлт, мониторинг хийнэ. ТЗН-ийн дунд шатны удирдлага нь өөр өөрийн хариуцсан чиглэлээр холбогдох талуудтай хамтран ажиллах “үйл ажиллагааны менежерүүд”-ээс бүрдэнэ (Зураг 5).




Зураг 5: Төслийн зохион байгуулалтын бүтэц нь ТЗН, албан ёсны, үндсэн хамтрагч байгууллага (хар хөх), засгийн газрын бусад агентлагийн түнш (цайвар цэнхэр), төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага (ногоон) болон дотоод болон гадын төслүүд, Мэдлэгийн төвийн хамтрагч (улбар шар)-ын хоорондын харилцааг харуулав. Үйл ажиллагааны менежерүүдийн үүрэг хариуцлагын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас харна уу.

ТЗН нь УУЯ, АМГ-ын БУ-н тасаг болон бусад гол түншүүдтэй хамтрах, техник туслалцаа үзүүлэх ажлыг зохицуулна. ТЗН-ийн үндсэн чиг үүрэг нь УУЯ, АМГ болон бусад байгууллага дахь гол хамтрагч талуудтай шууд хамтран ажиллах, зохицуулах явдал юм. ТЗН-ийн ХЭСХ, жендэрийн асуудлаарх чадавхийг бэхжүүлэх нь төсөл хэрэгжих хугацаанд мэдлэг, ур чадварыг шилжүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хангахын тулд төсөл хэрэгжүүлэх эхний үеээс эхлэн чухал байна. Үүрэг хүлээгчид болон төслийн ажилтнууд²⁴, гэрээлэгч мэргэжилтнүүд, ИНБ, зөвлөхүүдийн үүрэг хариуцлага нэмэгдэж буйтай холбоотойгоор тэднийг тухайн албанд нь тодорхой хугацаагаар, зарим тохиолдолд урт хугацаагаар ажиллуулах шаардлагатай. Чиг үүргийг төслийн түншүүдэд шилжүүлэх, гэрээлэгчдийг илүү авч ажиллуулах нь нүсэр бус ч илүү хүчтэй, тогтвортой төслийг бий болгох боломжийг бүрдүүлж, төслийг ТХН

хэрэгжүүлэхээс ТЗН илүү зохицуулах байдлаар хэрэгжүүлэх аргад шилжүүлэх юм. УУЯ-нд БУ-н албан ёсны Зохицуулалтын хэлтсийг байгуулж, УУЯ, АМГ-аас шаардлагатай нөхцөлөөр хангах нь энэ зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай.²⁵ Аймаг, сумын түвшинд үйл ажиллагааг зохицуулахад төвлөрөл саарсан орчин дахь орон нутгийн захиргааны тулж ажилласан туршлага нь маш чухал хөрөнгө болно. Энэ зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь төслийн нэгжийг хэвээр үлдээж, тус алба нь бүс нутгийн болон орон нутгийн захиргааны хамтран ажиллах ажлыг “нүдээр харж” зохицуулахыг санал болгож байна. Энэ нь орон нутгийн болон бүс нутгийн Баянхонгор аймгийн төрийн захиргааны ажилтнууд бусад бүс, орон нутгийн албан хаагчидтай харилцан үр дүнтэй суралцаж, туршлага солилцоход идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлнэ.

24 ШХА: Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратеги (2013–2016). Берн, 2013 оны 2 дугаар сар.

25 Төслийн бүх ажилтнууд “үйл ажиллагааны менежер”-ийн үндсэн үүрэгтэй байх ба төслийн түншүүдтэй хамтран ажиллах асуудлыг хариуцах бөгөөд хоёрдогч үүрэг нь “өөр өөрийн мэргэшлийн чиглэлээр “тэргүүлэх мэргэжилтэн”-ий үүргийг гүйцэтгэнэ.6.4.2. дахь хэсэгт “байгууллын матриц”-ын дэлгэрэнгүй саналыг тусгав.



ЧУХАЛ ҮЙЛ ЯВДАЛ, ЦАГ ХУГАЦАА

Зураг 6: Засгийн газрын түншүүдэд үүрэг хариуцлагыг аажмаар шилжүүлэх цаг хугацаа (тоймлосон цаг хугацаа)

Төслийн зохион байгуулалт нь хэрэгжүүлэх чиг үүргийг гол байгууллагуудад шаардлагатай чадавхи, санхүүгийн болон хүний нөөцийн чадамж нэмэгдэх, гол байгууллагын чиг үүргийг албажуулах зэрэгтэй холбоотой **тодорхой асуудлаар тодорхой хугацаанд амжилтад хүрснээр шилжүүлэх асуудлыг тусгана** (Зураг 6). Ийнхүү шилжүүлэхэд дадлагажуулах, хүний эрхийн асуудлаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа зэрэг асуудлаар түнш байгууллагад мониторинг хийх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

ТЗН нь Бүрэлдэхүүн хэсэг 3-ийг тэргүүлэх хэрэгжүүлэх ба тодорхой зарим асуудлыг шилжүүлэн хэрэгжүүлнэ. Эдгээр бүх чиг үүргийг хариуцах чадамж бүхий байгууллага хараахан байхгүй бөгөөд энэхүү бүрэлдэхүүн хэсгийн нийт төслийн хувьд эзлэх ач холбогдол тодорхой. Төслийн захирал болон Мэдлэгийн төвийн менежер эхний үйл ажиллагааг удирдан улмаар төсөл хэрэгжиж дуусах хугацаа ойртох үед менежментийг аажмаар шилжүүлж байх холимог бүтэцтэй байх шаардлагатай.

6.2.2 Төслийн Удирдах хороо

ТБУТ-ийн 3 дахь үе шатанд Удирдах хороо нь *"бичил уурхайг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах албан ёсны салбар гэж хүлээн зөвшөөрүүлэх"* зорилтыг хэрэгжүүлэхүйц байдлаар бүрдсэн байв. Хороо нь УУЯ, СЯ, БОНХАЖЯ, ХЯ, АМГ, УУАА, МХЕГ²⁶, бичил уурхайчдын төлөөлөл, ТБУТ-өөс бүрдсэн. Салбар хоорондын энэхүү хандлага нь тус салбарыг хүлээн зөвшөөрөх үр дүнтэй болохыг харуулсан.

ТБУТ-ийн 3 дахь үе шатны Удирдах хороо нь хүний эрх, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл зэрэг асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулсан Удирдах хороо хэвээр байна. Төслийн 4 дэх үе шат нь хүний

эрхийг хэрэгжүүлэх, эдийн засгийн хөгжил дэх нийлүүлэлтийн сүлжээг албажуулах асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч байгаатай холбоотойгоор төслийн Удирдах хороонд СЯ болон ХЭҮК-ийн төлөөллийг оруулах нь зүйтэй.

6.3 Түншүүдтэй хамтран ажиллах захиргааны зохицуулалт

Үйл ажиллагааны төлөвлөлт (жилийн болон арай богино хугацааны) хийх нь ТБУТ-ийн удирдлага, төслийн хамтрагчдын хамт хийх ажил юм. Төслийн үр дүн нь Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдаатайгаар хэрэгжих явдлыг хангах, хүлээн зөвшөөрүүлэхэд үйл ажиллагааны системтэй, хамтарсан төлөвлөгөө шаардлагатай. Энэ зорилтын хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх (үйл ажиллагааны чиглэл бүрд)-дээ ТЗН болон төслийн түншүүд **"ажлын багц"**-ын хувьд тохиролцоно. Ажлын багц нь ТБУТ-ийн **дэд төсөл** байх ба эдгээр нь өөр өөрийн төслийн орчлын менежменттэй (төлөвлөлт, мониторинг, дотоод үнэлгээ, үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх) байна. Ажлын багцын жендэрийн дүн шинжилгээ болон төлөвлөлт ба төсөвлөлтийн явц нь үйл ажиллагааны төлөвлөлтийн явцтай уялдсан байна.

"Үндсэн" болон "дэд" ажлын багцыг батлах зааварчилгаа болох үйл ажиллагааны зарчимтай байна. Үндсэн ажлын багцыг жилийн үйл ажиллагааны төлөвлөлтөд оруулахдаа тохиролцох ба Төслийн Удирдах хороогоор батална. Төслийн үйл ажиллагааны уян хатан байдлыг хангахын тулд дэд ажлын багцын талаар богино хугацаанд мэдэгдэл өгч, ТЗН зөвшөөрөн хэрэгжүүлнэ. Холбогдох босго алхмуудыг захиргааны дотоод үйл ажиллагааны процессын дагуу хэрэгжүүлнэ. Энэхүү процесс нь бүх талуудад ил тод, тодорхой байна.

6.4 Төслийн менежмент – үүрэг, хариуцах ажил, хариуцлага

6.4.1 Төслийн дээд удирдлага

Төслийн ерөнхий менежментийг төслийн үе шатыг хэрэгжүүлэх явцад гадны удирдлагаас дотоодын удирдлагад аажмаар шилжүүлнэ. Менежментийн өөр өөр бүтцийн талаар төслийн төлөвлөлтийн явцад дүн шинжилгээ хийсэн. Хамгийн оновчтой эхлэл бол БУ-н салбарын туршлагатай, стратегийн болон онолын менежментийн ур чадвартай, дотоодын болон олон улсын түншүүдтэй

26 Хэдийгээр хамтран төлөвлөлт хийх нь төслийн загварт тусгагдсан ч, ТЗН-ийн тодорхой чиг үүргийг УУЯ-нд шилжүүлэх явдал нь урт хугацааны чухал зорилго юм. Үүнийг УУЯ-ны БУ-н Зохицуулалтын хэлтэс дотор байгуулах нь нийцтэй болов уу. Одоогийн БУ-н хэлтэст тулгуурлан, Зохицуулалтын хэлтэс нь дараахь чиг үүргийг гүйцэтгэх 3 ажилтныг томилж ажиллуулна: (i) *стратегийн*: яамдын хоорондын бодлогын болон шийдвэр гаргах түвшин дэх зохицуулалт, ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх; жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлтийг хариуцах; (ii) УУЯ ба АМГ/УУАА ба холбогдох яамдын хэрэгжүүлэгч агентлаг болон иргэний нийгмийн оролцогч талуудын хоорондын (орон нутгийн захиргаа мөн багтана) *менежмент ба зохицуулалт* ба одоогийн зохицуулалтын сүлжээг бэхжүүлэх (iii) *хэрэгжүүлэлтэд үзүүлэх дэмжлэг*: төслийн зөвлөхүүдийн хяналтад дэмжлэг үзүүлэх, мэдээ материал тараах, мэдлэгийн төв болон бусад холбогдох чиг үүрэгт дэмжлэг үзүүлэх явдал. Үндсэндээ, Зохицуулалтын хэлтэс нь ТЗН-ийн чиг үүрэгтэй ижил үүргийг гүйцэтгэх ба ахлах ажилтан нь өндөр түвшинд, хоёр ажилтан нь үйл ажиллагааны менежертэй ижил үүрэгтэй ажиллана.

хамтран ажиллах явдлыг зохицуулах **Төслийн захирлын** удирдсан Төслийн дээд удирдлага байна. Төслийн захиралд Үндэсний зохицуулагч дэмжлэг үзүүлж ажиллах ба тэрээр төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үндэсний мэдлэг туршлага болон төслийн менежментийн ур чадвартай байх ба хэрэгжилт, захиргаа, төлөвлөлт, мониторингд анхаарч ажиллана. Аль аль нь төлөвлөлт, төсөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлт, мониторинг болон үнэлгээнд жендэр ба хүний эрхийн асуудлыг хангалттай анхаарч байх явдлыг хангахад манлайлах үүрэгтэй байна. Түүнчлэн, Төслийн үндэсний зохицуулагчийг шийдвэр гаргах, санхүүгийн менежментийн асуудлаар илүү хариуцлагатай, үр дүнтэй ажиллах чиглэлээр Төслийн захирал дадлагажуулна. Төслийн дээд удирдлагын

хувьд төслийн хэрэгжилтийн дунд шатанд албан ёсоор чиг үүргээ хүлээлгэн өгнө. Төслийн захирал хоёр дахь жилийн дараа ажлаа өгч, энэ үед Үндэсний зохицуулагч нь төслийг бие даан удирдах хангалттай чадавхитай болсон байна. Төслийн менежментэд олон улсын ноу-хау болон техник туршлагын дэмжлэг болон техник зөвлөгөөг **Олон улсын зөвлөх** үлдэж буй 3, 4 дэх жилийн хугацаанд үзүүлнэ.

Төслийн захирал болон Үндэсний зохицуулагч *“ТБУТ-ийн менежмент”* гэж хамтдаа үйл ажиллагаагаа тайлагнахын зэрэгцээ ШХА болон Төслийн Удирдах хороонд тус тусдаа тайлагнана. 3 дахь жил эхлэх үед Үндэсний зохицуулагч нь Удирдах хороо болон ШХА-т бие даан тайлагнана. Олон улсын зөвлөх ШХА-т шууд тайлагнана.


Албан тушаал	Үүрэг, хариуцах ажил, хариуцлага
Төслийн захирал (1-2 жилийн хугацаанд байнга ажиллах) <i>Тавигдах үндсэн шаардлага:</i> БУ-н талаар “ахлах” Төслийн менежментийн талаар “ахлах”	БУ-н салбарт туршлагатай, төслийн ерөнхий стратегийн болон хэрэгжилтийн менежментийг хариуцсан олон улсын мэргэжилтэн төслийн хугацаанд суурьшин ажиллана. Хариуцах ажил: төслийн хэрэгжилтийг хангаж, үр дүн ба бүтээгдэхүүний түвшинд хяналт тавьж, боломжийг тодорхойлж, дотоодын болон олон улсын холбоо, харилцааг бүрдүүлж, бэхжүүлэх бөгөөд Үндэсний төслийн зохицуулагчийг дадлагжуулан, 2 жилийн дараа ажлаа хүлээлгэн өгнө.
Олон улсын зөвлөх (3-4 жилийн хугацаанд байнга ажиллах) <i>Тавигдах үндсэн шаардлага:</i> БУ-н талаар “ахлах” Төслийн менежментийн талаар “ахлах”	БУ-н талаарх олон улсын туршлагаар хангаж, төслийн стратегийн ерөнхий болон хэрэгжилтийн менежментийн асуудлаар зөвлөгөө өгнө. Хариуцах ажил: Төслийн гүйцэтгэх, стратегийн чиглэлээр зөвлөгөө, зөвлөмж өгөх; дотоодын болон олон улсын холбоо, харилцааг бий болгож, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
Төслийн үндэсний зохицуулагч <i>Тавигдах үндсэн шаардлага:</i> БУ-н талаар “анхан шатны” Төслийн менежментийн талаар “ахлах”	Төслийн менежментийн өдөр тутмын үйл ажиллагаа, зохицуулалтыг Төслийн захирлын удирдлага дор 1-2 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. 3 дахь жилээс эхлэн Төслийн үндэсний зохицуулагч нь Олон улсын зөвлөхийн дэмжлэгтэйгээр төслийн ерөнхий менежментийг хариуцна. Хариуцах ажил: Бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх, уялдуулах, зохицуулах; түншүүд төслийг хэрэгжүүлж буй байдлыг зохицуулах, мониторинг хийх (бүтээгдэхүүн ба үйл ажиллагааны түвшинд); хоёр жилийн дараагаас эхлэн стратегийн ерөнхий болон хэрэгжилтийн менежмент.

6.4.2 Дунд шатны менежмент

Төслийг хэрэгжүүлдэг байдлаас зохицуулагчийн үүрэгт шилжихэд төслийн багийн бүтцийг шинэчилж, ТБУТ-ийн ажилтнууд аажмаар ажлаа хүлээлгэн өгөх шаардлагатай болно. Төслийн 3 дахь үе шатны бүтэц нь хангалттай уян хатан бус, бүрэлдэхүүн хэсгийн ахлагчдын ажлын ачааллыг хэт их болгож, доод шатны “мэргэжилтнүүдийн” менежментийн ур чадварыг хангалтгүй ашиглахад хүргэх ба зохицуулалтын түвшинд төслийн түншүүд төслийн ажилтнуудтай нүүр нүүрээ харан тулж ажиллах сонирхолтой байдаг. Түүнчлэн төслийн 4 дэх үе шат нь шинэ асуудлыг хамрах болсонтой холбоотойгоор 3 дахь үе шатны зохион байгуулалтын бүтцээр

явбал 4 дэх үе шатны эхнээс нь мэргэжилтэн нэмж авах шаардлагатай болно.

“Матриц менежмент”-ын арга нь нарийн, том үйлдвэр болон байгууллагад зохион байгуулалтын бүтэц болж ашиглагддаг. Энэ аргын давуу тал нь уян хатан, мэдрэмжтэй байдал, бизнесийн хүрээнд хамтран ажиллах харилцах явдлыг нэмэгдүүлж, нарийн цогц үйл ажиллагааг зохицуулдаг. Энэ аргыг босоо чиглэлийн бүтэц зонхилж байдаг хөгжлийн төслийн менежментэд төдийлөн хэрэглэдэггүй. ТБУТ-ын 4 дэх шатны хүрээнд хамрах оролцогч талууд олон, сэдэв өргөн хүрээний учир зохион байгуулалтын энэ бүтцийг илүү зохимжтой гэж үзэв (Зураг 7).



Жишээ 1: БУ-н Холбоог албажуулахад дэмжлэг үзүүлэх: В нь Холбоог хариуцсан үйл ажиллагааны менежер бөгөөд албажуулах асуудлаарх удирдах мэргэжилтэн С дэмжлэг үзүүлж ажиллана.



Жишээ 2: АМГ-аас албажуулах чиглэлээр кампанит ажил явуулах: С нь АМГ-ыг хариуцсан үйл ажиллагааны менежер бөгөөд үйлдвэрлэгч байгууллагын асуудлаарх удирдах мэргэжилтэн В дэмжлэг үзүүлж ажиллана.

Зураг 7: Төслийн ажилтан ба 2 үйл ажиллагааг жишээ болгон харуулсан, дунд шатны менежментийн матриц зохион байгуулалтын бүтэц.¹

¹ Тайлбар 1: Төслийн түншүүдийн тоо болон мэргэшлийн туршлагын чиглэлийг энэ зурагт багасгаж харуулсан. Тайлбар 2: Төслийн бүх түншүүд болон мэргэшлийн туршлагын чиглэл нь Бүрэлдэхүүн хэсэг 3-ын Мэдлэгийн төвтэй бүх үйл ажиллагаагаар уялдана ("+" тэмдгээр тэмдэглэсэн). Зураг дахь төслийн ажилтан "А" нь Мэдлэгийн төвийн гол менежер байна; Мэдлэгийн төв нь төслийн бүх ажилтнуудад хамаатай болохыг харуулах зорилгоор бусад бүх менежерүүдийн дор шугам татсан.

ТБУТ-ийн дунд шатны менежмент нь матриц менежментийн загварыг дагана. Үүнтэй холбоотойгоор ТБУТ-д “Бүрэлдэхүүн хэсгийн ахлагч” байхгүй харин,

- **Төслийн түнш бүр** ТБУТ-ийн дотор хариуцаж ажиллах **“үйл ажиллагааны менежер”-тэй байна.** Үүнтэй адилаар ,
- **Тодорхой сэдэв бүрт** тухайн асуудлаар туршлага бүхий **“удирдах мэргэжилтэн”** томилогдсон байна²⁷.
- ТБУТ-ийн багийн гишүүн бүр нэгээс доошгүй түншүүдийн хувьд үйл ажиллагааны менежер болж ажиллахаас гадна нэгээс доошгүй асуудлын удирдах мэргэжилтэнээр ажиллана.
- Үйл ажиллагааны явцад орлох шаардлага гардгийг харгалзан, багийн гишүүн бүр хэд хэдэн чиг үүргийг хариуцаж байна.
- Мэдлэгийн төвийн үйл ажиллагааг тэргүүлэхийн зэрэгцээ бусад менежер болон удирдах мэргэжилтний хариуцсан чиглэл, хариуцлагыг мэдэж байх мэдлэгийн төвийн Үйл ажиллагааны менежер хэрэгтэй.

Төслийн үйл ажиллагаа бүрийг үйл ажиллагааны менежерүүд болон удирдах мэргэжилтнээс бүрдсэн баг хариуцна. Үйл ажиллагааны менежерүүд төслийн түншүүдтэй хамтран үйл ажиллагаа бүрт оролцож, удирдах мэргэжилтнүүд өөр өөрийн туршлагатай хариуцсан асуудлаар бүх үйл ажиллагаанд оролцож байх явдлыг хангана. Менежментийн түвшинд дотоод зохицуулалтыг шаардах замаар **ТЗН түвшин дэх** түншүүдтэй ажиллах гадны зохицуулалтыг хангана. Энэ үүднээс, улс орны тогтолцоонд нягт уялдуулахын тулд төслийн ажилтан бүр өөрийн хариуцсан, менежер нь болж ажиллах түншүүдэд **хагас цагаар зөвлөх** болж ажиллана.

Төслийн аливаа чиглэл, асуудлын хувьд БУ-н салбарт ажилласан туршлага шаардлагатай. Матриц зохион байгуулалт нь хуримтлуулсан туршлага болон ТБУТ-ийн өмнөх үе шатуудад тогтоосон ажлын хэлхээ холбоонд тулгуурлах боломжийг олгох боловч багийн гишүүдийг өөрсдийн хариуцсан чиглэлд илүү анхаарах замаар үр дүн, үр ашгийг нэмэгдүүлнэ. Багийн бүх гишүүдийн хувьд, үйл ажиллагааны менежер болж хангалттай сайн ажиллахын тулд менежментийн ур чадварын сургалт шаардлагатай. Үүнтэй адилаар, ТЗН-ийн бүх гишүүд сургалтад хамрагдаж, менежер болон тэдний хариуцсан асуудал бүрт жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан хандлагыг бүрэн тусгаж хэрэгжүүлж байх явдлыг хангахтай холбоотойгоор ур чадвартай үйлчилгээ хүргэгчээс тодорхой хугацаанд дэмжлэг авч ажиллана.

Дунд шатны менежментийн гуравны нэг нь 4 дэх үе шатны хэрэгжилтийн явцад аажмаар ажлаа өгнө. Хэрэгжүүлэгч гол түншүүдийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байдгийг харгалзан, хэрэгжүүлэлт болон тодорхой сэдвээрх өргөн хүрээний үүрэг хариуцлагын багцыг удирдахын тулд төсөлд хэрэгжилтийн эхний 2 жилийн хугацаанд 6 “үйл ажиллагааны менежер” шаардлагатай. Хэрэгжүүлэх чиг үүргийг аажмаар дотоодын хэрэгжүүлэгч түншүүдэд шилжүүлснээр эдгээр менежерийн тоо буурна. Хоёр жилийн дараа гэхэд 5 менежер, 3 жилийн дараа энэ тоо 4 болон буурч, төслийн 4 дэх жилийн дараа дунд шатны менежментийн 3 ажилтан үлдсэн байна. Төслийн 4 дэх шат дуусах буюу төгсгөлийн үе шат эхлэх үед Төслийн Үндэсний зохицуулагч, Олон улсын зөвлөхийг оруулаад ТБУТ-ийн ТЗН нь бүтэн цагаар ажиллах 5 ажилтантай байна. Төслийн нарийн бичиг, нягтлан бодох, жолооч нь 4 дэх үе шат хэрэгжих бүх хугацаанд шаардлагатай байх болно.

²⁷ Төслийн багийн бүх гишүүд мэдэж байх ёстой (Жендэр, ХЭСХ, төслийн менежмент, мониторинг) ерөнхий асуудал хариуцсан “удирдах мэргэжилтэн” томилогдохгүй. Учир нь үүрэг хариуцлагыг тодорхойгүй болгоно.

7. Хөрөнгө нөөц

7.5 Хөрөнгө нөөцийг тодорхойлох нь

Төслийн хэрэгжилтийг Монгол, Швейцарь Улсууд хамтран санхүүжүүлнэ. Монголын талаас Төсөлд оруулах хөрөнгийг Монголын талаас оролцогч талууд (хамтрагч, түнш, үр шим хүртэгсэд) захиран зарцуулна. Швейцарийн оруулж буй хөрөнгийг ШХА хариуцан зарцуулна. Талууд өөрсдийн тус тусын дотоод журмын дагуу эдгээр хөрөнгийг захиран зарцуулна.

7.6 Төсөвт оруулах хувь

7.6.3 Швейцарийн талаас оруулах хувь

ШХА-аас Төслийн 4 дэх үе шатны хэрэгжилтийн 4 жилийн хугацаанд 6.0 сая шв.франктай тэнцэх хөрөнгө оруулна.

Төсөл нь үр шим хүртэгсэд, хамтрагч болон түншүүдэд зөвлөх үйлчилгээ, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх ба энэ зорилгын үүднээс хүний нөөцөд голчлон анхаарна. Тоног төхөөрөмж, дэд бүтэц зэрэг техник хөрөнгө оруулалт нь тэргүүлэх чиглэл биш бөгөөд гагцхүү Монголын талын чадавхийг бэхжүүлэхэд л шаардлагатай бол энэ зорилгоор хөрөнгө зарцуулна. Энэхүү төсөв нь төсөлд оруулж буй Швейцарийн талын нийт хөрөнгө оруулалт юм. Бүрэлдэхүүн хэсэг бүрээр хуваарилсан нь илэрхийлэл төдий юм.²⁸

28 Зарим зардал нь бүх бүрэлдэхүүн хэсэгт хамаатай бөгөөд зарим нь захиргааны зардалд зарцуулагдана. Жнь: Төслийн дээд удирдлага 3 бүрэлдэхүүн хэсэг болон Захиргааны зардалд хяналт тавина. БУ-н алтын

	Бүрэлдэхүүн хэсэг 1	Бүрэлдэхүүн хэсэг 2	Бүрэлдэхүүн хэсэг 3	Захиргаа	Нийт
Шв.франк	2,338,675	1,476,875	1,650,640	533,810	6,000,000
%	39%	25%	28%	9%	100%
	2015 он	2016 он	2017 он	2018 он	Нийт
Шв.франк	1,542,598	1,508,930	1,507,037	1,441,435	6'000,000
%	26%	25%	25%	24%	100%

7.6.4 Монголын талаас оруулах хувь

ТБУТ нь Монгол Улсын Засгийн газраас УУЯ-аар дамжуулан ШХА-т илэрхийлсэн эрэлт, хэрэгцээнд хариулж байна. Монголын талаас бэлэн бусаар оруулж буй хөрөнгийн хэмжээ 1,040,000 Шв.франк²⁹ байх ба үүнд:

- 520,000 Шв.франк — УУЯ, түүний харъяа агентлагууд төслийг баталсны дараа гарын үсэг зурж баталгаажуулах хоёр талын гэрээний дагуу хүлээсэн
- 120,000 Шв.франк — орон нутгийн засаг, захиргаанаас
- 400,000 Шв.франк — үр шим хүртэгсэдээс

Төслийн бүх түнш талууд өөрсдийн оруулж буй хөрөнгийн тус тусын захиргааны зарчмын дагуу захиран зарцуулна.

Бэлэн болон бэлэн бус хөрөнгө	2015 он Шв.франк	2016 он Шв.франк	2017 он Шв.франк	2018 он Шв.франк	Нийт Шв.франк
УУЯ, түүний агентлагууд	130.000	130.000	130.000	130.000	520.000
Орон нутгийн Захиргаа	30.000	30.000	30.000	30.000	120.000
Үр шим хүртэгсэд	100,000	100,000	100,000	100,000	400,000
Нийт	260.000	260.000	260.000	260.000	1,040.0000

7.6.5 Гуравдагч талын оруулах хөрөнгө

Бүрэлдэхүүн хэсэг 3-т Монгол, Швейцарь Улсуудын төсөлд оруулах хөрөнгийг нэмэгдүүлэхийг зорино. Бүрэлдэхүүн хэсэг 3 нь БУ-н мэдлэг, туршлага үйл ажиллагаанд тулгуурлан шууд бус буюу санал санаачлага гаргах хэлбэрээр оруулах хувь нэмэр болон тодорхой хэмжээгээр хамтарч санхүүжүүлэх үндсэн дээр хамтран

нийлүүлэлтийн сүлжээний менежментийн асуудлаарх Ази, Номхон далайн бүсийн Бага хурал нь бүрэлдэхүүн хэсэг 2-ийн үйл ажиллагаа гэж харагдах боловч бүрэлдэхүүн хэсэг 3-ийн суралцах үйл ажиллагаанд мөн хамааралтай. Үүнтэй холбоотойгоор, бүрэлдэхүүн хэсэг бүрийн төсвийн хуваарилалт нь субъектив шалгуурт үндэслэсэн бөгөөд заавал дагаж мөрдөх ёстой гэсэн үг биш.

29 Тооцсон ханш 1 ам.доллар = 0.95 Шв.франк

үйл ажиллагаа хэрэгжүүлнэ. Эдгээр оруулж буй хөрөнгийг төслийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцох боломжгүй боловч чухал ач холбогдолтой нь тодорхой юм. Бусад төсөл санаачлагын хүрээнд хуримтлуулсан мэдлэг нь БУ-н салбарын хэрэгжүүлсэн туршлагатай адил байна. Мэдлэгийн төвийн бусад санаачлагатай хамтарсан үйл ажиллагаа нь төслийн менежментийн тодорхойлсон боломжид үндэслэх бөгөөд зохих санхүүжилтээр хэрэгжиж, төслийн үр нөлөө болон дэлхий бусад улс оронд хүрэх боломжийн харилцан хөшүүрэг болно.

7.7 Зардал-үр ашгийн дүн шинжилгээ

ТХН-ээс ТЗН болон өөрчлөх нь зардлын асуудалд нөлөөлнө. Төслийг өөрөө хэрэгжүүлдэг байдлаас улс орны тогтолцоонд уялдуулан шилжүүлэх нь төслийн үр дүнг тогтворжуулах, төслийн ажилтнууд хэрэгжилтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог багасгана гэж үзсэн. Гэвч, үүний тулд төслийн гол цөм агуулгыг үргэлжлүүлэх, хэрэгжүүлэх болон хяналт-шинжилгээ хийхэд түнш байгууллагуудын ажилтнуудыг эрчимтэй сургах шаардлагатай (Жнь: төслийн ажилтнууд дадлагажуулах замаар тухайн ажлын байран дээр түр ажиллан сургах). Цаашлаад хамтрагч талын туршлага багатай ажилтнууд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эхэндээ үр дүн багатай байж болзошгүй.

Төслийн хамрах хүрээг асуудлын болон газарзүйн хувьд өргөжүүлэх нь нэмэлт хоёр бүрэлдэхүүн хэсгийг бий болгож, төслийн хэмжээг томруулах болно. 3 дахь үе шатны "БУ-н бодлого" ба "БУ-чдыг дэмжих" гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэн 4 дэх үе шатанд нэг бүрэлдэхүүн хэсэг болгосон (Бүрэлдэхүүн хэсэг 1: Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих) нь төслийг нэг бүрэлдэхүүн хэсгээр нэмэгдүүлж, өөр хоёр бүрэлдэхүүн хэсгийг (Бүрэлдэхүүн хэсэг 2: Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээг эдийн засгийн хувьд бэхжүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 3:

Мэдлэг, туршлага солилцох) нэмэх боломжтой болгож байна. Бүрэлдэхүүн хэсэг 3 нь де факто шинжтэй, дэлхийн бусад улс оронд хүрч ажиллах гэдэг утгаараа энэ нь төслийн хэмжээг 2 фактораар өргөжүүлнэ гэсэн үг.

Төслийн хэмжээг нэмэгдүүлэхэд Швейцарийн талаас оруулж буй хөрөнгийн хэмжээг маш багаар нэмэгдүүлэн зардлыг бууруулах, зардал-үр ашгийн хэмнэлтийг боломжтой болгоно. Төслийн хэмжээг 2 фактороор нэмэхийн тулд (өөрөөр хэлбэл 200%) төслийн дунд шатны менежментийн ажилтнуудыг 5 байсныг 6 (өөрөөр хэлбэл 120%) болгон нэмэх³⁰ боловч бодит зардлыг 40% бууруулна. 4 дэх үе шатны Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн шууд төсөв (2,338,675 шв.франк) нь 3 дахь үе шатны Бүрэлдэхүүн хэсэг 1+2 –ын шууд төсөв (3,700,000 шв.франк)-тэй харьцуулахад де факто 37% буурч байна. Нийт зардлыг нэмэгдүүлэх (4 жилийн дараа 4.5 сая шв.франкаас 6 сая шв.франк болгон 33% нэмэх) нь Монголын ДНБ-ний өсөлт (2010 онд 6.2 тэрбум ам.доллараас 2013 онд 11.5 тэрбум ам.доллар болж 85% өссөн)-тэй харьцуулахад ихээхэн бага юм. Энэхүү харьцуулалтын параметр нь төслийн төлөвлөлтийн явцад ашигласан зардал-үр ашгийн шалгуурт тодорхой тусгагдсан.

Төслийн зардал үр ашгийн харьцаа эерэг байна. 4 жилийн хугацаанд төсвийн хэрэгжилтэнд зориулж төсөвлөсөн Швейцарийн талаас оруулах 6 сая Шв.франк, Монголын талаас оруулах 1.04 сая Шв.франкийг зарцуулсанаар алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулж жилд 5 тонн алт тушаах боломжийг бүрдүүлж, Монгол банкны мөнгөний бодлогын хэрэгжилтэнд хувь нэмэр оруулж макро эдийн засагт жилд 200 сая Шв.франк оруулах боломжтой.

³⁰ Энэхүү нэмэгдэл нь төслийн хүрээ өргөсч байгаатай холбоотой эхний хугацаанд хамаарна. Төслийн түншүүд үүрэг, ажлаа шилжүүлэн авахын хэрээр төслийн дунд менежментийн ажилчдын тоо буурах буюу 2 дахь жилээс 5, 4 гэх мэтчилэн буурсаар төслийн сүүлийн жил 3 төслийн ажилчин үлдэнэ.

8. Эрсдлийн дүн шинжилгээ

8.1 Тооцоолол ба эрсдэл

Улс орны хэмжээний эрсдэл Монголын хувьд харьцангуй тогтвортой гэж үзэв.

Монгол орны улс төр, эдийн засгийн эрсдэл (бизнесийн орчин) нь дунд-өндөр түвшинд тогтвортой бөгөөд улс төрийн хүчирхийлэл бараг үгүй гэж үздэг. Ашигт малтмалын үнэ буурч, Хятадын эрэлт хэрэгцээ багассан, шинж тэмдэг нь илрээд буй “Голланд өвчин” нь эдийн засгийн уналтын томоохон эрсдлийг бий болгож байна. 2016 онд болох дараагийн сонгууль төслийн хэрэгжилтийн дунд үед болно. Сонгуулийн үр дүнгээс хамаарсан улс төрийн тогтолцооны аливаа өөрчлөлт нь төслийн дараагийн үе шатанд нөлөөлж (эерэгээр болон сөргөөр) болзошгүй.

БУ-н салбарын эрсдэл багассан. Саяхан батлагдсан Төрөөс Эрдэс баялгийн талаар баримтлах бодлогод БУ-н асуудлыг тусгасан нь БУ-н улс төрийн эрсдэл төслийн өмнөх үе шатуудтай харьцуулахад ихээхэн буурсан гэж болно. Монгол Улс Минаматагийн конвенцийг батлан нэгдэн орсноор БОНХАЖЯ-ны зүгээс БУ-н салбарын ахиц үр дүнг дэмждэггүй, эсэргүүцэх эрсдэл өмнөх үе шатныхаас багассан гэж болно. Алтны үнэ буурсан/зогсонги байдалд байх нь алтны халуурлын эрсдлийг багасгах бөгөөд БУ-н салбарын оновчтой цаг үед нэгтгэх боломжийг бий болгож байна.

Төслийн хувьд нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал, мэдлэг туршлага солилцох шинэ сэдэв, чиглэлээр оролцох эрсдэл бага. Эдийн засгийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг болон албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээ нь Ашигт малтмалын тухай хуулийн алтны худалдаатай холбоотой нэмэлт өөрчлөлт, БУ-аар олборлосон алтыг худалдан авах замаар Алтны улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилттой нийцэж байна. Бүрэлдэхүүн хэсэг 3 нь ДШҮ-ээр ШХА нь БУ-н салбар дахь цорын ганц хөгжлийн байгууллага байгаатай холбоотой дүгнэсэн эрсдлийн шууд хариу юм. Монголын оролцогч

талууд энэ сэдвийг хэр зэрэг анхаарахаас хамаарсан бага зэрэг эрсдэл байна.

8.2 Эрсдлийг бууруулах стратеги

ХЭСХ-д суурилсан төслийн төлөвлөлт ба хэрэгжүүлэлт нь хамгийн чухал хамгаалалтын шугам байна. Хүний эрхийн түгээмэл, салгашгүй байдал болон Монгол Улсын соёрхон баталсан олон улсын конвенци, мөн үүрэг хүлээгч ба эрх эдлэгчдийн тэнцвэртэй эрх мэдэлжүүлэх явдлыг чанд баримтлан хэрэгжүүлснээр эрсдлийг бууруулна. Жендэрийн асуудлыг төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөвлөлтийн бүх шатанд анхаарч тусгах нь жендэрийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдлийг үр дүнтэй бууруулах нөхцөлийг хангана.

Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээг эдийн засгийн хувьд бэхжүүлэхэд анхаарах нь эцэст нь “хууль бус наймаачидтай тэмцэх арга”-д хүрэх эрсдлийг бууруулж чадна. Энэ арга нь алтны өндөр хэлбэлздэг шинж чанараас шалтгаалсан тогтворгүй байдлаас гадна оролцогч талуудыг хууль бус ажиллагаанд илүү нэвтрэхэд хүргэх бөгөөд зөвхөн төсөл төдийгүй нийт ажилтнуудыг эрсдэлд оруулах юм.

Мэдлэг солилцох явдлыг саад, түвэг гэж үзэх эрсдлийг сайн туршлагаас суралцсаны дүнд гарч буй үр дүнг харуулах замаар бууруулна. Бүрэлдэхүүн хэсэг 3 нь бусад улсуудад хүрч ажиллаад зогсохгүй, Монгол Улс өөрөө олон улсын сайн туршлагаас суралцах үр шимийг хүртэнэ. Монголыг олон улсын БУ-н бусад бодлогын хэлэлцүүлгүүдтэй холбосноор улс орон өөрийн хүрсэн үр дүндээ эзэн байх явдлыг нэмэгдүүлж, улс төрийн нөхцөл байдал БУ-н эсрэг өөрчлөгдөх эрсдлийг ихээхэн бууруулна.

9. Хяналт-шинжилгээ ба үнэлгээ

9.1 Хяналт-шинжилгээ ба төслийн дотоод менежмент

Төслийг өөрөө хэрэгжүүлэхээ болиход хяналт-шинжилгээ маш чухал үүрэгтэй болно. Төслийг өөрөө хэрэгжүүлэх байдлыг (өмнөх үе шатуудад ТХН) төслийн хэрэгжилтийг түншүүдтэй хамтран болон тэднээр зохицуулах байдал руу (ТЗН) амжилттай өөрчлөхөд хяналт-шинжилгээ нь төслийн менежментийн хийх ажлын хамгийн чухал хэсэг болно. Өөрөө хэрэгжүүлэхэд зарим үйл ажиллагаа нь нийт үе шатны турш үргэлжилж буй мэт харагдах ба "өөрөө" гэдэг утгаараа ахиц дүнг гарах тухай бүр мэдэж байх явдлыг хангадаг (өөрөөр хэлбэл хяналт-шинжилгээ нь зөвхөн тайлагнах зорилгоор л хийгдэнэ). Нийт үйл ажиллагаа, эсхүл тодорхой багц үйл ажиллагааг (**ажлын багц**) төслийн түншүүдтэй тохирох, эсхүл бүр гэрээлэн гүйцэтгүүлэх замаар гэрээ болон бүтээгдэхүүнийг хамрах хүрээ, үргэлжлэх хугацааны хувьд нарийн тодорхойлох хэрэгтэй бөгөөд хяналт-шинжилгээ нь гарч буй ахицыг харж, хяналт тавихад маш чухал болдог (өөрөөр хэлбэл хяналтын үүрэгтэй).

Түнштэй хамтарч буюу тэднээр гүйцэтгүүлэх **"Ажлын багц"** бүрийг тусад нь төлөвлөж, хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ хийнэ. Үүнд хоёр шатлалтай хяналт-шинжилгээний бүтэц шаардлагатай болно:

- **Төслийн шатанд "Ажлын багц" бүрт хийх хяналт-шинжилгээг төлөвлөлтийн үеэс эхэлнэ.** Төслийн агуулгын хүрээн дэх холбогдох асуултууд болон хүлээгдэж буй үр ашгаас гадна (*Ажлын багц төслийн бүтээгдэхүүн, үр дүнд хувь нэмэр оруулах уу?*) ажлын багц бүрт төлөвлөлтийн явцад дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийнэ:
 - Хүний эрхийн ямар стандартыг хэрэгжүүлэх вэ?
 - Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгасан уу?

- Хэрэгжилтийн ил тод, хамрах байдлыг хэрхэн хангах вэ?
- Үүрэг хүлээгч болон эрх эдлэгчдийн идэвхтэй, чөлөөтэй, утга бүхий оролцоог хэрхэн хангах вэ?
- Ажлын багц нь эрх мэдэлжүүлэх болон хариуцлагын асуудлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн үү?
- Эмзэг бүлэгт нөлөөлж болзошгүй санамсаргүй сөрөг үр нөлөөнөөс хамгаалах аргыг төлөвлөсөн үү?

Ажлын багцын хяналт-шинжилгээний мэдээллийг төслийн ерөнхий хяналт-шинжилгээнд нэгтгэнэ.

- **Ажлын багцын түвшинд, үйл ажиллагааны холбогдох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хяналт-шинжилгээ хийнэ.** Энэ нь ТБУТ-ийн менежмент, төслийн түншүүдтэй хамтран хийх ёстой ажил. Шалгуур үзүүлэлт нь «SMART» (specific, measurable, attainable, relevant and time-bound) буюу (тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болох, уялдаатай, цаг хугацааны хувьд зохистой) байх ба гарч буй ахиц, үйл явцын чанар болон бүтээгдэхүүн болон үр дүнгийн түвшинд хувь нэмэр оруулж буй байдлыг хэмжиж үнэлнэ. ТБУТ-ийн дунд шатны менежмент нь ажлын багцын түвшин дэх хяналт-шинжилгээг хариуцна. Үйл ажиллагааны шинж чанараас шалтгаалан, "үйл ажиллагааны менежер" юм уу "удирдах мэргэжилтэн" шалгуур үзүүлэлтэд хамаатай өгөгдөл мэдээллийг олж авах, үнэлэх ажлыг хариуцна. ТБУТ-ийн дунд шатны менежерүүд төслийн дээд удирдлагад тайлагнана.

Шалгуур үзүүлэлтүүд гарч буй ахиц өөрчлөлтийг бүрэн хэмжихэд тохирч буй эсэхийг тогтоох зорилгоор хэрэгжилтийн эхний 6 сард багтаан шалгуур үзүүлэлт бүрт суурь түвшний үнэлгээ хийнэ. ТБУТ-ийн менежмент нь суурь түвшний өгөгдөл үнэлгээ хийх нь төслийн үйл ажиллагааны зайлшгүй нэг хэсэг байх явдлыг хариуцна.

«SMART» суурь түвшний өгөгдлийг үнэлэх боломжгүй тохиолдолд тухайн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрэхэд ахиц гарч буй эсэхийг үнэлэх боломжгүй болно.

Үр дүнд суурилсан ХШҮ-ний систем нь Төслийн салшгүй нэг хэсэг байх ба төсөл эхэлснээс хойш 6 сарын дотор энэ системийг бүрдүүлнэ. ХШҮ-ний системийг бүрдүүлэх эхний ажил нь төслийн шалгуур үзүүлэлт бүрийг үр нөлөө, үр дүн, бүтээгдэхүүний түвшинд суурь түвшинг тогтоох, шалгуур үзүүлэлт «SMART» байгаа эсэхийг тодорхойлох, зорилтот түвшинг бодитойгоор дүгнэж үзэх шаардлагатай.³¹ Төслийн шалгуур үзүүлэлтийг дахин хянаж Удирдах хороогоор батлуулах хэрэгтэй. ДШҮ-ний зөвлөмжид төслийн ХШҮ-ний чадавхийг бэхжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн, мөн ТЗН-д шилжиж буй бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор хяналт- шинжилгээний хувьд тавигдаж буй шинэ сорилтын дагуу ХШҮ-ний системийг³² бүрдүүлэхэд гадны зөвлөх үйлчилгээ хэрэгтэй болох ба цаашид зөвлөхийн дэмжлэгийг авч ажиллана. Хяналт-шинжилгээний үр дүн нь төслийн өөртөө хийх тодорхой хугацааны үнэлгээ болон Төслийн орчлын менежмент (төлөвлөлт, хяналт-шинжилгээ, дотоод үнэлгээ, үйл ажиллагаа болгох)-ээс хамаарна. Төслийн орчлын менежмент нь тайлагнах хугацаатай мөн нийцсэн байна.

• **Төслийн үйл явцыг хагас жил тутам тайлагнана.** Хагас жилийн тайлан нь бүтээгдэхүүний түвшинд анхаарах бөгөөд ТБУТ-ийн дээд удирдлага Төслийн Удирдах хороонд тайлагнана; илүү дэлгэрэнгүй жилийн тайлан нь бүтээгдэхүүн ба үр дүнгийн түвшинд анхаарах бөгөөд Удирдах хороонд батлуулахаар танилцуулна. Хяналт-шинжилгээний дүнд үндэслэн, өөртөө хийсэн үнэлгээний үр дүнг харгалзан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төслийн Удирдах хороогоор батлуулна.

Төслийн логик загварын эцсийн өөрчлөлт (үнэлгээний дүнг үйл ажиллагаа болгон тусгах хэрэгжүүлэх шаардлагатай)-ийг үр дүн болон бүтээгдэхүүний түвшинд боловсруулж, Удирдах хороогоор батлуулна. Түүнчлэн Төсөл тайланг тайлбарлан бичсэн байдлаар жил бүрийн намар ШХА-ийн Жилийн үйл ажиллагааны тайлан гарахаас өмнө ШХА-т гаргаж өгнө.

• **Түншүүдтэй хамтарч эсхүл тэднээр Үйл ажиллагааны түвшин дэх ахиц өөрчлөлтийг** (“ажлын багц”) товч байдлаар баримтжуулан төслийн үр дүнтэй удирдлагыг хангана.³³ ТБУТ-ийн дунд шатны менежментийн ажилтнууд нь түншүүддээ улирлын болон сарын тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх ба энэ хүрээнд хяналт-шинжилгээний өгөгдөл, өөртөө хийх үнэлгээ, үнэлгээний зөвлөмжийг үйл ажиллагаа болгох тусгах ажил хийнэ. Тайлан болон санал болгож буй өөрчлөлтийг ТЗН (ТБУТ-ийн дээд удирдлага) батална.

9.2 Үнэлгээ ба төслийн орчлын гадаад менежмент

Дотоод дунд шатны үнэлгээг хэрэгжилтийг хоёр дахь жилийн төгсгөлд (2016 оны сүүлийн улирал) хийх ба төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг идэвхтэй, чөлөөтэй, утга бүхий байдлаар баталгаажуулах болон/эсхүл шаардлагатай өөрчлөлт хийх боломжийг хангана.

Хөндлөнгийн үнэлгээг төслийн хэрэгжилтийн сүүлийн жилийн эхэнд хийх ба 2018 оноос хойших Төслийн эцсийн буюу хаалтын үе шатны төлөвлөлтийн нэг хэсэг байна.

31 4 дэх үе шатны төлөвлөлтийн явцад санал болгож байсан шалгуур үзүүлэлтийн суурь түвшний үнэлгээ нь хамрах хүрээ, цаг хугацааны боломжоос хэтэрсэн. Үүнтэй адилаар Логик загварын шалгуур үзүүлэлтийн зорилтот зарим түвшин нь төлөвлөлтийн багийн субъектив төсөөллөөс шалтгаалсан ба тэдгээр хүрч болох эсэхийг нотлох, SMART шинжийг тодорхойлох шаардлагатай.

32 ХШҮ-ний системийг ТБУТ болон ESEC II төслийн хоорондын уялдаа, хяналт-шинжилгээний давхардлаас зайлсхийхэд дэмжлэг үзүүлэхээр бүрдүүлэх хэрэгтэй. Түүнчлэн ШХА-ийн холбогдох бусад төсөл (ж.н БУ-гээр мэргэшүүлэх Мэргэжлийн боловсрол, сургалт, БУ-н бодлоготой холбоотой Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр зэрэг)

33 Тайлагнах давтамжийг ТБУТ-ийн дээд удирдлагаас үйл ажиллагааны шинж чанараас шалтгаалан тогтооно.

Хавсралт 1. Логик загвар

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Үр нөлөө (Үндсэн зорилго)	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт ¹		
Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын БУ-н салбар нь бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцан үр шимийг хүртэхийн хамт өөрөө хувь нэмэр оруулна.	- Гол 6 яамд нь БУ-н хууль, тогтоомж болон үйл ажиллагаандаа жендэр, хүний эрхийн стандартыг тодорхой тусгасан ба 3 дахь жилийн эцэст шаардлагатай эрх мэдэлтэй болсон байна. <i>Суурь түвшин: 2014: 0 Зорилт: 2018: 6</i> - Ашигт малтмалын нөөц ашигласны татвар болон албан ёсны гадаад валютын орлогод (FOREX) БУ-аас оруулж буй хэмжээ нэмэгдсэн байна (эдийн засгийн хөгжлийг үнэлэх)... <i>Ашигт малтмалын нөөц ашигласны татвар: Суурь түвшин 2014: 2 тэрбум төгрөг; зорилт - 2018: 6 тэрбум төгрөг Албан ёсны FOREX орлого: Суурь түвшин 2014: 60 тэрбум төгрөг, зорилт 2018: 400 тэрбум төгрөг</i> - Албан ёсны БУ-чдын 75%-ын орлого нь Төслийн 4 дэх үе шат дуусах үед нийт улсын дундажтай тэнцүү буюу илүү болсон байна. <i>Суурь түвшин 2013: Улсын сарын дундаж 627,200 төгрөг (100 хүртэлх тооны ажилчидтай байгууллагуудын хувьд); БУ-н сарын дундаж 2013: 352,000 төгрөг</i> - Монголын БУ-н орд дахь Байгаль орчны менежментийн талаар 10-аас доошгүй сайн туршлагыг хэвлүүлж, олон улсын хурал чуулганд танилцуулсан байна <i>Суурь түвшин 2014: 1 (Мөнгөн усгүй алт баяжуулалт) Жил бүрийн зорилт : 3</i> - ХЭСХ-ийг БУ-тай холбоотой үйл ажиллагаанд илүү өргөнөөр хэрэгжүүлсэн байна. - Монголд <i>Суурь түвшин: 2 (ТБУТ, БОХТОН) Зорилт 2018: 6</i> - Монголтой хамтран ажилласнаар олон улсын түвшинд <i>Суурь түвшин: 0 Зорилт 2018: 5</i>	- БУ-тай холбоотой гол яамдын хууль болон/эсхүл тогтоомжууд: - Уул уурхайн яам - Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам - Сангийн яам - Хөдөлмөрийн яам - Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, - Эрүүл мэнд, спортын яам - болон БУ-тай холбоотой асуудлыг хариуцдаг яамд - Хууль зүйн яам - Гадаад хэргийн яам - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам - Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам - Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яам - Шинэчилсэн хууль, тогтоомжийн жендэр, хүний эрхийн асуудлаарх дүн шинжилгээний тайлан - БУ-н алтны худалдаа, ашигт малтмалын нөөц ашигласны татварын талаарх ҮСХ-ны жилийн товхимол, Монгол банкны мэдээлэл, зэрэг ҮСХ-ны тоо мэдээлэл - ҮСХ-ны жилийн статистикийн мэдээ (Нэг хүнд ногдох орлого буюу/эсхүл ДНБ-ний талаар ҮСХ-ны тоо мэдээлэл) - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (Яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - Тайлангууд - Төслийн (тоо мэдээлэлд хяналт-шинжилгээ хийнэ: Монголын талын байгууллагуудаас бэлэн болон бэлэн бусаар оруулж буй хамтын ажиллагааны санаачлага) - Оролцогч талуудын - Мэдлэгийн төвийн сүлжээний мэдээлэл - ДШҮ болон 4 жилийн үнэлгээний нэг хэсэг болгон мэдлэгийн төвийн үр шимийг хүртэгсдээс судалгаа авна. - Жендэр, Хүний эрхийн талаар тодорхой үйл ажиллагаанд мэргэжилтний хийсэн дүн шинжилгээ	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт ²		Төсөөлөл ба эрсдэл
Үр дүн 1: Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа. БУ-н оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах талаарх төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр Хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын БУ-н бүх үйл ажиллагаа, асуудалд тусгасан байна.	- Төслийн 4 дэх үе шат хэрэгжиж дуусахад нийт БУ-чдын 50-аас доошгүй хувь албан ёсны болсон байна. 1. Суурь түвшин 2014: 5% (70%эрэгтэй: 30%эмэгтэй) 2. Зорилт: 2015: 10%; 2016: 20%; 2017: 30%; 2018: >50% - БУ-н Холбооноос хүний эрх/жендэрийн холбогдох стандартыг чухалчлан эрх мэдэлтнүүдэд албан ёсоор нөлөөлөхөөр гаргаж буй мэдэгдэл, хүсэлтийн тоо жил ирэх тусам нэмэгдэх Суурь түвшин 2014: 3 нөлөөллийн зорилгоор гарган хүргүүлсэн хүсэлт, мэдэгдэл (UPR, Төрөөс Ашигт малтмалын салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт) Зорилт: 2015 он: 12; 2016 он: 16; 2017 он: 18; 2018 он: 20 - БУ-чид нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдах нь жил ирэх тусам нэмэгдсэн байна. Суурь түвшин 2014: 4,200 (30%эм; 70% эр) Зорилт: 2015 он: 5500; 2016 он :7000; 2017 он: 8500; 2018 он:10,000 - Төсөл хэрэгжих хугацаанд БУ-н орд дахь гэмтэл, ослоос шалтгаалан хөдөлмөрийн чадвар, амь насаа алдсан тоо буурсан байна. Суурь түвшин 2014: хэлэлцэж байж тохирно Зорилт: Жил бүр 20%-аар буурна	- Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - АМГ-ын уул уурхайн кадастрийн мэдээллийн сан - БУ-н Үндэсний холбооны жилийн үйл ажиллагааны тайлан; өргөн барьсан тайлангийн хуулбар - ХЭҮК-ийн тайлан, холбогдох гэрээ бүхий байгууллагуудын тайлан - Жендэр, Хүний эрхийн талаарх мэргэжилтний дүн шинжилгээ - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - БУ-н орд, БУ-н ТББ-аас АМГ-ын БУ-н тасаг жил бүр түүвэр судалгаа авна. - Аймгийн түвшин дэх хөдөлмөр эрхлэлтийн албадаас бүртгэгдсэн гэмтэл, ослын талаар авсан тоо мэдээлэл - УУАА, АМГ-ын БУ-н тасаг, БУ-н ТББ, сумын эмнэлгийн тоо мэдээлэл	Төсөөлөл: Ашигт малтмалын тухай шинэ хуультай холбоотой гарах журмууд, БУ-д холбоотой зохицуулалт бүхий бусад хуулиуд нь уурхайчдын эрхийг хүндэтгэн хамгаалж, албажуулахад таатай байна. Эрсдэл: Бодлого боловсруулагчдын зүгээс дэмжих талаарх санал нь хэт өндөр босготой байх, үүнээс шалтгаалан эрхийг хэрэгжүүлэх бодит байдалд саад болох Эрсдэл: Эдийн засгийн уналтаас болж БУ-чдын тоо нэмэгдэх Төсөөлөл: АМГ-ын БУ-н тасал бие даан болон орон нутаг дахь хөтөлбөрүүдтэй хамтран түүвэр судалгаа хийхэд хангалттай дэмжлэг авах Эрсдэл: АМГ-ын БУ-н тасаг нь эрх мэдэл бий болоч ТБУТ-ийн анхны дэмжлэгтэйгээр ХШ-ний үр дүнтэй арга боловсруулсан ч ХШ хийхэд шаардлагатай санхүүгийн хангалттай нөөц авахгүй байх Төсөөлөл: Хөдөлмөрийн яамны аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчилнэ. Эрсдэл: Эдийн засгийн уналтаас болж БУ руу хошуурах

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт ²		Төсөөлөл ба эрсдэл
Үр дүн 2: Бичил уурхайн албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх: Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор БУ-аар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна.	- Орон нутаг дахь БУ-н ашигт малтмалын худалдааг албажуулахтай холбоотой Хүний эрхэд суурилсан прагматик зохицуулалтыг батлах <i>Суурь түвшин 2014: Орон нутаг дахь БУ-н ашигт малтмалын худалдааны ямар нэг зохицуулалт байхгүй</i> <i>Зорилт: 2015 он гэхэд батлуулах</i> - Албан ёсоор бүртгэгдсэн БУ-н алтны үйлдвэрлэл 0.5 т/а –аас доошгүй хэмжээгээр нэмэгдэнэ. <i>Суурь түвшин 2014: 0.98т/а</i> <i>Зорилт 2018: > 3.0 т/а</i> - Ашигт малтмалаас олсон орлогынхоо зарим хэсгийг бусад бизнес боломжид хөрөнгө оруулж буй албан ёсны болсон бичил уурхайчид, ченжүүдийн тоо 3 дахь жилийн эцэс гэхэд 2 дахин нэмэгдсэн байх ба тэдний гуравны нэгээс доошгүй нь эмэгтэйчүүд байна. <i>Суурь түвшин 2014: 87 уурхайчин (38% эр;62% эм)</i> - БУ-н салбараас хүний эрхэд суурилсан хувь нэмэр нь орон нутгийн засаг захиргааны эдийн засгийн бодлогоор дамжуулан эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүлээн зөвшөөрөх явдал нэмэгдсэн байна. <i>Суурь түвшин 2014:судалгааны зр дүнг харгалзан дараа тохирох</i> <i>Зорилт:</i> <i>2015 он: 2 аймаг: 4 сум</i> <i>2016 он: 4 аймаг: 8 сум</i> <i>2017 он: 6 аймаг : 12 сум</i> <i>2018 он: 8 аймаг: 20 сум s</i>	- Албан ёсны мэдээллийн товхимол - Жендэр, хүний эрхийн асуудлаарх дүн шинжилгээний тайлан - Мэдээллийг дараах эх сурвалжаас авна: - Монгол банк (худалдан авсан хэмжээ болон бүртгэгдсэн экспортын хэмжээ) - АМГ ба БУ-н Холбоо (Албан ёсны БУ-н үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ) - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - БУ-н орд, БУ-н ТББ, ченжүүдээс АМГ-ын БУ-н тасаг жил бүр түүвэр судалгаа хийнэ - Төслийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторинг хийх - Сумын удирдлагуудаас судалгаа, асуулгын үр дүнг авах. - Хүний эрхийн асуудлаарх мэргэжилтний дүн шинжилгээ ба БУ-н талаарх ойлголт - Суурь түвшингийн судалгааг 10-аас доошгүй аймаг, 50-аас доошгүй сумдаас эдийн засгийн хөгжлийн стратеги дахь БУ-н гүйцэтгэх үүргийн талаар судалгаа явуулна.	Төсөөлөл: МУЗГ нь Ашигт малтмалын талаар Төрөөс баримтлах бодлого хэрэгжүүлнэ Алтны худалдааны тогтолцоо одоогийн зах зээл дээрх талуудыг хамруулсан, боломж олгосон байх. Төсөөлөл: Худалдааны зохицуулалт нь ченжүүдийг албажуулах боломжтой байна Төсөөлөл: Монгол банк болон сорьцын лаборатори орон нутаг дахь худалдаанд гардаг техникийн хүндрэлийг шийднэ. БУ-н талаар олон нийтийн хэлэлцүүлгийг улс төрийн намуудын кампанит ажлын үеэр улс төржүүлэхгүй байна.

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт ²		Төсөөлөл ба эрсдэл
Үр дүн 3: Мэдлэг харилцан солилцох, БУ-н талаарх олон улсын бодлогын хэлэлцүүлэг: Монгол Улсын оролцогч талууд БУ-тай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь БУ-н салбарт олон улсын түвшинд манлайлагч байна.	4-өөс доошгүй дотоодын болон мөн тооноос доошгүй олон улсын түншүүд Мэдлэгийн төвийн Монгол дахь үйл ажиллагаанд оролцох буюу дэмжиж, 3 дахь жилийн эцэс гэхэд олон түвшинд ажиллана. <i>Суурь түвшин 2014: 0 Жилийн зорилт: жил бүр 2 дотоод; 2 олон улсын түнш</i> - БУ-н чиглэлээрх төслүүд тайлан/судалгаа зэргийг ТБУТ-ийн Мэдлэгийн төвийн вэб хуудас зэргээр дамжуулан харилцан солилцох явдал жил ирэх тусам нэмэгдэх ба Монголын БУ-н төслийн талаар бичиж буй түнш вэб хуудасны тоо жил ирэх тусам нэмэгдэнэ. <i>Суурь түвшин 2014: 1 НҮБ-ын БОХ-ийн Дэлхийн мөнгөн усны түшлэлд ТБУТ-ийн талаар бичсэн. 2015: 4 төсөл, 5 вэб хуудас 2016: 6:8 2017: 8: 10 2018: 10:12</i> 3 дахь жилийн эцэс гэхэд МУЗГ Мэдлэгийн төвийн оролцогч талуудтай хамтран ажилласны дүнд "хориглоод, хайхрахгүй орхих"-оос өөр бусад арга замаар мөнгөн усны нууц хэрэглээний асуудлыг шийдвэрлэхийн тулд БУ дахь мөнгөн усгүй бусад аргыг албан ёсоор зөвшөөрсөн байна. <i>(сургамж авах асуудалтай холбоотой ойролцоо шалгуур үзүүлэлт) Суурь түвшин 2014: 1 баяжуулах цехийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг зөвшөөрсөн</i> 4 дэх үе шатны төгсгөл гэхэд ШХА-ийн өөр улсад хэрэгжүүлж буй нэгээс доошгүй БУ-н өөр төсөл болон Монгол Улсад өөр хандивлагчийн БУ-н талаар хэрэгжүүлж буй 2-оос доошгүй төсөл ХЭСХ-ыг төсөлдөө тусган хэрэгжүүлэх ба энэ үйл ажиллагаанд ТБУТ-ийг чухал хувь нэмэр оруулагч гэж үзнэ. <i>Суурь түвшин 2014: 0 ШХА-ийн бусад улс хэрэгжүүлж буй БУ-н төсөл 0 Монгол дахь БУ-н төсөл</i>	- Түншлэлийн гэрээ, ХОСБ болон түүнтэй адилтгах, стратегийн баримт бичиг болон үйл ажиллагааны хөтөлбөр - ТБУТ-ийн Мэдлэгийн төв болон түнш вэб хуудасны үйл ажиллагаанд ТБУТ-ийн ажилтнууд хяналт-шинжилгээ хийнэ. - Монголын яамд, Засгийн газрын агентлагуудын стратегийн баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнтэй ижил төстэй тайлангууд - Төслийн баримт бичиг, ШХА болон бусад хандивлагчид, олон нийтэд нээлттэй бусад мэдээлэл	Төсөөлөл: Мэдлэг харилцан солилцох явдал нь шийдвэр гаргагчдад мөнгөн усыг хориглосноор хэрэглээ нууц хэлбэрт шилждэг талаарх бусад улсын туршлагаас суралцан, ойлгох боломж олгоно.

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл	
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал	Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ³		Төсөөлөл ба эрсдэл	
Үр дүн 1-ийн хувьд: Хүний эрхэд суурилсан БУ-н бодлого ба БУ-чдыг дэмжих үйл ажиллагаа. БУ-н оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр Хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын бичил уурхайн бүх үйл ажиллагаа, асуудалд тусгасан байна.				
Бүтээг-дэхүүн 1.1	Хуульчлах ба албажуулах: Төслийн түнш болон хамтрагч эрх бүхий байгууллагууд БУ-н холбоотой дүрэм, журмуудыг хүний эрхийн асуудлыг тодорхой тусган шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.	- БУ-н талаарх шинэ/шинэчилсэн журмуудад хүний эрх, жендэрийн асуудлыг тодорхой хүлээн зөвшөөрч, эхний жилийн эцэс гэхэд төрийн үйлчилгээ хүргэхэд засгийн газрын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байна. <i>Суурь түвшин: 0</i> - БУ болон ХЭСХ-тай холбоотой асуудлаар чадавхийг нь бэхжүүлсэн төв болон орон нутгийн засгийн газрын ажилтнуудын тоо <i>Суурь түвшин 2014: засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны 120; Зорилт: засгийн газар болон орон нутгийн захиргааны ажилтнууд: жил бүр 100-аас доошгүй.</i>	- Албан ёсны товхимол: БУ-н журам - Шинэчилсэн журмууд дахь Жендэр ба Хүний эрхийн талаарх мэргэжилтний дүн шинжилгээ - Төслийн жилийн үйл ажиллагааны тайлан	Шаардлагатай дүн шинжилгээ хийх боломжтой холбогдох мэдлэг мэдээлэл/нөөц
Бүтээг-дэхүүн 1.2	Эрх мэдэлжүүлэх: Бичил уурхайчид, тэдний төлөөллийн байгууллагуудын эрхээ хамгаалах, шаардах, нөлөөлөхтэй холбоотой чадавхийг бэхжүүлэх	- Өөрсдийнх нь эрхийн төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулж буй аргыг тодорхойлж чадах 20-оос доошгүй БУ-н ТББ дахь эрэгтэй, эмэгтэй гишүүдийн харьцаа 2дахь жилийн эцэс гэхэд хоёр дахин нэмэгдсэн байна. <i>Суурь түвшин 2015: судалгааны дараа хэлэлцэн тохирно</i> 2 дахь жилийн эцэс гэхэд 20-оос доошгүй БУ-н ТББ болон нэгжүүд БУ-н Холбоонд төлбөрөө төлдөг болсон байна <i>Суурь түвшин 2014: 3 БУ-н ТББ 12 сарын хугацаанд бүрэн төлсөн; 12 БУ-н ТББ 1-6 сарын хугацаанд төлсөн</i> <i>Зорилт: 2 дахь жилийн эцэс гэхэд 20-оос доошгүй БУ-н ТББ болон нэгжүүд БУ-н Холбоонд төлбөрөө төлдөг болсон байна, 4 дэх үе шат дуусахад 30 болсон байна.</i> - Хүний эрхийн асуудлаар эрх мэдэлтнүүдэд БУ-н байгууллагуудаас гаргаж буй нөлөөллийн үйл ажиллагааны мэдэгдэл, хүсэлт жил бүр нэмэгдсэн байна <i>Суурь түвшин 2014; 5 мэдэгдэл, хүсэлт</i> <i>Зорилт: 2015 он:10; 2016 он: 20; 2017 он: 30; 2018 он: 40</i>	- БУ-н ТББ-ын сургалтын тайлан - Бичил уурхайн нэгдсэн судалгаа (цаашид ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - АМГ-ын БУ-н тасгаас хийсэн БУ-н орд болон БУ-н ТББ-ын талаарх жилийн түүвэр судалгаа. - БУ-н Холбооны санхүүгийн тайлан - ХЭҮК-ийн тайлан мэдээ. - БУ-н ТББ болон БУ-н Холбооны тайлан	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал	Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээг- дэхүүн 1.3	Мэргэшүүлэх болон хариуцлагын тогтолцоо: Зохицуулалт, харилцаа холбоо, чадавхийг бэхжүүлэх тодорхой бүтэц, үйл явцыг гол байгууллагуудад тогтоож, БУ-н мэргэшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх - Мэргэжлийн уч чадвар хөгжүүлэх сургалтын жендэр, хүний эрхийн асуудлыг мэдрэмжтэй тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулан, 2 дахь жилийн эцэс гэхэд БУ-н орд бүхий газар 1-ээс доошгүй МСҮТ-ийн сургууль батлан хэрэгжүүлсэн байна. <i>Суурь түвшин 2014: 0; Зорилт 2016: 1</i> 3 дахь жилээс хойш туршилтын МСҮТ-үүдэд БУ-н мэргэжлээр ур чадвар эзэмшиж, дүүргэж буй эрэгтэй, эмэгтэй уурхайчдын тоо <i>Суурь түвшин: 0 Зорилт: жил бүр 3 курст нийт 15-аас доошгүй хүн суралцахаас 5-аас доошгүй нь эмэгтэй хүн байна.</i> 3 дахь жилийн эцэс гэхэд Засгийн газрын гол байгууллагуудын чиг үүрэгт (АМГ, БУ-н тасаг ХЯ гэх мэт) БУ-н тусгай мэргэжилтэй холбоотой тодорхой үүргийг тусгасан байна. <i>Суурь түвшин: 0 2015 он: Засгийн газрын 2 байгууллага 2016 он: 4 2017 он: 6 2018 он: 8</i>	- Мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг баталсан байна. - Сургалтын хөтөлбөрийн төсөлд жендэр, хүний эрхийн асуудлыг хэрхэн тусгасанд хийсэн дүн шинжилгээний тайлан - Мэргэжлийн сургалт/гэрчилгээт хөтөлбөрийн талаарх ХОСБ, зөвшөөрөл ба тайлан - Жендэр, хүний эрхийн асуудлаар мэдрэмжтэй сургалтын хөтөлбөрийг батлах - Элсэн суралцсан байдал ба төгсөлтийн талаарх тайлан - Байгууллагын бүтэц, зохион байгуулалт. Ажилтнуудын нэрсийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолт	Төсөөлөл: АМГ-ын БУ-н тасаг бие даан болон орон нутаг дахь бусад хөтөлбөртэй хамтран түүвэр судалгаа явуулахад хангалттай дэмжлэг авсан байна. Эрсдэл: АМГ-ын БУ-н тасаг нь ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр хяналт шинжилгээ хийх аргачлал боловсруулсан ч мониторинг хийх санхүүгийн эх үүсвэргүй байх эрсдэлтэй. Төсөөлөл: Тодорхойлсон хэд хэдэн хувилбараас нэг түншийг сонгосон байна. Эрдсэл: Албан ёсны мэргэжлийн сургалтын системд БУ-н асуудлыг оруулах боломжгүй байх ба гэрчилгээнд суурилсан тусгай арга шаардлагатай болох.

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээгдэхүүн 1.4	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал ба тэгш эрх: Ажлын байрны аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн болон хүүхэд асрах үйлчилгээг сайжруулах талаар төслийн хамтрагч түншүүдийн хөтөлбөр	2 дахь жилийн эцэс гэхэд АМГ-ын БУ-н тасаг болон ЭМСЯ, ХАХНХЯ, ХЯ, ХЭҮК-ийн холбогдох газар хэлтсүүд ажлын байрны аюулгүй байдал, нийгмийн хамгаалал болон эрүүл мэнд, хүүхэд асрах үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар БУ-н үйлчилгээ хүргэх талаарх үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийг оролцооны аргаар боловсруулсан байна. <i>Суурь түвшин 2014: АМГ-ын БУ-н тасаг БУ-н асуудалтай холбоотой үйе ажиллагааны хөтөлбөр, төсөвтэй.</i> 3 пдахь жилийн эцэс гэхэд БУ бүхий нийт 50 сумд БУ-тай холбоотой өвчин, гэмтлээс урьдчилан сэргийлэх, оношлох болон эмчлэх аргаар бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтантай болсон байна. <i>3 Суурь түвшин 2014: 0 Зорилт: 2015:25; 2016:50; 2017:75; 2018:100</i> - Хүний эрхэд суурилсан БУ-н эрүүл ахуй болон аюулгүй ажиллагааны талаар сургалтад сууж, бэлтгэгдсэн эрэгтэй, эмэгтэй уурхайчдын тоо жил ирэх тусам нэмэгдэх <i>Суурь түвшин 2014: 6,000; Зорилт 2015: 7,000; 2016: 8,000; 2017:9,000; 2018: 10,000</i>	- Засгийн газрын холбогдох байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр ба төсөв <i>АМГ-ын БУ-н тасгаас БУ-н орд, БУ-н ТББ-уудын талаар хийх жилийн түүвэр судалгаа</i> - ЭМЯ, ДЭМБ-ын тайлангууд - АМГ-ын БУ-н тасгаас БУ-н орд, БУ-н ТББ-уудын талаар хийх жилийн түүвэр судалгаа - Нийтийн Эрүүл мэндийн сургуулийн тайлан - Төслийн жилийн үйл ажиллагааны тайлан - АМГ-ын БУ-н тасгаас БУ-н орд болон БУ-н ТББ-уудын талаар хийсэн жилийн түүвэр судалгаа	Төсөөлөл: АМГ-ын БУ-н тасаг бие даан болон орон нутаг дахь бусад хөтөлбөртэй хамтран түүвэр судалгаа явуулахад хангалттай дэмжлэг авсан байна. Эрсдэл: АМГ-ын БУ-н тасаг нь ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр хяналт шинжилгээ хийх аргачлал боловсруулсан ч мониторинг хийх санхүүгийн эх үүсвэргүй байх эрсдэлтэй. Төсөөлөл: ДЭМБ орон нутгийн эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэх хөтөлбөртөө БУ-н асуудлыг хамруулан тусгах. Эрсдэл: Хэрэгжилт төлөвлөсний дагуу явахгүй байх

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал	Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээгдэхүүн 1.5	Өргөдөл гомдол ба маргаан шийдвэрлэлт: Хүний эрх, ашигт малтмалын болон өмчийн эрхийн маргааныг шийдвэрлэх механизмыг олон улсын гэрээ, сайн туршлагад нийцүүлэн бүрдүүлэх - Эхний жилийн эцэс гэхэд жендэр, хүний эрхийн асуудалд мэдрэмжтэйгээр өргөдөл гомдол, маргааныг шийдэх мехназмд хийх үнэлгээг БУ-н Холбоо, ХЭҮК хамтран хийсэн байна. <i>Суурь түвшин 2014: Өргөдөл гомдол, маргаан шийдэх ямар нэг механизм байхгүй.</i> - Маргаан, өргөдөл гомдол шийдвэрлэх талаарх БУ-н холбоо болон ХЭҮК-ийн хамтран зохион байгуулсан албан ёсны сургалтад хамрагдсан БУ-н ТББ-ын тоо <i>Суурь түвшин 2014: 0 Зорилт: 2016: 10; 2017: 20; 2018: 30</i> - Төслийн энэ үе шатны эцэс гэхэд бүх аймаг дахь ХЭҮК-ийн ажилтнууд БУ-н сургалтад хамрагдан, БУ-н асуудлыг үр дүнтэй шийдэх аргыг тодорхойлж чаддаг болсон байна. <i>Суурь түвшин: 0 Зорилт: 2015: 25%; 2016: 50%; 2017: 75%; 2018: 100%</i>	- Үнэлгээний тайлан батлах - Сургалтын тайлан, нэрсийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолт - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - АМГ-ын БУ-н тасгаас БУ-н орд болон БУ-н ТББ-уудын талаар хийсэн жилийн түүвэр судалгаа - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - БУ-н байгууллагуудын хүрээнд БУ-н холбооноос хийх жилийн түүвэр судалгаа - Төслийн хүрээнд сургалтын өмнө болон дараа хийсэн асуулга	Төсөөлөл: АМГ-ын БУ-н тасаг бие даан болон орон нутаг дахь бусад хөтөлбөртэй хамтран түүвэр судалгаа явуулахад хангалттай дэмжлэг авсан байна. Эрсдэл: АМГ-ын БУ-н тасаг нь эрх мэдэл бий болоч ТБҮТ-ийн анхны дэмжлэгтэйгээр ХШ-ний үр дүнтэй арга боловсруулсан ч ХШ хийхэд шаардлагатай санхүүгийн хангалттай нөөц авахгүй байх.

Үр дүн 1-ийн Бүтээгдэхүүнүүдийн зардал: 2,338,675 шв.франк

Үр дүн 2: Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор БУ-аар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна. (*"Албан ёсны Нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх"*)

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээг- дэхүүн 2.1	Нийлүүлэлтийн сүлжээг албажуулах: БУ-н албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний хэрэгцээ шаардлага, хэлбэр, эрхзүйн болон санхүүгийн тогтолцооны талаар гол оролцогч талууд санал нэгтэй байх ба энэ талаар албан ёсоор арга хэмжээ авах.	- Нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудын хүсэл зорилго, үндэсний тэргүүлэх чиглэл, олон улсын сайн туршлагыг тусгасан БУ-н алтны зохицуулалтыг боловсруулж, эхний жилийн эцэс гэхэд батлуулсан байна. <i>Суурь түвшин 2014: Алтны худалдааны зохицуулалт байхгүй</i> - Арилжааны хувьд найдвартай алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах зорилгоор хийж буй Алтны нийлүүлэлтийн сүлжээн дэх үйл ажиллагаа (хувийн болон төрийн, хариуцлагатай зах) 4 дэх үе шатны эцэст 5 дахин нэмэгдсэн байна. <i>Суурь түвшин 2014 : 1 NTR metals Жилийн зорилт: 1</i> - Алтны худалдааны зохицуулалтын асуудлаарх уулзалтад оролцсон эрэгтэй, эмэгтэй уурхайчид, алтны худалдаа эрхлэгчид болон төр, захиргааны байгууллагын төлөөллийн 60-аас доошгүй хувь нь баталж гаргасан зохицуулалт нь хэрэгжиж болохуйц байна гэж үзсэн. <i>Суурь түвшин 2015: дараа хэлэлцэн тохирно</i> - Орон нутгийн 1-ээс доошгүй худалдаа эрхлэгч этгээд БУ бүхий аймаг, сумдын хувьд дараах байдлаар бүртгэгдэн, байгуулагдсан байна: <i>Суурь түвшин 2014: 0 дахь жилийн эцэс гэхэд: 5 аймаг, 5 сум 3 дахь жилийн эцэс гэхэд: 15 аймаг, 30 сум 4 дэх жилийн эцэс гэхэд: БУ бүхий бүх аймаг, БУ бүхий нийт сумдын 80%</i>	- Албан ёсны товхимол: БУ-н алтны зохицуулалт - БУ-н алтны зохицуулалтын талаарх мэргэжилтний дүн шинжилгээ - Уулзалтын протокол - Уулзалтын дараа оролцогчдоос авсан асуулга - Зөвлөлдөх уулзалтын тайлан - Бүртгэлийн байгууллагын тоо мэдээлэл (дараа тохирон тогтооно) - Зохицуулалтын асуудлаарх уулзалтын өмнө ба дараа хийсэн санал асуулга	Төсөөлөл: Төслийн түншүүд нь албан ёсны алтны нийлүүлэлтийн сүлжээний эрх зүйн болон санхүүгийн тогтолцоог шийдэх чадамж бүхий эрх мэдэлтэй этгээд байна.

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии	Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал	Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээг- дэхүүн 2.2	Нийлүүлэлтийн сүлжээний уян хатан байдал: Бичил уурхайчид албан ёсны, хариуцлагатай, эдийн засгийн хувьд ашигтай нийлүүлэлтийн сүлжээнд орсон байна. - Орлогын албан татвар болон нийгмийн даатгалаа төлдөг эрэгтэй, эмэгтэй БУ-чдын тоо жил ирэх тусам нэмэгдэнэ. <i>Суурь түвшин 2014: 4,200 (30% эм; 70% эр); Жилийн зорилт 2015-17: 1,450 Нэгдсэн зорилт 2018: 10,000</i> - Албан ёсны, хариуцлагатай уурхайн сургалтад хамрагдсан нийт уурхайчид болон худалдаачдын 80 гаруй хувь нь үйл ажиллагаагаа албажуулж, 90 гаруй хувь нь үйл ажиллагааныхаа эдийн засаг, нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээ авсан байна. Эдгээрийн гуравны нэгээс доошгүй нь эмэгтэйчүүд байна. <i>Суурь түвшин 2014: Сургалтад хамрагдсан уурхайчдын 20% of 30% эмэгтэй) Target: жил бүр 20% (30% эмэгтэй)</i> 3 дахь жилийн эцэс гэхэд Сорьцын үндэсний төвөөс гэрчилгээжүүлсэн лабораториар БУ-чид хүрч үйлчлүүлэх явдал 30 хувь, 4 дэх жилийн эцэс гэхэд 50 хувь болсон байна. <i>Суурь түвшин 2014: 216 уурхайчин болон хуладаачид</i>	- Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - АМГ-ын БУ-н тасгаас ченжүүд болон БУ-н ТББ-уудын талаар хийсэн жилийн түүвэр судалгаа - Үндэсний хэмжээний БУ-н талаарх судалгаа (яваандаа ҮСХ хийнэ; Суурь түвшин 2015, зорилт 2018) - АМГ-ын БУ-н тасгаас ченжүүд болон БУ-н ТББ-уудын талаар хийсэн жилийн түүвэр судалгаа - АМГ-ын уул уурхайн кадастрийн мэдээлэл - Гэрчилгээт лабораторийн дүн мэдээ	Төсөөлөл: АМГ-ын БУ-н тасаг бие даан болон орон нутаг дахь бусад хөтөлбөртэй хамтран түүвэр судалгаа явуулахад хангалттай дэмжлэг авсан байна. Эрсдэл: АМГ-ын БУ-н тасаг нь ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр хяналт шинжилгээ хийх аргачлал боловсруулсан ч мониторинг хийх санхүүгийн эх үүсвэргүй байх эрсдэлтэй.

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээгдэхүүн 2.3	Эдийн засгийн сонголт ба эрх чөлөө: Уул уурхайтай холбоо бүхий бизнесийн янз бүрийн загваруудыг БУ-н ТББ-уудад хүргэнэ.	2 дахь жилийн эцэс гэхэд 5-аас доошгүй БУ-н ТББ, төслийн энэ үе шатны эцэс гэхэд 10 ба түүнээс дээш БУ-н ТББ бизнес нэгж болон өөрчлөгдсөн байна. <i>Суурь түвшин 2014: 0</i> - Төслийн энэ үе шатны эцэс гэхэд 3-аас доошгүй БУ-н байгууллага хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний санаачлагын гэрчилгээтэй болж, (Шударга олборлолт, шударга худалдаа, BGI, RJC-тай адил) бүтээгдэхүүнийхээ зарим хэсгийг гадаад руу экспортлоно. <i>Суурь түвшин 2014: 0</i> - Үйл ажиллагаа нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа уул уурхайн компаниуд бичил уурхайчдад баяжуулах хүдрээ эдийн засгийн хувьд ашигтай байдлаар компанид зарах санал тавина. <i>Суурь түвшин 2014: 0</i> <i>Зорилт: жил бүр 1</i>	- Төслийн тоо мэдээлэл - Төслийн тоо мэдээлэл БУ-н байгууллагын гэрчилгээний статусыг хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний санаачлагаас хэвлүүлнэ. - Уурхайчид, худалдаа эрхлэгчдийн бизнесийн уян хатан байдлын суурь түвшний үнэлгээ ба дараагийн жил бүрийн үнэлгээний тайлан	
Бүтээгдэхүүн 2.4	Орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх: БУ-н байгууллагууд болон худалдаа эрхлэгчид орон нутгийн амьжиргааг сайжруулах, эдийн засгийг өргөжүүлэх, амьдрах чадвартай болгоход оруулах хувь нэмрээ нэмэгдүүлэх чадавхитай болж, оролцогч талууд энэ хувь нэмэр, үр дүнгийн талаар мэддэг болсон байна.	2 дахь жилээс 500 гаруй уурхайчид, ашигт малтмалын худалдаа эрхлэгчид БУ-н бизнесийн сургалтад хамрагдсан буюу төгссөн байх ба тэдний гуравны нэгээс доошгүй нь эмэгтэйчүүд байна. <i>Суурь түвшин 2014: 48 уурхайчин (38% эр, 62% эм), 0 худалдаа эрхлэгчид</i> - Эрэгтэй, эмэгтэй уурхайчид болон ашигт малтмалын худалдаа эрхлэгчдээс эдийн засгийн бусад салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын нийт хэмжээ жил ирэх тусам 20 хувиар нэмэгдэнэ. <i>Суурь түвшин 2015: Судалгаа хийж, үр дүнгээс хамааран тогтооно</i> - БУ-аас хамааралтай аймгуудын эдийн засгийн өсөлт нь улсын дунджаас 40-өөс доошгүй хувиар өндөр байна. (аль ч жилд) (жишээ нь улсын эдийн засгийн өсөлт 10% байвал БУ бүхий сумын өсөлт 14% байна). <i>Суурь түвшин 2014: 2015 онд хэлэлцэн тогтооно.</i>	- Дамжааны талаарх статистик - Уурхайчид, худалдаа эрхлэгчдийн бизнесийн уян хатан байдлын суурь түвшний үнэлгээ ба дараагийн жил бүрийн үнэлгээний тайлан (сонгон авсан 10 суманд БУ-н орлогын төрөлжсөн байдал, хөрөнгө оруулалтын асуулга хийх замаар хийнэ) - Сум, аймгийн захиргаа болон ҮСХ-ны эдийн засгийн өсөлтийн талаарх тоо, мэдээ - Дараах шалгуурт үндэслэн БУ-аас хамааралтай аймгууд нь Баянхонгор, Дундговь, Дорноговь гэж үздэг: БУ-чдын тоо их, БУ-н ашигт малтмалын орд их, мал аж ахуйгаас өөр эдийн засгийн бусад үйл ажиллагаа хомс	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Үр дүн 2-ын бүтээгдэхүүнүүдийн зардал: 1,476,875 шв.франк				
Үр дүн 3: Монгол Улсын оролцогч талууд БУ-тай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд бататгах; Монгол Улс болон ШХА нь БУ-н салбарт олон улсын түвшинд манлайлагч байна. (<i>Мэдлэг, туршлага солилцох, БУ-н талаарх олон улсын бодлогын хэлэлцүүлэг</i>)				
Бүтээг- дэхүүн 3.1	Мэдлэгийн менежмент ба түгээх: Сайн туршлагын мэдлэгийн төвийн үйл ажиллагаа эхэлсэн байна.	- Монголын болон олон улсын БУ-н талаар олон хэл дээр бэлтгэгдсэн вэб хуудас эхний жилийн эцэс гэхэд бий болсон байна. Вэб хуудсыг ТБУТ эсхүл түнш байгууллага хариуцан ажиллуулна. <i>Суурь түвшин 2014: байхгүй</i> - Мэдлэгийн төвийн урт хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж, эхний жилийн эцэс гэхэд хэрэгжүүлж эхэлсэн байна. - Мэдлэгийн төвийн вэб хуудасны агуулга, бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо, нэрээ нууцалсан зочин хэрэглэгчид, Мэдлэгийн төвийн вэб хуудасны линкүүд төслийн 4 дэх үе шатны эцэс гэхэд улирал тутам нэмэгдсэн байна	- Мэдлэгийн төвийн вэб хуудас биет байдлаар бий болсон байна - Төслийн жилийн үйл ажиллагааны тайлан - Мэдлэгийн төвийн бизнес төлөвлөгөөний баримт бичиг - Серверийн талаарх статистик мэдээ	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт ³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээг- дэхүүн 3.2	Сайн туршлага хуваалцах: Монголын оролцогч талууд үндэсний болон олон улсын түвшинд харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллаж бичил уурхайн талаарх мэдлэг туршлага, ур чадвараа солилцоно.	- Мэдлэгийн төв нь хоёр жил тутам нэгээс доошгүй олон улсын болон хоёроос доошгүй дотоодын суралцах арга хэмжээг зохион байгуулах ба зохион байгуулсан томоохон арга хэмжээний ихэнхэд нь хүний эрх, жендэрийн асуудлыг тодорхой тусгана. <i>Суурь түвшин 2014: 0 арга хэмжээ</i> - ТБУТ-ийн ажилтнууд, дотоодын хамтрагч түнш байгууллагуудын төлөөлөл БУ-н асуудлаарх Азийн болон бусад олон улсын 4-өөс доошгүй арга хэмжээнд оролцоно. <i>Суурь түвшин 2014: 1 арга хэмжээ</i> - ТБУТ-өөс гаргаж буй бүх нийтлэл нь Монгол хэл болон өөр хоёр дахь хэл дээр гарах ба олон нийтэд нээлттэй, зорилтот сургалтын байгууллагууд болон холбогдох хэрэглэгчдэд түгээгдэнэ. <i>Суурь түвшин 2014: ТБУТ-ийн вэб хуудас дээр нийтлэл, хэвлэгдсэн материалууд гол төлөв Монгол дээр тавигдсан</i> 3 болон 4 дэх жилээс эхлэн жил бүр хоёроос доошгүй дотоодын болон олон улсын эрдэмтэн болон, эсхүл оюутан ТБУТ болон төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар судалгаа явуулж, нэр хүндтэй сэтгүүл юмуу номонд хоёроос доошгүй нийтлэл хэвлүүлнэ. <i>Суурь түвшин 2014: 0</i>	- Уулзалтын тайлан ба нийтлэл - Төслийн үйл ажиллагаа, томилолтоор ажилласан тухай тайлан - Мэдлэгийн төвийн нийтлэл, хэвлэсэн материалууд вэб хуудас дээр нээлттэй байна. - Төслийн үйл ажиллагаа ба нийтлэх, хэвлэх материалуудтай холбоотой төлөвлөгөө	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээг- дэхүүн 3.3	Ижил төстэй байгууллагууд харилцан суралцах: Хөгжиж буй орнуудын бичил уурхайчид, зохицуулагчид болон БУ-тай холбоотой иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-ын харилцан суралцах сүлжээ бий болно.	- Монголын оролцогч талууд бусад оронд хийж буй танилцах аялал (оролцогчдын 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна) болон түүнээс суралцан авсан сургамжийг Мэдлэгийн төвийн сүлжээгээр дамжуулан дотоодын болон олон улсын хэрэглэгчдэд хүргэнэ. <i>Суурь түвшин 2014: 0 танилцах аялал</i> - Монголд өөр орны зохицуулагч, иргэний нийгэм болон/эсхүл уурхайчдын байгууллагын төлөөллийн танилцах аялал, айлчлалыг жил бүр зохион байгуулж, авсан сургамжийн талаар Мэдлэгийн төвийн сүлжээгээр дамжуулан танилцах аялал бүрээр гаргана. <i>Суурь түвшин 2014: 0 танилцах аялал</i> - Мэдлэгийн төв олон улсын хэмжээнд зөвхөн бичил уурхайчид оролцсон бага хурлыг 3 дахь жилийн эцэс гэхэд зохион байгуулах ба оролцогчдын 25-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.	- Хэвлэгдсэн танилцах аяллын тайлан - Хэвлэгдсэн танилцах аяллын тайлан - Бага хурлын тайлан	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээгдэхүүн 3.4	Үйл ажиллагааны тогтвортой байдал: Өмнө хүрсэн амжилт, цаашдын сорилтын талаар мэдээлэл, санал солилцох механизм бүрдэнэ.	- Орон нутгийн болон олон улсын хэрэглэгчдэд зориулсан БУ-н харилцаа, уялдуулан зохицуулах стратегийг эхний жилд боловсруулж, түүнээс цааш жил бүр шинэчилж байна. - Жендэр, хүний эрхийн хэрэгжилт зэрэг БУ-чдын хэрэгжүүлсэн сайн туршлагын талаарх олон нийтийн дунд зохиогдсон тэмцээн, шагнал гардуулах ёслолыг Засгийн газрын холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. <i>Суурь түвшин 2014: 0 шагнал гардуулах ёслол</i> - ТБУТ гадаадын дипломатууд, нөлөө бүхий хүмүүс, Засгийн газрын болон төрийн бус байгууллагын төлөөллийг БУ-н орд дээр жил бүр нэгээс доошгүй удаа очих ажлыг зохион байгуулна. <i>Суурь түвшин 2014: 2 айлчлал</i>	- Батлагдсан стратегийн баримт бичиг - Үр дүнгийн талаарх хэвлэл мэдээллийн материал болон нийтлэгдсэн материал - Төслийн баримт бичиг ба холбогдох мэдээлэл	

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратегии		Гол шалгуур үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж Нотолгооны арга	Гадны хүчин зүйл
Бүтээгдэхүүн (үр дүн тус бүрээр) ба зардал		Гарц буюу бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт³		Төсөөлөл ба эрсдэл
Бүтээгдэхүүн 3.5	Давтамж: Авсан сургамжийг олон улсын хэмжээнд дэлгэрүүлэн өргөжүүлэх механизмыг бүрдүүлнэ.	- Төслийн 4 дэх үе шатны эцэс гэхэд Монголын болон олон улсын ТБУТ-тэй хамтран ажилладаг мэргэжилтэн хариуцлагатай БУ, БУ-н хувь нэмэр, БУ-н оролцогч талууд хүний эрхийг хэрэгжүүлж буй эсэх асуудлын талаар олон улсын мэдлэг солилцох 10-аас доошгүй арга хэмжээнд илтгэл тавьсан байна. <i>Суурь түвшин 2014: 1 арга хэмжээ (ДЭМБ)</i> <i>Зорилт: жил бүр 3 арга хэмжээ</i> - Төслийн 4 дэх үе шатны эцэс гэхэд төслийн зүгээс хариуцлагатай БУ, БУ-н хувь нэмэр, БУ-н оролцогч талууд хүний эрхийг хэрэгжүүлж буй эсэх асуудлын талаарх мэдлэгийг сайжруулах зорилго бүхий олон улсын 5-аас доошгүй санаачлагыг дэмжинэ (бэлэн мөнгө болон бэлэн бус байдлаар). Хэрэв бэлэн мөнгөөр дэмжлэг үзүүлж буй бол үүнийг тохирох санхүүжилтийн хэлбэрээр өгнө. <i>Суурь түвшин 2014: 2 санаачлага</i> <i>Зорилт: жил бүр хоёроос доошгүй санаачлага</i> - Жил бүр бусад улс, газарт БУ-г дэмжих төсөл, хөтөлбөр дээр 1-ээс доошгүй сараар ажилтныг түр ажиллуулах (ТБУТ болон ижил төстэй төсөл, хөтөлбөр) ба БУ-н чиглэлээр 1-ээс доошгүй гадны ажилтыг ТБУТ-өөс урьж тэдний хөтөлбөр, төслийн судалгааны үр дүнг танилцуулж, ашиглана. (дотоод, гадаадын ажилтнуудын солилцооны санхүүжилт адил, нийцэж байх шаардлагатай.) <i>Суурь түвшин 2014: 0 ажилтныг солилцсон.</i>	- Жилийн тайлан - Илтгэлүүд Мэдлэгийн төвийн вэб хуудас дээр нээлттэй байна (Мэдлэгийн төв эсхүл зохион байгуулагчийн вэб хуудас дээр байршуулна) - Жилийн тайлан - Ажлын хэсгийн тайлан - Судалгааны тайлан	
Үр дүн 3-ийн Бүтээгдэхүүнүүдийн зардал: 3: 1,650,640 шв.франк				

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги	
Үйл ажиллагаа (Бүтээгдэхүүн тус бүрээр)	Орц
Бүтээгдэхүүн 1.1-ийн үйл ажиллагааны жагсаалт: 1.1.1: Гол салбарын оролцогч талуудтай тогтмол хамтран, зөвшилцөх замаар зохицуулалтын шинэчлэл хийх хэлэлцүүлгийг дэмжиж ажиллах. 1.1.2: Уул уурхайн яам, АМГ болон тэдний засгийн газрын хамтрагч байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах. 1.1.3: Засгийн газар, аймаг сумдын захиргааны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, тэдний хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах 1.1.4: Аймаг, сумдын захиргааны байгууллагуудыг үйлчилгээ хүргэх талаарх үүргээ албан ёсны болгоход дэмжлэг үзүүлэх. 1.1.5: Засгийн газрын гол чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог сайжруулахад санхүүжүүлэх механизмаар үйлчилгээ хүргэлтийн тогтвортой байдлыг дэмжих.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 1.2-ын үйл ажиллагааны жагсаалт:: 1.2.1: БУ-н Холбооны Хүний эрхэд суурилсан нөлөөллийн стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн болон бүсийн БУ-н байгууллага байгуулах чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. 1.2.2: БУ-н Холбоо, бүсийн болон орон нутгийн БУ-н байгууллагуудын тогтвортой байдлын үүрэг хариуцлагыг үр дүнтэй шилжүүлэх замаар дэмжиж ажиллана. 1.2.3: Залгамж байдал, жендэрийн эрх тэгш байдалд анхааран манлайлал, нөлөөлөл болон практик зохион байгуулалтын менежментийн ур чадварыг хөгжүүлэх явдлыг чиглүүлэх. 1.2.4: Орон нутаг, бүсийн болон олон улсын хэмжээнд бичил уурхайчдын хэлэлцүүлгийг зохион байгуулах явдлыг дэмжих.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 1.3-ын үйл ажиллагааны жагсаалт:: 1.3.1: Мэргэжлийн сургалтад хамрагдах боломжид үнэлгээ хийж, сайжруулах. 1.3.2: Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон хувийн салбарт гарааны цэгийг эрж хайх, тодорхойлох. 1.3.3: Микро, жижиг аж ахуйн нэгжийг хөгжүүлэхэд хэрэгжиж буй санаачлагад түшиглэх. 1.3.4: Мэргэжлийн болгон хөгжүүлэх үүргийг албажуулах явдлыг дэмжих.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 1.4-ийн үйл ажиллагааны жагсаалт:: 1.4.1: Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын кампанит ажлыг бэхжүүлэх 1.4.2: Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах хэрэгжиж буй хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх 1.4.3: Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар үүрэг хүлээгчдийн техник чадавхийг бэхжүүлж, шаардлагатай бол мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх 1.4.4: БУ-н олборлолтын талбай орчим хүүхэд асрах үйлчилгээний загварт үнэлгээ хийж, дэмжих. 1.4.5: Бүх үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг тусгасан байх, үүрэг хүлээгчдийн жендэрийн асуудлаарх чадавхийг сайжруулах.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 1.5-ын үйл ажиллагааны жагсаалт:: 1.5.1: Өргөдөл гомдол болон маргаан шийдвэрлэх оновчтой механизмыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх. 1.5.2: Үүрэг хүлээгчдийн шаардлагатай чадавхийг бэхжүүлэх. 1.5.3: БУ-н Холбоо, бүсийн БУ-н байгууллага, БУ-н ТББ-уудыг гишүүдийнхээ маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх явдлыг сайжруулах. 1.5.4: Хамтын ажиллагаа болон маргаан шийдвэрлэх сайн туршлагыг талаар онцлох	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги	
Үйл ажиллагаа (Бүтээгдэхүүн тус бүрээр)	Орц
Бүтээгдэхүүн 2.1-ийн үйл ажиллагааны жагсаалт: 2.1.1: Олон улсын сайн туршлагад үндэслэн бодит баримт нотолгоотойгоор нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаарх хэлэлцүүлгийг дэмжиж ажиллах. 2.1.2: Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээ нь Монгол Улсын макро эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулж болох талаарх олон нийтийн мэдээллийг сайжруулах замаар алтны албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний талаарх бодлогын хэлэлцүүлгийг дэмжих. 2.1.3: Нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудад арилжааны хувьд найдвартай, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан эрх зүйн болон санхүүгийн тогтолцооны талаарх нөлөөллийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх 2.1.4: Төрийн байгууллага, хувийн салбарынханд арилжааны хувьд найдвартай, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан БУ-н салбарын ашигт малтмалыг ихэнх хэсгийг худалдаалж байх боломжийг хангах талаарх эрх мэдлийг олгоход дэмжлэг үзүүлэх.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 2.2-ын үйл ажиллагааны жагсаалт: 2.2.1: Зах зээлд хүрэх өөр өөр зам, боломжийн төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад нь нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх. 2.2.2: Монгол Улсад нэмүү өртөг авчрах уламжлалт болон уламжлалт бус экспортын арга замыг, аргыг дэмжих. 2.2.3: Нийлүүлэлтийн сүлжээг албажуулах боломжтой хувилбарыг газар дээр нь турших ажлыг дэмжих.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 2.3-ын үйл ажиллагааны жагсаалт: 2.3.1: БУ-ыг байгууллага, худалдаачдад аж ахуйн нэгжийнхээ арилжааны найдвартай байдлыг сайжруулахын хамт байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулж, нийгмийн болон эдийн засгийн үр нөлөөг бэхжүүлэн, гарч болзошгүй гуравдагч этгээдийн сөрөг үр нөлөөг багасгах зорилготой оновчтой, чанартай сургалт явуулах явдлыг хангах. 2.3.2: Өөр өөр оролцогч талууд хариуцлагатай уул уурхайг хэрхэн хэрэгжүүлэх, БУ-н эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг хангах талаар хэрхэн ажиллахыг тодорхойлох, үнэлэх, дэмжих. 2.3.3: БУ болон том хэмжээний уурхайн хувьд харилцан ашигтай байх амжилттай “хамран ажилласан” жишээг түгээн, хэрэгжүүлэх, үргэжлүүлэх. 2.3.4: Ашигт малтмал боловсруулагчид болон худалдан авагчид (баяжуулах цех, ченжүүд, Эн Ти Ар зэрэг алт цэвэршүүлэгч нэгж, арилжааны банк болон бусад) алба ёсоор, хуулийн дагуу, найдвартай ажиллах чадавхийг бэхжүүлэх.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 2.4-ийн үйл ажиллагааны жагсаалт: 2.4.1: БУ-н эрхэлдэг өрх гэр, хүмүүс БУ-тай холбоотой нэмэлт өөр бизнес хийх бусад, боломжит хувилбарыг тодорхойлох, дэмжих. 2.4.2: БУ-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, БУ-чдад бизнесийн өөр нэмэлт боломж олоход дэмжлэг үзүүлэх талаар Германы хамтын ажиллагааны байгууллага буюу GIZ-тэй хамтран ажиллах. 2.4.3 Уурхайчид нийлүүлэлтийн сүлжээг хэрэгжүүлэгчдийн бизнесийн амжилтаа бататган, сайжруулах чадавхийг бэхжүүлэх ажлыг хэрэгжүүлэх. 2.4.4: БУ-г хөдөө орон нутгийн хөгжлийн бодлогод хэрхэн тусгаж буйд үнэлгээ хийх, ийнхүү тусгахад дэмжлэг үзүүлэх. 2.4.5: Гуравдагч талыг БУ нь хөдөө орон нутгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулж буй, БУ-н үр нөлөөг бодитой тогтоох үүднээс эерэг болон сөрөг үр нөлөөг аль алиныг тэнцвэртэй асуудлыг хангах асуудлаар харилцан адилгүй түвшинд (сумын, аймгийн болон улсын хэмжээнд) оновчтой, үр дүнтэй харилцааны сувгаар дамжуулан мэдээлэл олох, нийтлэх боломжоор хангах.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги	
Үйл ажиллагаа (Бүтээгдэхүүн тус бүрээр)	Орц
Бүтээгдэхүүн 3.1-ийн үйл ажиллагааны жагсаалт:: 3.1.1: Мэдлэгийн төв байгуулахад зөвлөгөө өгөх гадны зөвлөх үйлчилгээ авах. 3.1.2: Мэдлэгийн төв эхнээсээ төслийн хэрэгжих явцад болон дуусах хүртэл ямар эрх мэдэлтэй, ямар хэлбэртэй байхыг тогтоох. 3.1.3: Зардал хэмнэх боломж, санхүүгийн тогтвортой байдал, эзэмшлийн асуудал болон хэрэглэх эрх Үр дүн 1 ба 2-ын үйл ажиллагаа, Бүтээгдэхүүн 3.4-тэй холбоотой харилцааны стратегийн асуудлыг анхаарах зэргээр Мэдлэгийн төвийн бизнес төлөвлөгөөг боловсруулах. 3.1.4: Мэдлэгийн төвийн зохицуулагчийг ажилд авах, мэдээллийн бааз бий болгох 3.1.5: Сүлжээг байгуулж, суралцах, мэдээлэл солилцох болон харилцааны асуудлыг дэмжихад харилцан хамтарч ажиллах. 3.1.6: Мэдлэгийн төвийн гол чиг үүрэг, үйл ажиллагааг (хамтран) хэрэгжүүлэх боломжтой түншүүдийг тодорхойлж, хамтран ажиллах. 3.1.7 : БУ-н олон улсын болон Монголын БУ-н оролцогч талууд зэрэг өргөн хүрээнд Мэдлэгийн төв хэрхэн ажиллах, ямар хувь нэмэр оруулах, хэрхэн хэрэглэх, өргөжүүлэх, мэдлэгийн төвийн эзэмшлийн асуудлыг ойлгон, ийм төвөөр бахархах сэтгэл бий болгох явдлыг хангах	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 3.2-ын үйл ажиллагааны жагсаалт:: 3.2.1: БУ-н мэдлэг харилцан солилцох ажлыг хэрэгжиж буй санаачлагатай хамтран хуваах, холбогдох Монголын болон олон улсын оролцогч талуудын оролцоог дэмжих зэрэг гол боломжийг тэргүүлэх чиглэл болгох. 3.2.2: Олон улсын форум зохион байгуулах, Монгол Улс ямар асуудлаар сайн туршлагаасаа хуваалцах, эсхүл Монгол Улс ямар асуудлаар олон улсын сайн туршлагаас суралцаж болох талаар мэдээлэл хэвлэн нийтлүүлэх 3.2.4: Гадны оюутан, мэргэжилтнүүдийг Монголд ирүүлэх, Монголын талаас мөн оюутан эрдэмтэд гадагш зочлон Монголын БУ-н асуудлаар судалгаа хийх танилцах аяллыг дэмжих, үүний дүнд БУ-д сонирхолтой мэргэжилтнүүдийн мэргэжлийн хувьд хөгжих боломжийг дэмжих, нийтлэлийг хэвлүүлэх.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 3.3-ийн үйл ажиллагааны жагсаалт:: 3.3.1: Мэдлэгийн төв бичил уурхайчид, зохицуулагчид, ИНБ-ууд бусад хөгжиж буй орнуудын ижил төстэй байгууллага, хүмүүсээс суралцах явдлыг бэхжүүлэх механизмыг хэрхэн бүрдүүлэхийг тодорхойлох. 3.3.2: Нийтлэг туршлага, сорилт, эрх мэдэлжүүлэх болон сайжруулахын төлөө санаачлагатай ажиллах зорилгоор шийдэл олох талаар өөр орны бичил уурхайчдаас суралцах, мэдээлэл солилцохоор бичил уурхайчдыг нэг дор цуглуулахын тулд зөвхөн уурхайчид оролцсон бага хурал зохион байгуулах. 3.3.3: Монголын уурхайчид, зохицуулагчид, ИНБ-ынхан БУ бүхий өөр улсад харилцан зочлох ажлыг зохион байгуулах. Бусад орны уурхайчид, зохицуулагчид болон ИНБ-ын төлөөлөл Монголд боловсролын буюу харилцан суралцахаар ирэх ажлыг зохион байгуулах.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт
Бүтээгдэхүүн 3.4-ийн үйл ажиллагааны жагсаалт:: 3.4.1: БУ-н нөлөөнд өртсөн иргэд, олон нийт болон БУ-тай холбоотой үүрэг хүлээгчид (орон нутгийн захиргаа, их хурал, яамд)-д хүрч ажиллан БУ-н салбар хүрсэн Монгол Улсын амжилт (томоохон сорилт)-ын талаар үндэсний хэмжээнд таниулах стратеги боловсруулах. 3.4.2: Монголын тогтвортой БУ-н манлайлагчид болон бусад оролцогч талуудтай сургаж туршлагаа солилцох санаачлагын манлайлагчдыг шагнах шагнал гардуулах ёслолын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх 3.4.3: Монголын хүрсэн амжилт, хүний эрх болон жендэрийн холбоотой асуудлаар зэрэг олон улсын өргөн хүрээнд нөлөөлж болох өвөрмөц боломжийг тодорхойлох, эдгээр мэдээллийг олон улсад түгээх аргыг тодорхойлох. 3.4.4: БУ-н орд дээр гадны төлөөлөгчдийг аваачих, БУ-н арга хэмжээнд оролцуулах зэргээр Монголын өвөрмөц онцлогтой БУ болон хүрсэн амжилтын талаар танилцуулан сурталчлах.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт

Зорилгуудын дараалал Үйл ажиллагааны стратеги	
Үйл ажиллагаа (Бүтээгдэхүүн тус бүрээр)	Орц
Бүтээгдэхүүн 3.5-ын үйл ажиллагааны жагсаалт:: 3.5.1: Хариуцлагатай бичил уурхай, БУ-аас санхүүжих, болон БУ-н оролцогч талууд хүний эрхийг хэрэгжүүлэх зорилготой олон улсын санал санаачлагыг дэмжих 3.5.2: Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан БУ-н салбарыг хөгжүүлэхээр ажиллаж буй олон улсын түншүүдтэй хамтран ажиллах, харилцан суралцах ажлыг зохицуулах 3.5.3: Төслийн ажилтнуудыг солилцох, зөвлөгөө өгөх зэргээр БУ-н шинэ төсөл, санаачлагыг дэмжих. 3.5.4: БУ дахь ХЭСХ-ыг хэрэгжүүлж буй сургамж, туршлагыг системчлэх 3.5.5 : БУ-н Мэдлэгийн төв болон түүний түншүүд, Монголын болон олон улсын БУ-н талаарх санаачлагын тогтвортой байдлыг хангах санхүүгийн, улс төрийн болон нийгмийн капиталыг бий болгохын тулд БУ-н стратеги бодлогын түвшинд ажиллаж буй этгээдүүдийн үйл ажиллагааг зохицуулах механизм бүрдүүлэх.	ШХА ба хамтран ажиллаж буй байгууллагын санхүүжилт

Хавсралт 2. Төсөл/хөтөлбөрийн гол ажилтнууд, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт

Дээд удирдлага

Албан тушаал	Ажлын байрны тодорхойлолт
Төслийн захирал (1-2 дахь жилд)	Төслийн захирал нь стратегийн болон агуулгын хувьд ерөнхий удирдлага, Төслийн баримт бичиг болон Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр, ШХА-аас өгсөн удирдамжийн дагуу хэрэгжилтийн зохион байгуулалтыг хариуцна. Төслийн захирал нь БУ-н өндөр түвшний, гүн гүнзгий, онцлогт нийцсэн мэдлэг туршлага болон хандивлагчдын санхүүжилт бүхий БУ-н төслийг удирдан хэрэгжүүлэх болон олон улсын оролцогч талуудтай харилцах, бодлогын өндөр түвшинд ажиллах туршлагатай байх, энэхүү туршлагаа дотоодын оролцогч талууд, төслийн ажилтнууд ялангуяа төслийн Үндэсний зохицуулагчид дамжуулна. Дараах асуудлыг хариуцна. Үүнд: төслийн ерөнхий хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих, жендэр болон хүний эрхийн тэргүүлэх чухал асуудлыг тусгах зэрэг стратегийн болон агуулгын өөрчлөлтийг төсөлд оруулахаар санал гаргах, үр дүн болон бүтээгдэхүүний түвшинд хяналт шинжилгээ хийх, эрсдэл болон боломжийг тодорхойлох, дотоодын болон олон улсын хэлхээ холбоо, харилцааг бэхжүүлэх, мэдлэгийн төвийн болон холбогдох сүлжээний зохицуулалтыг дэмжих асуудал багтана. ШХА болон Удирдах хороонд ажлаа тайлагнана.
Олон улсын зөвлөх (3-4 дэх жилд)	Олон улсын зөвлөх нь төслийн Үндэсний зохицуулагч, ШХА болон Удирдах хороонд стратегийн болон агуулгын менежментийн асуудлаар зөвлөмж, зөвлөгөө өгнө Олон улсын зөвлөх нь БУ-н салбарын талаар олон улсын өндөр түвшний мэдлэг, туршлагатай бөгөөд БУ-н салбарын асуудлаар дээд түвшний шийдвэр гаргагчид болон олон улсын харилцааны хэлхээ холбоог бэхжүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллах чадвартай байна. Дараах асуудлыг хариуцна. Үүнд: Стратегийн болон агуулгын менежмент, хэрэгжилтийн талаар зөвлөн дэмжих, удирдамж заавар өгөх, мэдлэгийн төвийг хөгжүүлэхэд дотоодын болон олон улсын оролцогч талуудын хооронд шаардлагатай хэлхээ холбоо, харилцааг дэмжинэ. ШХА болон Удирдах хороонд ажлаа тайлагнана.

Төслийн Үндэсний зохицуулагч

Төслийн Үндэсний зохицуулагч нь төслийн менежмент болон үйл ажиллагааны хэрэгжилтийг Төслийн баримт бичиг, Удирдах хорооны шийдвэр болон ШХА-аас өгөх удирдамж чиглэлд нийцүүлэн хангах асуудлыг хариуцна.

Төслийн Үндэсний зохицуулагч нь төслийн ажилтнуудын хоорондын харилцааг удирдан, дэмжиж, уялдуулахын зэрэгцээ төслийг үр дүнтэй, үр ашигтай удирдах арвин туршлагатай байх, мөн зохицуулалт, захиргаа, төлөвлөлт ба хяналт-шинжилгээний асуудалд анхаарч ажиллана. Тэрээр төслийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ гээд бүхий л үйл ажиллагаанд жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон тусгасан байх явдлыг хангахад манлайлах үүрэгтэй байна.

Дараах асуудлыг хариуцна: төслийн хэрэгжилт, бүрэлдэхүүн хэсгүүд төлөвлөсний дагуу, уялдаатай, асуудалгүй хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих, төслийн бүтээгдэхүүний болон үйл ажиллагааны түвшинд төслийн түншүүдтэй хамтран зохицуулалт, хяналт-шинжилгээ хийнэ. Тэрээр төслийн хэрэгжилтийн дунд хугацаанаас эхлэн гарын үсэг зурах эрхтэй болох зэргээр аажмаар шийдвэр гаргах болон санхүүгийн менежментийн асуудлыг хариуцна.

Төслийн захиралд эхний 1-2 жилд харин 3-4 дэх жилд ШХА болон Удирдах хороонд үйл ажиллагаагаа шууд тайлагнана.

Эхний 1-2 жилд Төслийн захирлын орлогч байдлаар ажиллана.

Дунд шатны менежмент


Албан тушаал	Ажлын байрны тодорхойлолт
Гол үйл ажиллагааны менежер • УУЯ • АМГ • ХЭҮК • Иргэний нийгмийн байгууллагууд • Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгэн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд энэ нь ажлын нийт цагийн 75%-аас илүүгүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байх ба холбогдох асуудлаар мэдлэгийн төвийн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.

Албан тушаал	Ажлын байрны тодорхойлолт
Гол үйл ажиллагааны менежер • БУ-н Холбоо • БУ-чдын байгууллага • Дотоодын үйлчилгээ үзүүлэгчид • Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгээн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд энэ нь ажлын нийт цагийн 75%-аас илүүгүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байх ба холбогдох асуудлаар мэдлэгийн төвийн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.
Гол үйл ажиллагааны менежер • ХЯ • ЭМСЯ • ХАХНХЯ • БОНХАЖЯ • АБЭА-н дэд хороо • Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгээн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд энэ нь ажлын нийт цагийн 75%-аас илүүгүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байх ба холбогдох асуудлаар мэдлэгийн төвийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.

Албан тушаал	Ажлын байрны тодорхойлолт
Гол үйл ажиллагааны менежер - Монгол банк - Нийлүүлэлтийн сүлжээг ажиллуулагчид - Нийлүүлэлтийн сүлжээний санаачлагууд - Хувийн салбар - Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгээн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд энэ нь ажлын нийт цагийн 75%-аас илүүгүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байх ба холбогдох асуудлаар мэдлэгийн төвийн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.
Гол үйл ажиллагааны менежер - Аймгийн захиргаа - Сумын захиргаа - Орон нутагт үйлчилгээ хүргэгчид - Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. Орон нутгийн захиргаанаас гаргаж өгсөн ажлын байранд ажиллан (жишээ нь Баянхонгор), улс орны хэмжээнд орон нутгийн захиргааны байгууллагуудад хүрч ажиллана. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгээн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд өөрийн ажлын байранд ажиллах хугацаа нь ажлын нийт цагийн 75%-аас илүүгүй, орон нутгийн захиргааны ажлын байранд ажиллах хугацаа нийт ажлын цагийн 25%-аас багагүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байх ба холбогдох асуудлаар мэдлэгийн төвийн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.

Албан тушаал	Ажлын байрны тодорхойлолт
Гол үйл ажиллагааны менежер - Дотоодын болон олон улсын төслүүд, Мэдлэгийн төвд хамтран ажиллах түншүүд - Хэвлэл мэдээлэл - Эрдэм шинжилгээний байгууллага - Судалгааны байгууллага - Бусад	Өөрийн хариуцсан байгууллагуудтай харилцан ажиллана. Тавигдах шаардлага: Хоёр хэлийг бүрэн эзэмшсэн, хоёр дахь гадаад хэлтэй бол илүү давуу талтай байна. Харилцааны өндөр ур чадвартай. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. ТБУТ-ийн мэдлэг, туршлагыг хагас цагаар сэлгэн ажиллах байгууллагадаа дамжуулна. (Сэлгээн ажиллуулах цар хүрээг төслийн түншүүд тус бүртэй харилцан тохиролцох бөгөөд өөрийн ажлын байранд ажиллах хугацаа нь ажлын нийт цагийн 25%-аас илүүгүй байна.) Төслийн нийт үйл ажиллагаа болон хариуцсан байгууллагуудтай холбоотой төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны менежмент (тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилт, баримтжуулах, хяналт-шинжилгээ ба үнэлгээ, төслийг дуусгах)-ийг хариуцна. Тэрээр жендэр болон хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч, тусгах асуудлыг хангана. Төслийн захиралтай (1, 2 дахь жилд), Олон улсын зөвлөхтэй (3, 4 дэх жилд) нягт хамтран ажиллана. Төслийн Үндэсний зохицуулагчид үйл ажиллагаагаа тайлагнана. 1, 2 дахь жилд гадны түншүүдтэй холбоотой асуудлаар Төслийн захиралд тайлагнана. Өөрийн хариуцсан БУ-тай холбоотой чиглэлээр мэдлэг, туршлагаараа манлайлах мэргэжилтэн байна. Хариуцсан чиглэлээр БУ-н мэдлэг туршлагын хувьд дэд манлайлагч байдлаар ажиллана. Өөр нэг гол үйл ажиллагааны менежерийн орлогч байдлаар ажиллана.

Хавсралт 3. Төсөл хэрэгжих газарзүйн байршил



Хавсралт 4. Олон улсын БУ-н талаарх дэлгэрэнгүй үнэлэлт, дүгнэлт

Энэ Хавсралт нь 2.3 дахь хэсэгт дурдсан БУ-тай холбоотой дэлхий нийтийн чиг хандлага, сорилт, олон улсын бодлогын талаарх дүн шинжилгээ болон холбогдох гол баримт бичгийн ном зүйг агуулсан болно.

Уур амьсгалын өөрчлөлт, уламжлалт амьдралын хэв маяг, сайн сайхан байдал алдагдаж, эдийн засгийн шилжилтийн үе болон уналт, хямрал, ашигт малтмалын өндөр үнэ зэрэг нь БУ эрхлэгч хүн амын тоо 2 дахин нэмэгдэж, 15 жилийн хугацаанд дэлхийн нийт 30 сая хүн амыг хамрахад хүргэв.³⁴ Олон улсын хэмжээнд ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ өссөнд хөтөлгөдөн БУ-тай шууд холбоотой хүн амын тоо 6 саяаас 30 сая болж нэмэгдсэн нь 150 сая гаруй хүн энэ үйл ажиллагаанаас шууд бусаар хамааралтай болсон гэсэн үг. Дэлхийн нийт БУ-чдын тал орчим хувь нь алт олборлож буй бөгөөд алтны салбарын хөдөлмөр эрхлэлтийн 90 хувь, дэлхийн нийт алт үйлдвэрлэлийн 12-15 хувийг гаргаж, үүний гуравны хоёр нь Швейцарь Улсад цэвэршүүлж байна. Мөн хугацаанд энэ том өөрчлөлт гарсантай холбоотойгоор бичил уурхай болон түүнд оролцогч талуудын хүний эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой сорилт, боломжуудыг бий болгож байна.

Хүний эрхийг хамгаалах нь хэдийгээр бүрэн зохицуулагдахад хол байгаа ч БУ-н салбарын засаглалын гол асуудал болж байна. Жон Рагги-ийн 2011 онд гаргасан Хамгаалах, Хүндлэх, Засаж сэргээх тогтолцоо болон НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн талаарх тулгуур зарчмууд нь хувийн салбарт ажиллаж буй этгээдүүдийн хүний эрхийг ханган хэрэгжүүлэх явдлыг Засгийн газрын үүрэг, бизнес эрхлэгчдийн хариуцлага гэж тогтоосон. Бизнесийн хувьд, Монголын БУ-чдын байгууллагуудын үйл ажиллагаа нь гуравдагч талын хүний эрхэд ямар үр нөлөө үзүүлж байгааг анхаарч авч үзэх ёстой бөгөөд Монголын төр НҮБНХ-т гарын үсэг нэгдсэний хувьд БУ-н оролцогч талуудын хүний эрхийг хангах хэрэгжүүлэхэд БУ-н салбарыг дэмжиж ажиллах үүрэгтэй байна.^{35, 36}

НҮБ-ын тулгуур зарчмуудыг үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөхөөр хүлээн зөвшөөрснөөр БУ-н боловсруулсан ашигт малтмалын гаралтай түүхий эд ашигладаг компаниудын хариуцлагатай эх сурвалжийн талаар маш их анхаардаг болов. Нийлүүлэлтийн сүлжээний зохистой ажиллагаа, ялангуяа ЭЗХАХБ-ын Зохистой ажиллагааны зааврыг хэрэгжүүлэх нь³⁷

34 Секкаторе, Ж. Ба бусад 2014: Бичил уурхайгаар олборлож буй алтны дэлхийн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох нь. Нийт байгаль орчны шинжлэх ухаан: <http://www.ncbi.nlm.nih.gov/pubmed/24867677> (25/7/2014).

1999 онд, Норман Женнингс БУ эрхлэгч хүн амын тоог 13 сая, түүнээс хамааралтай хүмүүсийн тоо 80-100 сая байна гэсэн тооцоог хийсэн. Женнингс, Н 1999: *Бичил уурхайчдын нийгмийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал*. Бичил уурхайн Нийгмийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх Гурван талт уулзалтын ярилцлагад бэлдсэн тайлан. Олон улсын хөдөлмөрийн алба, Женев хот: http://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/news/WCMS_007929/lang-en/index.htm#note1 (25/07/2014)

35 НҮБ ОНЧР 2011: Бизнес ба хүний эрхийн тулгуур зарчмууд. НҮБ-ын 'Хамгаал, Хүндэл, Засч сэргээ' тогтолцоог хэрэгжүүлэх: http://www.ohchr.org/Documents/Publications/GuidingPrinciplesBusinessHR_EN.pdf (25/07/2014).

36 Рагги, Р. 2008: Хамгаал, Хүндэл, Засч сэргээ: Бизнес ба хүний эрхийн тогтолцоо. Үндэстэн дамнасан корпораци болон бусад бизнес аж ахуйн нэгжүүд, хүний эрхийн асуудлаарх Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгчийн тайлан, Жон Рагги; 07/04/2008: <http://www.reports-and-materials.org/sites/default/files/reports-and-materials/Ruggie-report-7-Apr-2008.pdf> (25/07/2014).

37 ЭЗХАХБ 2013: ЭЗХАХБ-ын хямралд өртсөн болон эрсдэл өндөртэй газар нутгийн ашигт малтмалын хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний Зохистой ажиллагааны заавар: хоёр дахь хэвлэл: http://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/news/WCMS_007929/lang-en/index.htm#note1

одоо ашигт малтмалын хариуцлагатай эх сурвалжийн асуудлыг хангах, буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх стандарт үйл ажиллагаа болж байна. БУ-н салбарт хүний эрхийн зөрчил, байгаль орчинд хор хөнөөл учруулдаг эрсдэл өндөр байсаар байгаа тул эх сурвалжийн асуудал, ялангуяа БУ-чдаас авч буй ашигт малтмалын эх сурвалжид онцгой анхаарах болсноор зарим худалдан авагчид энэ салбараас хөндийрөх, дайжихад хүргэж байна. энэ нь Монголын хувьд нэг талаас ТБУТ болон БОХТОН төслийн хүрсэн амжилтад үндэслэн, нөгөө талаас бусад орнуудад БУ-г албажуулах талаар хүрсэн амжилтынхаа сургамжаас хуваалцах зэргээр хариуцлагатай БУ-н эх сурвалжийн байр сууринд тавих таатай боломжийг бий болгож байна.³⁸

Хариуцлагатай эх сурвалжийн санаачлага нь Монголын БУ-н салбарт боломжийг бий болгож байна. Шударга худалдаа³⁹, шударга олборлолтын⁴⁰ стандарт нь алт боловсруулж буй БУ-чдын байгууллагууд өргөн хүрээний эрсдлийн асуудлаар гүйцэтгэлд суурилсан стандартыг боловсруулах шаардлагыг мөрдөж буй эсэхийг гэрчилнэ. Хариуцлагатай үнэт эдлэлийн хорооны үйл ажиллагааны дүрэм⁴¹ болон Хяналтын стандартын сүлжээ⁴² нь БУ-н хариуцлагатай эх сурвалж болон БУ-чид орд дээр нь ажиллаж буй том хэмжээний уурхай ба БУ-чдын хоорондын харилцааны талаар тавигдах шаардлагыг тодорхойлсон. Швейцарийн Илүү сайн алтны санаачлага болон Solidaridad-ын Алтны хөтөлбөр⁴³ мөн БУ-н үйлдвэрлэгчдэд анхаарах болсон. Эдгээр санаачлагад Монголын уурхайчдыг мөн хамруулах боломжтой.

oecd.org/daf/inv/mne/GuidanceEdition2.pdf
(25.07.2014).

38 Ялангуяа ЭЗХАХБ-ын алтны нэмэгдлийн талаарх Хавсралт 1-д тусгасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд (дээрхээс харна уу).

39 Шударга худалдааны шошгын байгууллага 2013: Бичил уурхайгаар олборлосон алт болон холбогдох үнэт чулууны шударга худалдааны стандарт. Хувилбар: 08/11/2013: <http://wordpress.p20126.webspaceconfig.de/wp-content/uploads/2014/04/Gold-and-Precious-Metals-from-Artisanal-Mining-Standard-EN.pdf> (25/07/2014).

40 Хариуцлагатай Уул уурхайн холбоо 2014: Бичил уурхайгаар олборлосон алт, мөн үнэт металлын шударга олборлолтын стандарт. Хувилбар 2.0, April 2014: http://www.communitymining.org/images/sampledData/EstandarFairmined/Fairmined%20Std%20%200_2014%20ENGLISH.pdf (25/07/2014)

41 RJC 2013: Үйл ажиллагааны дүрэм: http://www.responsiblejewellery.com/files/RJC_Code_of_Practices_2013_eng.pdf (25/07/2014).

42 RJC 2012: Хяналтын стандартын сүлжээ: http://www.responsiblejewellery.com/files/S002_2012_RJC_CoC_Standard_PM.pdf (25/07/2014)

43 Solidaridad 2014. Тогтвортой алт: <http://www.solidaridadnetwork.org/gold>. (25/07/2014)

БУ-н Зохистой ажиллагаа нь дан ганц БУ-аас худалдан авч буй этгээдийн бус түүнчлэн том уурхайд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчдын асуудал юм. Санхүүгийн хөрөнгө оруулагчид (Олон улсын Санхүүгийн корпораци, банк, хөрөнгө оруулалтын компани зэрэг) болон уул уурхайн салбарын нийгэмлэгүүд (Канадын Өмчийн хөгжлийн нийгэмлэг, Ашигт малтмал, металлын Олон улсын зөвлөл зэрэг) БУ-г том уурхайн ашиг болон уян хатан байдлын хоорондын чухал эрсдэл байдлаар авч үзэх болсон. БУ болон том уурхайн хоорондын харилцаа нь эрэл хайгуулын болон нөөцийн хувьд хязгаарлагдмал, цаашдын уурхайн үйл ажиллагаа тодорхойгүйгээс БУ-чидтай эхлэн харьцах шаардлагатай болдог шинэ тутам компаниудын хувьд маш чухал. Энэ хандлага нь том уурхайн компаниуд өөрийн эзэмшлийн орд дээр БУ-чидтай үр дүнтэй хамтран ажиллахыг дэмждэг ба энэ асуудлыг Монголд хуульд тусган дэмжиж байна.


Нэг талаас, сүүлийн арван жилд ашигт малтмалын өсөлтөөс шалтгаалж уул уурхайн компаниудын эрэл хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо ихээр нэмэгдсэнээр бичил уурхайчид шахагдаж БУ-чид олборлох эрхгүй газар ажиллах явдал газар авсан. БУ нь ур чадвараа өөрчлөх, эсхүл өөрсдийн бүтээмж, орчин, байгаль орчинд нөлөөтэй байдлаар ажиллахад хүрэх таагүй орд руу нүүхэд хүрдэг. ОУСК-ийн Тогтвортой байдлын тогтолцоо баримт бичгээ 2012 онд дахин хянаж, бичил уурхайчдын эрхийг хамгаалах талаар нааштай зарим эхлэл тавигдсан боловч БУ-том уурхайн харилцаан дээр тэдний эрхийг хамгаалахад амжилт гаргасан тохиолдол дэлхийн хэмжээнд маш цөөн гэж болно. БУ-том хэмжээний уурхайн харилцааг *хамтран оршин байх* гэх бус харин *хамтран ажиллах* гэсэн талаас нь авч үзэх болсон нь чухал зөв алхам бөгөөд Монгол Улс энэ тал дээр шинэ эхлэлийг тавиад байна.

Олон улсын хэмжээнд БУ-н салбарыг албажуулах, мөнгөн усны хэрэглээний менежмент, улмаар энэ хэрэглээг устгах асуудал анхаарлын төвд байсаар байна. Хятад, Конго, Мозамбик, Колумб, Перу зэрэг улсуудад сүүлийн үед хийгдэж буй эрх зүйн болон бодлогын түвшин дэх арга хэмжээ, Монголын хувьд БУ-н салбар дахь сайн засаглалын асуудлаарх сайн, муу аль аль туршлагаас харилцан сурч солилцох боломж байна. БУ-г албажуулах талаарх үйл ажиллагааг эрчимжүүлэх томоохон алхам 2013 оны 10 дугаар сарын 10-нд Минаматагийн

конвенцийг баталж, Японы Кумамото хотод гарын үсэг зурахаар болсон явдал юм. Өнөөгийн байдлаар Монгол зэрэг 100 гаруй улс гарын үсэг зурсан ба хамгийн анхны соёрхон баталсан явдал АНУ-д 2013 оны 11 дүгээр сарын 6-нд болсон.[□] Энэ конвенци нь БУ-н салбарт ч мөн адил мөнгөн усны ялгаруулалтыг хянах, хэрэв боломжтой бол бууруулах асуудлыг тусгасан. Засгийн газар хоорондын хэлэлцээний комиссын 3 дугаар уулзалтын үеэр оролцогч орнуудын Засгийн газруудыг мөнгөн усны хэрэглээг устгахад албажуулах асуудал чухал болохыг ШХА ятган ойлгуулж чадсан юм.[□]

Хариуцлагатай БУ-г дэмжих, боломжийг хангах нь хүүхдийн хөдөлмөр, хүүхэд хамгаалал, албадан хөдөлмөр эрхлэлт болон байгаль орчны нөлөөлөл зэрэг асуудлаар олон улсын түвшинд чухал асуудал байсаар байна.[□] Барууны орнуудын хууль тогтоомж болон хэвлэл мэдээлэлд боолчлол болон хүний наймааны талаар дахин анхаарах болсон нь албадан хөдөлмөр эрхлэлт (өрөнд хэт автагдах зэргийг оруулаад)-ийн асуудлыг БУ-н дүн шинжилгээ ба арга хэмжээний талаар дэлхийн хэмжээний шинэ “халуун сэдэв” болгож байна.[□] ТББ болон НҮБ-ын төрөлжсөн агентлагууд хамгаалалтын бүс нутагт БУ-г хэрхэн зохицуулах талаар анхаарч эхэлж буй нь тусгай хамгаалалттай газар нутагт олборлох үйлдвэр (БУ ороод)-ийг явуулах сайн туршлагыг тодорхойлох зорилгоор БХОУЗ-өөс 2014 онд зохион байгуулсан Өмнөд Африкийн хөгжиж буй улсуудын Засгийн газрын оролцсон арга хэмжээнээс харагдаж байгаа бөгөөд мөн БУ- РАСЕ хөтөлбөрийн хүрээн дэх ажлууд мөн үүний жишээ болно.[□]


Хавсралт 5. Оролцогч талуудын дүн шинжилгээ



Хөгжлийн зорилт

Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай хүний эрхэд суурилсан Монгол Улсын БУ-ын салбар нь бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцан үр шимийг хүртэхийн хамт өөрөө хувь нэмэр оруулах

Хавсралт 6 Шугаман логик загвар /Өөрчлөлтийн онол



Хавсралт 7. ТБУТ-ийн 4 дэх үе шат ба ШХА-ийн Хамтын ажиллагааны зарчмын харьцуулсан дүн шинжилгээ

Төсөл нь Швейцарийн олон улсын хамтын ажиллагааны болон Швейцарийн гадаад бодлогын хамтын ажиллагааны зарчимтай нягт уялдсан байна.⁴⁴ Тодруулбал,

- *“Хөгжилд хөтлөх бүтэц тогтолцооны нөхцөл, дэлхийн бодлогыг дэмжих”*: ХЭСХ-д онцгойлон анхаарах нь эрх мэдэлтнүүд болон иргэний нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлнэ. ТБУТ нь БУ-г хувийн салбар болон тэдний төлөөлөл болох төрийн бус байгууллагуудын нэг хэсэг гэж үзэх эрх зүйн таатай, шударга орчин бүрдүүлэхийг зорьсон. Ашигт малтмалын байгалийн шавхагдах нөөцийн тогтвортой менежментийг дэмжиж, байгаль орчны сайн туршлагын замаар ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжинэ.
- *“Хамгийн үр ашигтай байдлыг хангах”*: Эхэлснээсээ хойш ТБУТ нь олон улсын хамтын ажиллагааны үр шимийн эцсийн хүртэгсэд болох бичил уурхайчид болон тэдний гэр бүлийн амьжиргааны түвшинг сайжруулах талаар бодит үр дүн, сайжруулалтыг бий болгож чадсан байна. Төслийн 4 дэх үе шат нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдал, засаглал болон жендэрийн асуудлуудыг цогцоор нь авч үзнэ.
- *“Нэмүү өртөг шингээх, ноу-хау болон туршлага хөгжүүлэх, харилцан солилцох”*: Швейцарь Улс нь өөрийн хамгийн сайн мэддэг, туршлагатай асуудлаараа дэмжлэг үзүүлдэг. ШХА-ийн БУ-н салбар дахь өвөрмөц ноу-хау болон туршлага нь ДШҮ-ээр ШХА энэ чиглэлийн үйл ажиллагаагаа зогсоовол энэ ажил “нурж болзошгүй” гэж анхааруулсан. 4 дэх үе шат нь бүсийн, олон

улсын түвшинд мэдлэг харилцан солилцох замаар энэ асуудлыг аль болох өргөн хүрээгээр шийдэх юм.

- *“Харилцан хүндэтгэн түнш байдлаар ажиллах”*: Хариуцлагатай бичил уурхайчид болон таатай эрх зүйн орчин нь харилцан дэмжсэн байх орчлыг санаачлах замаар ТБУТ нь өмнө нь албан бус байсан БУ-н салбарт хууль, дүрэм дээдлэх ёсыг хэрэгжүүлсэн. Төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд ХЭСХ-ыг хэрэгжүүлэх замаар хүний эрхэд онцгойлон анхаарч, төслийн үр дүнг бэхжүүлнэ. БУ-н салбар, болон нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал нь оролцогч талуудын итгэлцлийн харилцааг бүрдүүлэх зорилготой.
- *“Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах”*: Эхэлснээсээ хойш, ТБУТ нь АМГ болон бусад эрх бүхий холбогдох төрийн байгууллагуудтай үндэсний болон орон нутгийн түвшинд нягт хамтран ажилласан. 4 дэх үе шатанд ХЭСХ-д онцгойлон анхаарахын хамт улс орны одоогийн системтэй төслийн уялдааг сайжруулахад анхаарсан нь төслийн үр нөлөөг сайжруулна гэж үзэж байна.
- *“Сайн засаглал”*: 4 дэх үе шат нь “хүний эрхэд суурилсан хандлага”-ыг илэрхий дэмжих эрх мэдэлжүүлэх хандлагыг дахин авч үзэх болно. ТБУТ-ийн 4 дэх үе шат нь бичил уурхайн зохицуулалтын тогтолцоо болон нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг дэмжих замаар сайн засаглалд хувь нэмэр оруулж, улмаар татвараас зайлсхийх, алтны хар зах зээл дээрх мөнгө угаах явдлыг бууруулна. Энэ хандлага нь ЭЗХАХБ-ын ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлын талаарх заавартай нийцэж байна.
- *“Эмэгтэй, эрэгтэй хүмүүс эрх тэгш байна”*: Швейцарийн ядуурлыг бууруулах зорилт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах

44 НҮББОХ, n.d.: Мөнгөн усны талаарх Минаматагийн конвенци – Улсууд: <http://www.mercuryconvention.org/Countries/tabid/3428/Default.aspx> (25/07/2014)

оролдлоготой нэгэн зэрэг хийгддэг. Жендэрийн тэгш байдлыг хангах асуудал ялангуяа бичил уурхайн салбарт маш чухал. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2013 оны судалгаагаар бичил уурхайчдын 30 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд гэр бүлийн бизнест эмэгтэйчүүд цалин авдаггүй явдал нэлээдгүй байсаар байна. Төсөл соёлын болон нөхцөл байдлын онцлогийг анхаарах боловч бүх шатанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдлыг хүчтэй дэмжих болно.

Imprint

Editor:
Sustainable Artisanal Mining project
Swiss Agency for Development and Cooperation SDC

Photos:
Swiss Cooperation Office Ulaanbaatar

Orders:
www.sdc.admin.ch/mongolia

Mongolia, January 2014